Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

Монгол Улсын хөгжлийн хувилбар: 2040

Нүүрсний ирээдүй

Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл | 2014 он. 2 сар. №04 (0562) | www.mongolianeconomy.mn



НҮҮРС ЭРГЭН ИРЭХ ҮҮ

COAL MONGOLIA 2014

НҮҮРСНИЙ САЛБАРТ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН 4 ДЭХ УДААГИЙН ОЛОН УЛСЫН ЧУУЛГА УУЛЗАЛТ, УЗЭСГЭЛЭН

2014 оны 2 сарын 20-21
SS CONVENTION CENTER
МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ

8 165800 067941 6

VERTUL

OFFICE FURNITURE
ART GALLERY



Италийн алдарт DOIMO группийн албан тасалгааны тавилгыг албан ёсны эрхтэйгээр нийлүүлж байна.

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их сургуулийн гудамж, 31/1 , PC MALL
Утас: 7711-3535, 9903-7487



УСНЫ ИНЖЕНЕРИНГИЙН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ:

(Уул уурхай, Эрчим хүч, Үйлдвэр, Хотын ус хангамж)

- Усны нөөцийн болон инженерингийн хайгуул судалгаа
- ТЭЗҮ, Техникийн төсөл, Ажлын нарийвчилсан зураг төсөл боловсруулах
- Ус хангамжийн болон усны барилга байгууламж барьж байгуулах, хянах
- Насос, яндан хоолой, хаалт зэрэг усны тоног төхөөрөмжийн ханган нийлүүлэлт, угсралт, туршилт, тохируулга

WATER ENGINEERING SERVICES:

(Water supply for Mining, Energy, Industry and City)

- Water resource investigation and survey (Geodesy and Geotechnical)
- Feasibility study, Basic and Detailed engineering design
- Construction and supervision of water supply system
- Supply, installation, and services for Pump, Valve and Pipeline



Water treatment, Purification
Ус цэвэршүүлэх, цэнгэгжүүлэх



Dewatering
Хөрсний усны түвшин доошлуулах



GRE Fiber Glass pipeline
Шилээр хүчитгэсэн хоолой



HDPE Liner Geomembrane

PRESTIGE ENGINEERING CO., LTD

Tel: 99113896, 99057240, 99035448, 313392,
E-mail: ganzorig@prestige.mn, bato@prestige.mn
Website: www.prestige.mn, watercenter.mn

Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.Бэхбаяр / 9999-4248

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.Отгонжаргал / 8800-6228

ЕРӨНХИЙ РЕДАКТОР:

Б.Цогзаяабаатар / 9919-0715

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:

Теренс Эдвардс

ОРЧУУЛАГЧ:

Р.Гантулга

СЭТГҮҮЛЧИД:

Б.Баяртогтох

Э.Зоригт

Х.Хулан

Б.Үүрийнтуяа

Б.Бямбадорж

С.Батзаяа

ДИЗАЙНЕР:

Ш.Оюундарь

ВЭБ МАСТЕР:

Н.Гал

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:

Д.Барианжав / 9409-2904

Д.Баттулга / 9409-2905

БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР:

М.Хишигтогтох / 9409-2906

“ECONOMY” TB СТУДИ

СЭТГҮҮЛЧ:

Ц.Соёлмаа

ЗУРАГЛААЧ:

Ш.Гантуул

КОМПЬЮТЕР ГРАФИКЧ:

Т.Баярсайхан

ХАЯГ:
Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг. VI хороо,
Их сургуулийн гудамж.
AB center. 503 тоот
15160 Улаанбаатар,
Төв шуудан, ш/ х-2762
www.mongolianeconomy.mn
info@mongolianeconomy.mn
Утас/Факс: 976 - 7011 5476
“Улаанбаатар принт” ХХК-д хэвлэв
www.ubprint.mn

2013 оны Шилдэг сэтгүүл









РЕДАКЦИД ЗАХИАЛБАЛ ХҮРГЭЛТ ҮНЭГҮЙ

MONGOLIAN ECONOMY

ОНЛАЙН СЭТГҮҮЛИЙГ

http://mongolianeconomy.imedia.mn/

АГУУЛГА

ЭДИЙН ЗАСАГ

10 Монгол Улсын хөгжлийн хувилбар: 2040

12 Дэлхийн эдийн засгийн чуулган: Монголын талаарх стратегийн шийдвэр

16 Цэнхэр сувдны үнэгүйдэл

19 Хар алтны салбар хариулт нэхэх цагаар

20 Нүүрсний ирээдүй

22 О.Чулуунбат: Уул уурхайн компаниудаа урагш алхуулах хэрэгтэй

24 Б.Алтсүх: Нэг цонхны бодлогоор нүүрсээ гаргах нь манайд ашигтай

26 БНХАУ-ын банкны салбар

27 Сахил хүртээд шал дордох вий

29 Хяналт хаана байна

31 Эдийн засгийн тогтолцоо, түүний төрлүүд

34 Эрчимтэй хөгжил хийгээд хамаарал

35 Арилжаагаа амжилттай эхлэх зөвлөмжүүд

38 Том тоглогчийн жижиг эрсдэл

БИЗНЕС

42 Мэдлэг, технологийн нутагшуулалт

44 Зөвхөн хэрэгцээтэйг нь хий

45 Хамгийн чухал 10 нээлт

“ECONOMY” ТВ СТУДИ

“УС ИРЖ БАЙНА” нэвтрүүлэг

Нэвтрүүлэх суваг: NTV телевиз

Нэвтрүүлэх цаг: 2014 оны хоёрдугаар сарын 18-ны 21.50 цаг

Ус ууж, хэрэглэж байгаа хүн бүхэн заавал үзэх ёстой нэгэн нэвтрүүлгийг Economy студи бэлтгэлээ.

“ХАР АЛТНЫ ЭРИН” нэвтрүүлэг

Нэвтрүүлэх суваг: NTV телевиз

Нэвтрүүлэх цаг: 2014 оны хоёрдугаар сарын 25-ны 21.50 цаг

Алтны жишигт үнэлэгдэж, дэлхийн анхаарлыг Монгол Улс руу чиглүүлж байгаа эрдэс бол НҮҮРС. Economy студи нүүрсний салбарт анхаарал хандуулж байна.

“MONGOLIAN ECONOMY” СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Б.БЯМБАСАЙХАН Монголын бизнесийн зөвлөлийн ТУЗ-ийн дарга, “Mongolian Economy” сэтгүүлийн Зөвлөлийн тэргүүн

Б.БОЛД “Рио Тинто” компанийн Зэсийн группын Олон улсын үйл ажиллагаа эрхэлсэн ерөнхийлөгч

С.БЭХБАТ ЭЗХЯ-ны Инноваци, төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга

Д.ЖАРГАЛСАЙХАН МІН группын ерөнхийлөгч

Ц.БАТСҮХ СЭЗДС-ийн Эдийн засгийн тэнхимийн эрхлэгч

Ж.СҮНЖИДМАА “Пийбоди Энержи” компанийн Монгол дахь хамтын ажиллагаа, олон нийтийн асуудал хариуцсан менежер

Б.ТҮВШИНТӨГС Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал

ХОЛБООС

facebook.com/Mongolian.Economy

twitter.com/EconomyMongolia

youtube.com/user/MongolianEconomy

Борлуулах цэгүүд:
“Интер ном”
“Цэцэг төв”
“Минж плаза”
“Алтантүлхүүр” номын дэлгүүр
“Номин” супермаркетийн бүх салбар
“Макс” супермаркетийн бүх салбар
“Фреско” супермаркет
BTSI супермаркет
“Аз орчлон” номын дэлгүүр
“Билэг” их дэлгүүрийн номын тасаг
“Гранд Плаза” дахь супермаркет
“Мир” номын дэлгүүрийн
“Grand plaza”
“Metro mall”
“Sky” супермаркет
“Улаанбаатар” их дэлгүүр дэх салбар
“Max mall” салбарууд

МОНГОЛД

Тайлан:



Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс “Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын тайлан” гаргажээ. Уг тайланд Монгол Улсын эдийн засгийн үзүүлэлтийг бүхэлд нь авч үзсэн байна. Тус тайланг хоёр дахь жилдээ бэлтгэн гаргаж байгаа юм. Манай улсын хувьд санхүүгийн системийн 95 хувийг банкны салбар дангаар бүрдүүлж буй. Тайланд санхүүгийн зах зээл нь хөгжлийнхөө эхэн үедээ байна хэмээн онцолжээ. Санхүүгийн тогтвортой байдлыг хангах асуудалд дан ганц мөнгөний бодлого, банкны салбарыг тойрсон асуудлаар хандах нь өрөөсгөл болохыг мөн тэмдэглэжээ.

Хөгжил:



Монголын эдийн засгийн форум ирэх сарын 24, 25-нд Төрийн ордонд болно. Дөрөв дэх жилдээ зохион байгуулах гэж буй эдийн засгийн чуулга уулзалтаар ухаалаг төрийн бодлого, бүтээн байгуулалт, хөгжлийн өмнө тулгамдаж буй асуудлыг голчлон хөндөх юм. Мөн энэ үеэр Дэлхийн эдийн засгийн форумаас гаргасан Монгол Улсын хөгжлийн хувилбаруудыг олон нийтэд нээлттэй хэлэлцүүлэх аж.

Мөнгөний бодлого:
Монголбанкны мөнгөний бодлогын зөвлөл энэ сарын 7-11-ны өдрүүдэд гурван удаа хуралдаж, бодлогын хүүг /10.5 хувь/ хэвээр үлдээх шийдвэр гаргалаа. Өнгөрсөн онд хоёр удаа бодлогын хүүгээ бууруулаад байсан төв банкны Мөнгөний бодлогын зөвлөл энэ удаа хүүг хөдөлгөх шаардлагагүй гэж үзжээ. Харин эдийн засгийг тогтворжуулах, тогтвортой өсөлтийг дэмжих Засгийн



газар, Монголбанкны хамтарсан дунд хугацааны хөтөлбөрүүдийн үр ашгийг дээшлүүлэхэд анхаарч ажиллах нь чухал хэмээн мөнгөний бодлогын мэдэгдэлд онцолжээ.

Бүтээн байгуулалт:
Барилгын салбарын үйлдвэрлэн өнгөрсөн онд 70 хувиар өссөн байна. Ингэснээр нийслэлд 20, орон нутагт долоо мянган айлын орон сууц ашиглалтад оржээ. Энэ онд шинээр 20 орчим мянган айлын орон сууц шинээр ашиглалтад орох аж. Монголбанкны Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд дуусаагүй орон сууцны барилгуудын санхүүжилтэд зориулж 97 компанид 430 тэрбум төгрөгийн зээл олгосны нэлээд хэсгийг нь энэ жил хүлээлгэн өгөх юм.

Далд эдийн засаг:
Монголбанкны судалгааны газраас “Сүүдрийн эдийн засаг” судалгааг боловсруулжээ. Тус судалгааны дүгнэлтээс үзэхэд манай улсын сүүдрийн эдийн засгийн хэмжээ 2012 оны байдлаар ДНБ-ий 35 орчим хувьтай тэнцэж байна. 2000 оноос хойш сүүдрийн эдийн засаг өсөх хандлагатай байгаа аж. Сүүдрийн эдийн засаг үүсэх гол шалтгаан нь татварын дарамт, бизнесийн үйл ажиллагаатай холбоотой аливаа дүрэм журам болж байгаа юм. Үүнээс зайлсхийхийн тулд иргэд болон аж ахуйн нэгж албан эдийн засгийн бүртгэлээс орхигдож далд хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна. Энэ нь сүүдрийн эдийн засаг цэцэглэх үндэслэл болж буй.

Төсөв:
Үйлдвэр, хөдөө аж ахуйн салбарт энэ онд улсын төсвөөс нийт 128.1 тэрбум



төгрөгийг зарцуулна. Үүнээс мал аж ахуйн салбарт 63.4 тэрбум, газар тариаланд 35.1 тэрбум, хүнсний салбарт хүнсний салбарт 14.6 тэрбум, аж үйлдвэрт нэг тэрбум төгрөгийн тус тус олгох юм. Мөн малчдын хоршоодыг дэмжихэд 1.5 тэрбум төгрөг төсөвт суулгажээ. Үүнээс гадна улаан буудай, ноос, арьс, ширний урамшуулал хэвээр үргэлжлэх аж.

Гарчиг
Австрали, Монголын бизнесийн зөвлөл байгуулагдлаа. Тус зөвлөл нь хоёр орны эдийн засаг, худалдаа, хөрөнгө оруулалтын харилцан ашигтай хамтын ажиллагааг дэмжих юм. Зөвлөлийн ТУЗ-ийн даргаар Австралийн “Минтер Эллисон” компанийн Олон улсын салбар хариуцсан захирал Марк Грийг томилжээ. Манай улсад Австрали Улсын 30 гаруй компани төлөөлөгчийн газраа нээсэн байдаг.

Дэлхийн хамгийн их нүүрсний нөөцтэй 10 орон

	Улс	Нөөц, сая.тн	Дэлхийд эзлэх хувь
1	АНУ	237,3	22.6
2	ОХУ	157,0	14.2
3	Хятад	114,5	12.6
4	Австрали	76,4	8.9
5	Энэтхэг	60,6	7.0
6	Герман	40,7	4.7
7	Украин	33,9	3.9
8	Казахстан	33,6	3.9
9	ӨАБНУ	30,2	3.5
10	Монгол	23.5	2.5

Эх сурвалж: АМГ

ДЭЛХИЙ ДАХИНД



АНУ

АНУ-ын парламент Засгийн газрын өрийн дээд хэмжээг нэмэгдүүлэх саналыг хүлээн авч, батлаад байна. Парламент дахь Бүгд найрамдах намын бүлэг үүний эсрэг байр суурьтай байв. Гэвч нэлээд маргалдсаны эцэст санал нэгджээ. Ийнхүү нэг жилийн хугацаанд өрийн дээд хэмжээг 17.2 их наяд ам.доллар болгов. Тус улсын өр энэ сарын сүүлч гэхэд дээд хэмжээнээс хэтэрнэ хэмээн албаны хүмүүс хэлжээ.



БНХАУ

Хятадын гадаад худалдааны илүүдэл өнгөрсөн сарын байдлаар 31.9 тэрбум ам.долларт хүрчээ. Энэ нь эдийн засаг цаашид өсөлттэй байхыг харуулж буй. Өнгөрсөн оны мөн үеэр 23.7 тэрбум ам.долларын илүүдэлтэй гарч байв. Импорт жилийн өмнөх үеийнхтэй харьцуулахад 10 хувиар өсч, 175.27 тэрбум ам.долларт хүрчээ. Харин экспорт 10.6 хувиар өсч, 207.13 тэрбум ам.доллараар хэмжигдэх болов.

Япон

Японы Төвбанк уламжлалт бус мөнгөний бодлогоо цаашид хэрэгжүүлэх шаардлагагүй болж ч магад. Энэ талаар Олон улсын валютын сангийн Ази, Номхон далайн газрын орлогч дарга Жерри Шифф хэлжээ. Учир нь инфляци тус банкны зорилтот түвшин болох хоёр хувьд нь ойртож байгаа аж. Тэрбээр “Дэлхийн зах зээл




ороо бусгаа байгаа учраас Японы Төвбанк хөгжлийн асуудлыг болгоомжтой авч үзэх. Инфляци хурдаа алдах шинж тэмдэг илэрвэл шаардлагатай арга хэмжээ авах хэрэгтэй” гэжээ.

Евробүс

Энэ сарын дундуур евробүс өнгөрсөн оны дөрөвдүгээр улирлын эдийн засгийн өсөлтийн тайлангаа гаргаж буй. Үүнийгээ Европын Төвбанкны бодлого тодорхойлогчдод танилцуулах аж. “Ройтерс” агентлагаас хийсэн судалгаагаар евробүсийн ДНБ улирлын түвшингээр 0.2, жилийн түвшингээр 0.4 хувийн өсөлттэй байхыг харуулжээ. Уг бүсийн хамгийн том эдийн засаг бүхий Германы ДНБ-ий улирлын өсөлт 0.3, харин жилийн өсөлт нь 1.3 хувь байх болов уу гэсэн таамаг дэвшүүлсэн байна.

ОХУ

Оросын Төвбанк Москвад төвтэй Eurotrust, LINK-bank гэсэн хоёр банкны лицензийг хураажээ. Эхнийх нь боломжит алдагдал, зээлийг нөхөх хангалттай нөөцгүй. Мөн зээлдэгч, хадгаламж эзэмшигчдийнхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүй аж. Харин удаах нь үйлчлүүлэгчдээ



эрсдэлээс хамгаалж чадаагүй байна. Мөн хоёр банк мөнгө угаах зэрэг таагүй асуудалтай ороцолдсон хэмээн Төвбанк үзэж байгаа аж.

Индексийн өсөлт

АНУ-ын Холбооны нөөцийн банкны тэргүүн Жанет Еллен эдийн засгаа сайжиртал өнөөгийн мөнгөний бодлогоо үргэлжлүүлэх талаар мэдэгджээ. Үүний дараахан Азийн орнуудын хувьцаа, индекс өсөх болов. Үүнд, Японы Nikkei 225 индекс нэг, Хонконгийн Hang Seng 0.4 хувиар тус тус өсчээ. Мөн Wall Street-ийн индекс болох S&P 500 индекс 1.1, Dow Jones 1.2, Nasdaq нэг хувиар өссөн үзүүлэлттэй байна. ■



НҮҮРСНИЙ САЛБАРТ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН 4 ДЭХ УДААГИЙН ОЛОН УЛСЫН ЧУУЛГА УУЛЗАЛТ, ҮЗЭСГЭЛЭН

Ерөнхий зохион байгуулагч

УУЛ УУРХАЙН ЯАМ

MINING.MN



COAL MONGOLIA 2014

2014 оны 2 дугаар сарын 20-21

МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, SS CONVENTION CENTER

ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ ___ ДЭМЖИГЧ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУД

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН ЯАМ

ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМ

ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

САНГИЙН ЯАМ

ПЛАТИНУМ ИВЭЭН ТЭТГЭГЧИД

ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ ERDENES-TT

MONGOLIAN MINING CORPORATION

HERA Equipment — OFFICIAL DISTRIBUTER OF — WIRTGEN GROUP — Wirtgen

ДАЙМОНД ИВЭЭН ТЭТГЭГЧ

GLOGEX — Geology & Mining Consulting Services

ГОУЛД ИВЭЭН ТЭТГЭГЧИД

XacBank Зөв Банк

ТАВАНТОЛГОЙ ХК

SHARYN GOL JSC since 1965

TEVSHIIN GOBI POWER PROJECT — ENVIRONMENTALLY FRIENDLY ENERGY

KPM telematics

KHISHIG ARVIN INDUSTRIAL CO.,LTD

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИВЭЭН ТЭТГЭГЧИД

ХААН БАНК ЭРХЭМ ТАНЫ ИТГЭЛТ АНД

TRANSWEST MONGOLIA LLC

KOMATSU

МОНАА

BRB

MobiNet leading internet technology

MAPTEK

AL AY LAZZARO

ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГУУД

MONGOLIAN NATIONAL MINING ASSOCIATION

Mongolian Mining Club

COVERMONGOLIA

THE BUSINESS COUNCIL OF MONGOLIA

MAMCE

МОНГОЛЫН ХИМИЧ, ХИМИЙН ИНЖЕНЕРҮҮДИЙН НЭГДСЭН ХОЛБОО

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХАМТРАГЧИД

EAGLE — television — МОНЦАМЭ — BRB — EMONGOLIAN ECONOMY — АРДЧИЛАЛ — ASSA — InfoMongolia.com — UILDVERJILT.MN — HUMAN CAPITAL — ӨГЛӨӨНИЙ СОНИН — Business-Mongolia.com

Bloomberg TV MONGOLIA — InfoMine — ASIA Miner — globalCOAL — COAL INTERNATIONAL — Mining People Environment — ChinaMineral — ASIA TODAY — BAIINFO — OXFORD BUSINESS GROUP — COAL SPOT.COM

“Coal Mongolia” чуулганы тухай

Чуулган нь Монгол Улсад хэрэгжүүлж буй нүүрсний хайгуул, олборлолт, боловсруулалтын төслүүдэд хөрөнгө оруулалт татах, байгаль орчинд ээлтэй, шинэ дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, олон улсын харилцан үр ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлж Азийн бүс нутагт Монгол Улсын нүүрсний салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилготой.

Утас: +976-70115590, Факс: +976-70125590

info@coalmongolia.mn, registration@coalmongolia.mn

www.coalmongolia.mn

АЛБАН ЁСНЫ ДИСТРИБЬЮТОР

The power to do more

БАТАЛГААТ PC SERVICE CENTER 3 ЖИЛ ХУГАЦАА

DELL OPTIPLEX 3010

Business class performance desktops



CPU	RAM	HARD DISK	DVD	
Intel Core i3-3220	4GB DDR3	500GB HDD	DVD/RW	E1914H 18.5”

PC mall®
СҮЛЖЭЭ ИХ ДЭЛГҮҮР

www.pc-mall.mn

7011-3535, 7012-3535

ОНЦЛОХ

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН ХУВИЛБАР: 2040



Б.АЛТАЙ

Швейцарийн Давос хотноо өнгөрсөн сарын 22-25 нд Дэлхийн эдийн засгийн форум боллоо. 44 дэх удаагийн чуулганд Монголын Улсын хөгжлийн асуудлаар анх удаа тусгай хэлэлцүүлэг болсныг манай сэтгүүл онцолж байна. “Дэлхий дахиныг өөрчлөн шинэчлье: Нийгэм, улс төр, бизнест үзүүлэх нөлөөллүүд” сэдвийн дор дэлхийн улс төр, бизнесийн 2500 гаруй төлөөлөгч чуулсан юм. Тэд өөрсдийн өмнө тулгамдаад буй эдийн засгийн асуудлаа хамтдаа хэлэлцсэн. Дээвэр нэгтэй дэлхийн 30 орны төрийн тэргүүн Альпийн нурууны бэлд орших Доваст саатаж, шинэ сорилтыг хэрхэн даван гарах арга замаа ийн тодорхойлсон билээ.

Манай улсаас Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэг, НҮБ-ын Женев дэх төв болон олон улсын бусад байгууллагын дэргэд суугаа байнгын төлөөлөгч В.Пүрэвдорж нарын албаны төлөөлөгч оролцсон юм. Энэ удаагийн чуулганаар манай улсын ирээдүйн төлөвийн талаар тусгай хэлэлцүүлэг болж, 2040 он хүртэлх хөгжлийн зураглал “дуттуй”-гаа задаллаа.

Дэлхийн эдийн засгийн форумыг санаачлагч, профессор Шваб “Өмнө нь Давосын дэлхийн эдийн засгийн чуулга уулзалтаар Монгол Улсыг таниулах зорилготой байсан. Тэгвэл одоо Монгол Улс Давосын чуулга уулзалтад идэвхтэй оролцогч түнш боллоо” хэмээн онцлоод Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалтад орон зайгаа Монгол Улс эзэлж байгааг сайшаасан юм.

Эдийн засгийн чуулга уулзалт 44 жилийнхээ түүхэнд жил бүр нэг орныг сонгон авч хөгжлийнх нь стратегийн хэлэлцүүлэг өрнүүлдэг уламжлалтай. Өнгөрсөн жил ОХУ-ын хөгжлийн стратегийг хэлэлцэж, замын зураглал, зөвлөмж гаргаж байсан. Тэгвэл энэ жил Монголын хөгжлийн стратегийг онцлов. Хэлэлцүүлэг гурван үе шаттай байсан бөгөөд эхний хэлэлцүүлэг өнгөрсөн оны есдүгээр сард Улаанбаатар хотноо, хоёр дахь нь мөн оны арваннэгдүгээр сард Их Британийн нийслэл Лондонд болсон. Уг тайланг бэлтгэх гэж Дэлхийн эдийн засгийн чуулганы баг Монголд хэдэнтээ ирсэн билээ. Харин сүүлийн хэлэлцүүлэг Давост болж, “Монгол Улсын хөгжлийн стратегийн хувилбарууд” тайланг танилцуулсан. Энэхүү хөгжлийн стратегийн хувилбаруудыг манай сэтгүүл Давосын чуулганд задалсан “эх хувиас” нь дэлгэрэнгүй хөрвүүлж хүргэж байна. Харин одоо тус чуулганд оролцсон төлөөлөгчдийн заримынх нь хөгжлийн стратегийг хэрхэн харж буй төсөөллийг хүргэе. ▸▸

Ухаалаг төр ба хөгжлийн зураглал



Ц.Элбэгдорж /Монгол Улсын Ерөнхийлөгч/:

-Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалтаас гаргасан судалгаа болон зөвлөмжийг бид цаашид анхаарах болно. Энэхүү хөгжлийн зураглалын аль нэгээр нь Монгол Улс хөгжинө гэхээс илүү цаг үе, эдийн засаг, нийгмийн хандлагаас хамаарч өөрчлөгдөж болно. Гэхдээ бид том төрөөс ухаалаг төр лүү шилжих шилжилтийг хийж байна. Судалгаанд суурилсан, үйлчилгээнд чиглэсэн, хуулийн засаглалыг дээдэлсэн ухаалаг төрийг бий болгосноор Монголын хөгжлийн зураглал илүү өөдрөг байх болно гэдэгт итгэлтэй байна.

Хамгийн шинэлэг, анхаарууштай нь ногоон эдийн засаг



Б.Лакшми /Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадвар судалгааны төвийн гүйцэтгэх захирал/:

-Миний хувьд эхний хувилбар болох Зүүн Өмнөд Азийн хөгжлийн түншлэлд илүү ач холбогдол өгч байгаа. Энэ чиглэлд манай улс түлхүү анхаарах болов уу. Зөвхөн БНХАУ-ын зах зээл гэхгүйгээр бусад орны зах зээлд нэвтрэх боломж эндээс харагдаж байгаа. Одоогийн байдлаар манай улс Азийн орнуудтай харилцаа нэлээд сайн байгаа. Иймд 2040 он хүртэл таатай харилцаагаа түшиглэн олон оронтой хамтын ажиллагааг эхлүүлэх боломжтой.

Дэлхийн эдийн засгийн чуулганы зүгээс хийсэн манай улсын хөгжлийн зураглалыг гадаад орчинд голдуу хэлэлцэж ирсэн. Тэгвэл ирэх сард болох Монголын эдийн засгийн чуулганы үеэр дээрх зураглалыг дотооддоо танилцуулахаар зэхэж байна. Дотооддоо энэ ажлыг хийхэд хэр бэлтгэлтэй байна. Нэг талаасаа гэрийн даалгавараа хийхэд бэлэн эсэх нь гарч ирэх юм. Хамгийн сонирхолтой, шинэлэг, зураглал нь ногоон эдийн засаг. Манай урд хөрш болох БНХАУ ногоон эдийн засгийг түлхүү хөгжүүлэх. Хятадын хувьд агаарын бохирдол гамшгийн хэмжээнд хүрсэн.

Төрийн шийдвэр тогтвортой байх



Л.Пүрэвсүрэн /Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үндэсний аюулгүй байдал, гадаад харилцааны зөвлөх/:

-Манай улс уул уурхайн салбарт баримталж буй бодлогоо тогтвортой, тодорхой явуулах ёстой. Гол нь төрийн шийдвэр тогтвортой байх нь чухал. Юуны өмнө эдийн засгаа төрөлжүүлэх шаардлага урган гарч байна. Зөвхөн уул уурхай ярих бус сэргээгдэх, нөхөгдөх түүхий эд манайд бий. 45 сая толгой мал байна. Түүнээс гарч буй ноос ноолуур, арьс шир, сүү, цагаан идээ. Эдгээр нь Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэх, экспортын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх асар том боломж. Бидний өмнө том зах зээл байгаа. Иймээс экспортын аж үйлдвэрийг хөгжүүлэх. Мөн худалдааны зохистой бодлогыг бий болгох хэрэгтэй. Нэг зах зээлийн хамаарлыг багасгах. Ингэж эдийн засгийн аюулгүй байдлыг хангах. Бүс нутагтаа хөгжих боломж байна.

Макро эдийн засгийн тогтвортой байдал чухал



Н.Золжаргал /Монголбанкны ерөнхийлөгч/:

-Хэрвээ Монгол Улсын төр, засаг зураглал гаргасан 26 жилийн өндөр өсөлттэй хугацаанд дотооддоо төдийгүй гадаадад нээлттэй, ил тод байвал тулгарах бүхий л сорилтуудыг давж гарч чадах болно. Ирэх 20 жилд Монгол Улс бүс нутгийн өсөлтөд хувь нэмрээ оруулж, эдийн засгаа илүү өндөр хурдаар өсгөх шаардлага тулгарна. Энэ нь манай улсын хувьд нэг томоохон бөгөөд амаргүй сорилт. Гэвч эерэг нөлөөтэй сорилт гэж хэлж болно. Яагаад гэвэл энэ тохиолдолд бидэнд эдийн засгаа 20 хувиар өсгөх үү, 25 хувиар өсгөх, эсвэл эдийн засгаа гурван жил тутамд хоёр дахин тэлэх үү, таван жил тутамд уу гэсэн сонголт өгөх юм. Гол нь макро эдийн засгийн тогтвортой байдлаа хадгалж үлдэх хамгийн чухал. ■

ДАВОСЫН ЧУУЛГАН

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЧУУЛГАН: МОНГОЛЫН ТАЛААРХ СТРАТЕГИЙН ШИЙДВЭР

Р.ГАНТУЛГА

Швейцарь улсын Давос хотод болсон ДЭЗЧ-аас Монголын стратегийн талаар гаргасан тайланг товчилсон байдлаар орчуулан та бүхэнд хүргэж байна.

ДЭЗЧ-ыг үндэслэгч, тэргүүн Клаус Шваб уг тайлангийн өмнөтгөлд “Монголын эдийн засгийн хөгжлийн нүүр царайг уул уурхайн салбар нь аль хэдийнэ өөрчилжээ. Монгол Улс байгалийн нөөцөө цаашид хамгийн зөв зохистойгоор ашиглахын тулд бүс нутаг болон дэлхийн чиг хандлага дахь тодорхойгүй байдлыг шийдвэрлэх нь чухал. Бидний дэвшүүлсэн хувилбарууд тодорхойгүй байдлыг тодорхой болгож, өдгөө сайн шийдвэр гаргахад зориулсан шалгарсан арга барил юм. ДЭЗЧ-аас эдгээр хувилбарыг санал болгож байгаа нь нэр хүндийн хэрэг. Эдгээр нь Монгол Улсын ирээдүйн хөгжилд дэмжлэг болно гэдэгт найдаж байна” гэжээ.

Монгол Улсын цаашдын хөгжилд зориулсан стратегийн шийдвэрийн хувилбарыг доор танилцуулж байна.

Үүнд:

Стратегийн шийдвэр № 1:

Монгол Улсын уул уурхайн салбарын хөгжил, түүнээс олох боломжит орлогоос хүртэх үр өгөөжийг хэрхэн сайжруулах ёстой вэ?

Монголын нийт эскпортын 90 хувийг эзэлж буй уул уурхайн салбар эдийн засгийн байдлыг өөрчлөх боломжтой. Уул уурхайн салбар 2011 онд төсвийн орлогын 50 хувийг эзэлж байв. “Оюутолгой” бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхэлбэл төсвийн 30 хувийг дангаараа бүрдүүлэх тооцоо бий. Гэхдээ энэ салбар хөгжлийн эхэн шатандаа байгаа тул Монголын ирээдүйн нөхцөл ямар байх, тогтвортой хөгжлийн талаарх асуултын хариултыг олоход ДЭЗЧ-аас санал болгож буй хувилбарууд дэмжлэг үзүүлэх юм. Тухайлбал, хайгуул, ашиглалтын лицэнз болон салбарын хөгжлийн үйл явц ямар хурдацтай явагдах ёстой. Тулгарч буй сорилтыг шийдвэрлэхэд уул уурхайн салбарт ямар бодлого үгүйлэгдэж байна вэ. Олон нийтийг салбарын хөгжилд хэрхэн оролцуулах вэ гэх мэт асуудал гарч ирнэ. Тухайлбал, 2013 оны дөрөвдүгээр сард орон даяар хийсэн судалгаанд оролцогчдын 85 хувь нь Монголын стратегийн ач холбогдол бүхий ордуудын ихэнхийг нь эсхүл бүгдийг нь Монгол Улс эзэмших ёстой гэжээ.

Стратегийн шийдвэр № 2:

Эдийн засгийг ямар хэлбэрээр, хэрхэн төрөлжүүлэх вэ?

Уул уурхайн бус бүтээгдэхүүний эскпорт өнгөрсөн онд өсөлттэй гарсан боловч нийт эскпортын 12-хон хувийг эзэлжээ. Үүнээс 40 хувь нь самнасан ноолуур болон ноолууран бүтээгдэхүүн байв. Аж үйлдвэрийн салбар өнгөрсөн оны эхний хагаст өсөлттэй гарсан ч ДНБ-ий тавхан хувийг эзэлжээ.

Эдийн засаг нь төрөлжсөн Азийн орнуудтай харьцуулахад Монголын эдийн засаг таваарын зах зээлээс ихээхэн хамааралтай. Учир нь таваарын ханшийн уналт эдийн засагт нь шууд нөлөөлдөг. Энэхүү хөгжлийн эхэн шатанд эдийн засгийг төрөлжүүлэхтэй холбоотойгоор бизнесийнхэн болон бодлого тодорхойлогчдын гаргах шийдвэр нь маргаашийн эдийн засаг ямар байхыг тодорхойлох гол хүчин зүйл болж байна. Монголын хувьд томоохон боломжийг бүрдүүлэх ямар бараа, үйлчилгээ ирээдүйд эрэлттэй байх бол. Аль салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээ нэмүү өртөг бий болгож чадах вэ. Мөн эдийн засгийн төрөлжилтөөс үүдсэн ямар асуудал урган гарч ирэх бол. Засгийн газар зөвхөн гадаадын хөрөнгө оруулалтын орчинг сайжруулахад анхаараад байх уу. Эсхүл Монголд өрсөлдөх давуу талыг бий болгох “ялагчийг сонгох” (picking winner) стратегийг баримтлах уу. Энэ мэт олон асуудал стратегийн энэхүү шийдвэрийн хүрээнд хөндөгдөж буй.

Стратегийн шийдвэр № 3:

Дээрх хоёр стратегийн шийдвэрийг гаргахад худалдаа, хөрөнгө оруулалтын ямар харилцаа шаардлагатай вэ?

Азийн бусад оронтой харьцуулах Монгол Улс ганцхан зах зээлээс хамааралтай. Энэ бол мэдээж урд хөрш нь. Хятад улс Монголын нийт экспортын 80, импортын 45, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 49 хувийг тус тус бүрдүүлдэг. Дэлхийн хамгийн том зах зээлийн хөрш байх нь Монголын хувьд тактикийн давуу тал, өргөн боломжтой байгааг харуулж буй. Гэхдээ Монголын эдийн засгийн гүйцэтгэл урд хөршийнхөөсөө шууд хамааралтай юм.

Энэ нь ч Хятадад ямар хөгжил, дэвшил шинээр гарч ирж буйг Монголын тал ойлгож, худалдаа, хөрөнгө оруулалтын ямар боломж байгааг олж мэдэхэд нь тустай аж. Худалдаа, хөрөнгө оруулалтыг төрөлжүүлэхийн тулд бүс нутагт цаашид боломж байгаа болов уу. Мөн бүс нутгийн хүрээнд болон хүрээнээс давж хөгжихөд шаардагдах эдийн засаг болоод улс төрийн ямар харилцааг Монгол Улс цаашид баримтлах хэрэгтэй вэ. Энэ хоёр асуултад аль алинд нь тодорхой хариулт олох нь чухал юм.

Урт хугацааны алсын хараатай болох нь өнөөгийнхөөс илүү дэвшилтэт харилцаатай болох боломжийг цаашид нээж өгнө. Энэ алсын хараагаар бүс нутагт боломж буй эсэхийг сайтар шалгаж үзсэнээр худалдаа, хөрөнгө оруулалтын харилцааг улам тодотгож өгөх. Монголыг урт хугацааны тогтвортой өсөлттэй болгох давуу талыг олгох боломжтой.

Тодорхойгүй байгаа тулгамдсан асуудлуудыг авч үзэх. Тухайн асуудал шууд хариулах боломжгүй ч хамгийн сайн хариултыг хэрхэн өгөхөө шийдвэрлэх нь чухал. Хариултыг олохдоо өнөөгийн болон ирээдүйн тодорхойгүй нөхцөл байдлыг нухацтай авч үзэх ёстой.

Орд газрыг хөгжүүлэх, төрөлжсөн бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргахад урт хугацаа шаардагдана. Явцын дунд тодорхойгүй байдал улам даамжирч, цаашид юу болохыг таамаглахад бэрхтэй болдог. Тухайлбал, таваарын цаашдын эрэлт, ханш. Бүс нутгийн хамтын ажиллагаа, нэгдмэл байдал. Уул уурхайн хөрөнгө оруулалт дахь ширүүн өрсөлдөөн. Нийгэм, байгаль орчны норм, норматив нь Монгол Улс цаашид олборлосон бүтээгдэхүүнээ боловсруулж, борлуулахад хэр зэрэг хүндрэл учруулах бол гэх мэт тодорхойгүй хүчин зүйл олон бий.

Дээрх тодорхойгүй зүйлс хэрхэхийг таамаглахад бэрхтэй. Иймээс Монгол Улсын ирээдүйн нөхцөл байдал 2040 онд хэрхэх талаар хийсэн гурван хувилбарыг Дэлхийн эдийн засгийн чуулганы зүгээс санал болгосон. Хувилбар тус бүр харилцан адилгүй тодорхойгүй нөхцөл байдлаас бүрдэж буй. Тиймээс энэ нь бодлого тодорхойлогчдод цаашдын бодлого, шийдвэрээ гаргахад нь дэмжлэг үзүүлэх юм. Үүний тулд Монголын улстөрчид стратегийн илүү сайн шийдвэр гаргах, ирээдүйд юутай ч тулгарахад бэлэн байх шаардлагатай юм.

Яагаад хувилбарууд гэж?

Нөхцөл байдал тодорхойгүй байхад зөвхөн таамаг төдий зүйлд найдах нь ухаалаг сонголт биш. Тухайлбал, Азийн орнуудын хөгжлийн замнал цаашид ямар байх бол. Түүнчлэн өнөөгийн бодлогоо тодорхойлж, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэхийн тулд ирээдүйн нөхцөл байдлыг үнэлэх шаардлагатай болдог. Энд санал болгож буй хувилбарууд нь энэхүү үнэлгээгээр хангаж өгнө. Хувилбарууд нь таамаг төдий зүйл биш бөгөөд ирээдүйн талаарх үнэмшилтэй зураглал юм. Энэ нь улс орон, байгууллага, группын ирээдүйн нөхцөл байдал ямар байх талаарх хамгийн боломжит зураглалыг өөр өөр хэлбэрээр гаргасан, стратегийн ул суурьтай, сайн шийдвэр гаргахад зориулсан хэрэгсэл юм.

Монгол Улсын стратегийн хувилбарууд

Монголын хувьд уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүнээ үйлдвэрлэж, борлуулахад харьцангуй хялбар байх нөхцлийг бүрдүүлэх нь чухал. Гэхдээ уул уурхайгаас бусад бараа, бүтээгдэхүүн болон үйлчилгээнд энэ нь хүндрэл учруулж болзошгүй. Энэ байдал 2040 онд хэрхэх талаар гурван хувилбарыг боловсруулсан. Үүнд:


Хувилбар 1:

Бүс нутгийн сэргэн мандалт. Энэ хувилбараар Монгол Улс уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулахад хялбар байх аж. 2040 онд Монголын хөршүүд улстөр, эдийн засгийн хувьд илүү нэгдмэл болсон байна. Зүүн хойд Ази болон ОХУ-ын зүүн хэсэгт худалдаа, хөрөнгө, мэдлэгийн урсгал чөлөөтэй болж, хүн ам нэмэгдэж, хамтын ажиллагаа сайжирна. Үүний дүнд бүс нутгийн эдийн засаг огцом өсөх аж. Энэ нь Монголын хувьд уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүн болон бусад бараа, үйлчилгээг борлуулахад урьд хожид байгаагүй сайхан боломж болох юм байна. Гэхдээ эрсдэл бий. Үүнд, Монгол Улс голлланд өвчин, байгаль орчинд учруулах хор хөнөөл, баян, ядуугийн хоорондох ялгаанаас үүдсэн олон нийтийн үймээн, уламжлалт амьдралын хэв маягаас үүдэлтэй сөрөг нөлөө зэргээс урьдчилан сэргийлж чадах болов уу.

Хувилбар 2:

БНХАУ-ын (байгаль орчноо хамгаалахад чиглэсэн) ногоон бодлого. Энэ хувилбараар Монгол Улс уул уурхайгаас бусад чухал бүтээгдэхүүн, үйлчилгээ бий

Стратегийн хувилбарууд



БНХАУ-ын (байгаль орчноо хамгаалахад чиглэсэн) ногоон бодлого. Энэ хувилбараар Монгол Улс уул уурхайгаас бусад чухал бүтээгдэхүүн, үйлчилгээ бий

болгож, борлуулах боломжтой юм байна. Харин уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулахад хүндрэлтэй тулгарахаар байна. 2040 он гэхэд БНХАУ ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх, шинэ технологи, үйлдвэрлэлийн илүү цэвэр үйл явцыг санаачилах зэрэг талбарт бүс нутгийн хэмжээндээ тэргүүлж, эдийн засгийн дундаж өсөлттэй байх аж. Учир нь тус улс нийгмийн тогтвортой байдал, хүрээлэн буй орчны чанарыг сайжруулах зэрэг илүү тогтвортой хөгжлийн төлөө зорино.

Нөгөө талаас, Хятадын ногоон хөгжил нь Монголд уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүнээ эскпортлоход нь хүндрэл учруулна. Учир нь байгаль орчин болоод нийгмийн зардал нэмэгдэж, бүтээгдэхүүний эрэлт буурах аж. Гэхдээ энэ хувилбар Монгол Улсад ногоон бодлоготой болж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргаж, эдийн засгаа төрөлжүүлэх боломжийг бүрдүүлэх сайн талтай ч байж болох.

Хувилбар 3:

Байгалын нөөцийн зөрчилдөөн: Энэ хувилбараар Монгол Улс уул уурхайгаас бусад бүтээгдэхүүн болон үйлчилгээг бий болгож, борлуулах боломжгүй болох юм. Бүс нутгийн хувьд 2040 он гэхэд тарж бутарсан байдалтай, геополитикийн зөрчилдөөнтэй, эдийн засгийн тэмцэл, өрсөлдөөнөөр дүүрэн байх шинжтэй. Байгалийн нөөц, баялгийг улс төрийн хөшүүрэг болгон ашиглаж, энэ нь Монголын уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүнийн эрэлтэд нөлөөлнө. Баруун эсхүл зүүн жигүүрийн популизм давамгайлсан улс, орнууд өөрсдийн хувийн ашиг сонирхлыг илүүд үзнэ. Хөрөнгө оруулагчид зөрчил, тэмцэл, үймээн самуун гарах эрсдэл багатай орнуудад хөрөнгө оруулалтаа хийхийг илүүд үзэх болно.

Энэхүү хувилбар нь Монголын хувьд хүндхэн сорилт юм. Уул уурхайн баялгаа нээн олборлож, эдийн засгийн бусад салбараа хөгжүүлэхийн тулд санхүү болон эскпертизийн тусламж, дэмжлэг авахад олон хүндрэлтэй тулгарах аж. Өөдрөг талаас нь харвал, Монгол Улс бүс нутагтаа бие даасан хэм хэмжээгээ хадгалж, бүс нутгийн зөрчилдөөнийг шийдвэрлэхэд идэвхтэй оролцох боломжтой юм байна.

Монгол Улс стратегийн шийдвэр гаргахад зориулсан хувилбаруудын үр нөлөө

Стратегийн шийдвэр № 1:

Бүс нутгийн сэргэн мандалт: Энэ хувилбараар бүс нутгийн нэгдмэл байдал нь эдийн засгийн өсөлтийг авчирч, Монгол Улсад уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулах ихээхэн боломжийг бүрдүүлэх аж.

Гэхдээ эдгээр боломж шууд гараад ирнэ гэсэн баталгаа үгүй. Бүс нутгийн эдийн засгийн хүчтэй өсөлт нь бусад орны анхаарлыг татна. Гэхдээ Монгол Улс дэд бүтцээ системчилсэн хэлбэрээр сайжруулж, өрсөлдөх чадвар сайтай, өндөр ашигтай хөрөнгө оруулалтыг татахад анхаарах нь зүйтэй. Засгийн газар цаашид хувийн хэвшилд оролцоод байх уу, оролцохгүй байх уу гэдэг асуудлын тал дээр нэгдсэн зөвшилцөлд хүрэх ёстой. Мөн уул уурхайн салбарт ногдуулах татвар болон хайгуул, ашиглалтын лицензийн олгох асуудлыг ч нааштай шийдвэрлэх шаардлагатай тулгарна.

Уул уурхайн салбарыг өргөжүүлж, түүнээс олох орлогыг нэмэгдүүлэхдээ ашгийн шударга хуваарилалт хийж байгаа гэдгээ олон нийтэд ойлгуулах байдлаар зохион байгуулах. Голланд өвчнөөс сэргийлэх, хөгжлийг дэмжих хэлбэрээр уул уурхайгаас олох орлогыг сайтар зохион байгуулах хэрэгтэй. Валютын ханш зэрэг макро эдийн засагт зориулсан сайн менежменттэй байх нь энэ хувилбарт чухал үүрэг гүйцэтгэнэ.

Монгол Улсын баялгийн сан хоёр төрлийн дэмжлэг үзүүлэх болно. Нэгдүгээрт, эдийн засаг хэт халахаас урьдчилан сэргийлэхийн тулд шаардлагатай үед эдийн засгаас мөнгө гаргаж, хөрөнгө оруулалтын сан хэлбэрээр ажиллах. Хоёрдугаарт, шаардлагатай үед орон нутгийн чанартай хөрөнгө оруулалт хийж, хөгжлийн сан хэлбэрээр ажиллах. Эхнийх нь санхүүгийн экспертиз шаардах бол удаах нь салбарын тусгай менежментийн экспертиз шаардах болно.

БНХАУ-ын ногоон бодлого: Энэ хувилбар Хятад болон бүс нутгийн ногоон бодлого нь Монголын уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтад урт хугацааны хүндрэл учруулна гэсэн саналыг дэвшүүлж байна. Харин богино хугацаанд энэ хувилбар нь “Нартай үед хадлангаа бэлтгэх” боломжийг бүрдүүлж буй. Энэ үеийг ашиглан уул уурхайн бүтээгдэхүүнээ аль болох хурдан борлуулж, баялгийн сандаа аль болох ахиухан хуримтлал бий болгох хэрэгтэй. Бүтээгдэхүүний борлуулалт муудах үед баялгийн сангаасаа ашиглах боломжтой юм. Засгийн газар одооноос үр ашиг, өрсөлдөх чадварыг нь сайжруулах хэрэгтэй институц, дэд бүтцэд хөрөнгө оруулж эхлэх нь зүйтэй. Энэхүү богино хугацааны стратеги нь урт хугацаанд өөр боломжийг бүрдүүлэх боломжтой гэдгийг олон нийтэд ойлгуулах хэрэгтэй болно.

Энэ хувилбараар уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүний ханш буурч, энэ нь экспортыг дэмжихэд хангалтгүй байх аж. Гэхдээ Монгол Улсын хувьд ногоон хөгжлийг сонгосон орнууд руу эскпортлох боломжтой газрын ховор элемент, уран зэрэг өөр бүтээгдэхүүн нээн илрүүлэх боломж бий.

Байгалийн нөөцийн зөрчилдөөн: Энэ хувилбараар геополитикийн зөрчил нэмэгдэж, эрдэс баялгийн стратегийн зориулалтаарх ашиглалт нэмэгдэх учраас уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулахад ихээхэн хүндрэлтэй болохоор байна. Өмнөх хувилбарын нэгэн адил уурхайн бүтээгдэхүүний борлуулалтыг аль болох хурдан, үр ашигтай хийж, баялгийн сандаа хуримтлалтай болохын тулд одоогийн уул уурхайн үйл ажиллагааны үр ашгийг хамгийн дээд түвшинд хүргэхэд анхаарах хэрэгтэй.

Стратегийн шийдвэр №2:

Бүс нутгийн сэргэн мандалт: Бүс нутгийн нэгдмэл байдал болон эдийн засгийн өсөлт нь бүс нутагт харьцуулалт хийх давуу талыг Монголд олгох болно. Хөдөө аж ахуй, оёмол бүтээгдэхүүн, газрын тос, байгалийн хий, уул уурхай, санхүүгийн үйлчилгээ зэрэг салбарт бараа, үйлчилгээ шинээр бий болгох шаардлагатай тулгарна. Тухайлбал, Монгол Улс ОХУ-ын хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүнтэй өрсөлдөх боломжгүй ч оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлээрээ өрсөлдөх давуу талтай байж болох юм.

БНХАУ-ын ногоон бодлого: Энэ хувилбар Хятад болон бүс нутгийн хэмжээнд байгаль орчныг хамгаалахад чиглэсэн ногоон бодлого баримтлахыг харуулж байна. Энэ нь Монголын уул уурхайн гол нэрийн бараа, үйчилгээнд томоохон сорилт болох аж. Зах зээлийн эрэлт өөрчлөгдөх учраас Монголын хувьд органик мах, сүү, ноолуур, эко аялал жуулчлал, сэргээгдэх эрчим хүч гэх мэт эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой. Бараа, үйчилгээний чанарыг олон улсын түвшинд хүргэхийн тулд нэлээд цаг хугацаа, хөрөнгө оруулалт шаардагдана.

Шинэ бараа, үйлчилгээг нэвтрүүлэхийн тулд бизнесийн орчин маш сайн байх шаардлагатай. Тухайн салбар хараахан бие дааж хөгжих боломжгүй үед төрийн оролцоо зарим үед дэмжлэг үзүүлэх нь бий. Гэхдээ үүнийг хийхдээ маш сайн судалгаа, шинжилгээнд үндэслэх ёстой. Мөн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид болон олон улсын компаниудад зориулсан тодорхой, ойлгомжтой журам гаргаж, бизнесийн орчинг ил тод болгох. Мөн баялгийн сангийн хөрөнгөөс боловсролын салбарт хөрөнгө оруулах шаардлагатай тулгарна.

Байгалийн нөөцийн зөрчилдөөн: Энэ хувилбараар Монгол Улс уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулах, мөн бусад салбараа хөгжүүлэхэд шаардагдах санхүүжилт олохын тулд ихээхэн хүндрэлтэй тулгарах аж. Бүс нутгийн бизнесийн орчин тааруухан байх болно.

Дэд бүтэц, боловсролын салбарт стратегийн хөрөнгө оруулалт хийх нь эдийн засгийн үр ашиг, өрсөлдөх чадварыг хамгийн дээд түвшинд хүргэхэд чухал ач холбогдолтой. Бүс нутгийн тээвэр, эрчим хүч, харилцаа холбооны сүлжээг дэмжихэд эртнээс анхаарах нь цаашид бүсийн дунд хуваагдал үүсч, үүнээс бий болох сөрөг нөлөөллийг бууруулахад тустай юм.

Хөрөнгө оруулалт, тээвэрийн зардал багатай бүтээгдэхүүн, үйлчилгээ нь экспортыг төрөлжүүлэх сайхан боломж байж болох. Тухайлбал, чацаргана гэх мэт. Мөн Итали зэрэг зах зээл рүү ноолуур тээвэрлэхэд хялбар байж болно. Хөрш орнуудтай харьцуулахад мэдээлэл, харилцаа холбоо, технологийн салбарт ихээхэн дэвшил гаргах боломж Монголд бий.

Логистик, аюулгүй байдлын стандартыг дээшлүүлснээр махны экспортыг сайжруулах боломжтой. Гэхдээ шинэ салбараар эдийн засгийг төрөлжүүлэхэд тулгарах саад, бэрхшээл нь Монголыг нүүдэлчин соёл, уламжлалын өнөөгийн хэв маягаа цаашид хэвээр хадгалахад хүргэж ч болзошгүй.

Стратегийн шийдвэр №3:

Бүс нутгийн сэргэн мандалт: Энэ хувилбараар бүс нутаг нэгдмэл байх бөгөөд Монгол Улсын хувьд худалдаа, хөрөнгө оруулалт хийх боломж олж авахад илүү хялбар байх аж. Гэхдээ эдгээр боломжийг хүртэх давуу талыг олж авахын тулд Монголын Засгийн газар бүс нутгийн орнуудын Засгийн газар болон институцтэй нягт хамтран ажиллах шаардлагатай. Энэ хувилбараар амжилт олохын тулд Монгол бизнесийн сайн түнш байж, хөршүүд болон олон талт институц, хувийн хөрөнгө оруулагчидтай сайн харилцаатай байх шаардлагатай юм.

Хөнгөлттэй зээлийн сан болон гадаадын шууд хөрөнгө оруулалтын өсөлтийг түвшинг үнэлснээр тээврийн зардал, логистикийн асуудлыг нааштай шийдвэрлэх боломжтой. Учир нь Монгол Улс далайд гарцгүй. Хоёр хөршийнхөө болон бүсийн хэмжээнд худалдаа, наймаа хөнгөвчлөхөд чиглэсэн дэд бүтцээр хангаж өгөх хэрэгтэй болно.

БНХАУ-ын ногоон бодлого: БНХАУ болон бүсийн бусад орон ногоон хөгжлөөр замнах тохиолдолд Монгол тэдгээртэй хэрхэн хамгийн сайн харилцаатай байхаа тодорхойлох хэрэгтэй болно. Тухайлбал, олон улсад ногоон орон гэсэн нэр хүндийг олж авах, хөрөнгө оруулагчдыг татах. Хятад болон дэлхийн компаниудтай хоёр талт хэлэлцээр хийх нь ногоон үйлдвэрлэлийн нийлүүлэлтийн сүлжээ (green industry supply chains)-нд нэгдэх боломжийг олж авах чадавхыг хөгжүүлнэ. Тухайлбал, газрын ховор элементээ ашиглан цахилгаан автомашины зай хураагуурын зарим эд ангийг үйлдвэрлэх гэх мэт.

Байгалийн нөөцийн зөрчилдөөн: Энэ хувилбар нь геополитикийн зөрчилдөөн, мөн байгалийн нөөцийг стратегийн орд болгон ашиглах нь бүс нутаг дахь харилцааг ойлгох, боломжийг олж илрүүлэхэд чадварлаг удирдан, зохион байгуулах зэрэгт чухал ач холбогдолтой байх болно. Тухайлбал, Хятадын оролцоотой зөрчилдөөн нь Австрали, Монгол зэрэг нийлүүлэгч орны худалдаанд заналхийлж болзошгүй юм. Энэ нь Хятадтай хөдөө аж ахуйн худалдааны талбарт хамтрах боломжийг нээж өгөх ч талтай. Хөрш орнуудтайгаа эдийн засаг, улс төрийн ул суурьтай харилцааг бий болгохын чухлыг энэ хувилбар санал болгож буй. Урт хугацаанд эдийн засгийн байдал улам хүндрэх учраас соёл, боловсролын солилцоо зэрэг харилцааг хөгжүүлэх, нөгөө талаас зардал багатай сонголтуудыг хийх боломжтой юм. Бүс нутгаас гаднах орнуудтай урт хугацааны түншлэл, хамтарсан хөрөнгө оруулалт хийх нь хамгийн зөв арга зам байж болох. Энэ нь ноолуур зэрэг уул уурхайгаас бусад салбарыг хөгжүүлэхэд тустай. Эцэст нь хэлэхэд, энэ хувилбараар бүс нутгийн байдал замбараагүй байх боловч Монгол Улс хоёр хөршийнхөө Монгол угсаатнуудтай худалдааны харилцаагаа өргөжүүлэх боломжтой юм.

Дээрх гурван хувилбар нь гадаад, дотоодын бизнесийн байгууллага, эрдэмтэн, судлаачидтай Монгол Улсын цаашдын эдийн засгийн талаар стратегийн уулзалт, хэлэлцээр хийж, төрийн бодлого тодорхойлоход гол тулгуур болж өгөх юм. Энэ тайланг гаргахаас өмнө олон уулзалт, хэлэлцүүлэг хийсэн. Тухайн үед бүс нутаг болон дэлхий эдийн засаг Монголын эдийн засагт хэрхэн нөлөөлж буй, эдгээр нь хооронд хэр нягт холбоотой зэргийг онцлон тэмдэглэж байв. Дээрх хувилбарууд нь Монгол орны нөхцөл байдал 2040 он хүртэл ямар байх талаарх хамгийн боломжит санал. Хооронд харилцан адилгүй бөгөөд хоосон таамаг, төсөөллөөс ангид. Мөн Монгол Улсыг урт хугацаанд тогтвортой хөгжүүлэх үүднээс байгалийн нөөцөө зөв зохистой ашиглах боломжийг дээд зэргээр нэмэгдүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэхэд чиглэсэн болно.

Цаашид гарын авлага болгон ашиглах дээрх хувилбарууд нь ДЭЗЧ болон Монгол Улсын хооронд хамтын ажиллагааны үр дүн юм. Хувилбаруудын гол зорилго нь хурдацтай хөгжиж, шинээр гарч ирж буй эдийн засгийн дүр төрхөө олоход нь Монгол Улс болон гол оролцогч талуудад дэмжлэг үзүүлэхэд оршино. ■

КАМПАНИТ АЖИЛ

ЦЭНХЭР СУВДНЫ ҮНЭГҮЙДЭЛ

“Mongolian Economy” сэтгүүл жил бүрийн гуравдугаар сарын 22-нд болдог Дэлхийн усын өдрийг тохиолдуулан “Усны үнэ цэнэ” кампанит ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран өрнүүлж, усны үнэ цэнийг ард түмэн, бодлого тодорхойлогч, шийдвэр гаргагчдад ойлгуулахыг зорин ажиллаж байна. Мөн тус аянд бусад хэвлэл мэдээллийн хэрэгслийг нэгдэхийг уриалах юм. Учир нь цэнхэр гаригт усны төлөөх дайн дажин, тэмцэл өрнөсөөр. Харин монголчууд бид их хувь заяаны тохиолоор усны гачлант амьдралыг мэдэхгүй, угаалтуур суултуурдаа хүртэл байнга газрын гүний цэвэр цэнгэг ус урсгасаар сууна. Хотжилт нэмэгдэж, уул уурхай эрчимжиж буй энэ цагт бидний өмнө цэвэр усны хангамжийн асуудал хурцаар тавигдах боллоо.

Тиймээс mongolianeconomy.mn сайтаар “Монголд ус үнэ цэнэтэй юү” цахим хэлэлцүүлгийг өрнүүлж, “Mongolian Economy” сэтгүүлийн дэргэдэх “Economy” студийн бэлтгэсэн “Цэнхэр сувдны үнэгүйдэл” нэвтрүүлгийг NTV телевизээр цацаж, сэтгүүлийнхээ уншигч, захиалагчдад хүргэж байна.



Ч.ЛУТАА

Үнэгүй юм үнэгүй л байдаг. Энэ сэтгэлгээгээр монголчууд усандаа хандсаар ирсэн. Монгол Улсын нийгэм эдийн засгийн хурдацтай хөгжил цөөн хэдэн газар төвлөрч тэнд усны гачигдал үүсэх магадлалтайг салбарынхан анхааруулсаар байгаа. “Ногоон эдийн засгийн өсөлт” ТББ-ын удирдах зөвлөлийн гишүүн З.Батбаяр “Нийслэлийн хүн ам нэмэгдэхийн хэрээр усны хэрэглээ ихэсч, Туул голын сав орчмын газрын доорх усны түвшин зарим жил 15 метр хүртэл доошилж, зарим үед тасарч эхэлсэн. Энэ нь бидний хэрэглэсэн гүний усыг гадаргын усаараа нөхөж чадахгүй болсон гэсэн үг. Тиймээс газрын гүний усыг ухаалаг ашиглах хэрэгтэй. Огт ашиглахгүй байна гэж байхгүй. Ундны усандаа гүнийн ус ашиглаад бусад хэрэглээндээ цас, борооны болон гадаргын ус хэрэглэх цаг болсон” гэв. Манай орны хэмжээнд ашиглагдаж байгаа цэвэр усыг авч үзэхэд ахуйн усан хангамж нь л дотоодын “цэнхэр ус”-ны нийт хэрэглээний таван хувийг эзэлж байна. Тэрбүү хэл, орон сууцны айл өрхүүд суултуур, угаалтуурдаа ч ундны усны эх үүсвэр болох Туул голынхоо цэвэр цэнгэг усыг хайр гамгүй урсгасаар. Гэтэл дэлхийн нийт хүн амын 85 хувь нь бөмбөрцгийн хамгийн хуурай цөлжилттэй бүс нутагт амьдарч байна. Түүнээс 780 гаруй сая хүн өнөөдөр цэвэр ус хүртэх боломжгүй амьдардаг гэх. Жилд дунджаар 6-7 сая хүн усны гамшиг болон устай холбоотой өвчний улмаас нас бардаг аж. Дэлхий дээр нэг минут тутамд усны хомсдолын улмаас нэг хүүхэд нас барж байна. Энэ мэт усны хомсдолтой холбоотой муу мэдээнүүд олон. Дээр нь бөмбөрцгийн хүмүүсийн тэн хагас нь хот суурин газар амьдардаг. Тэдгээрийн усан хангамжийн асуудал олон улсын өмнө тулгамдаад байна.

Мөн уул уурхай, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн усны хэрэглээ улам нэмэгдсээр. Дэлхийн хөдөө аж ахуйн салбарын цаашдын усны хэрэглээ 2050 онд ойролцоогоор 19 хувиар нэмэгдэх тооцоо гарчээ. Энэ хэрээрээ усны хүрэлцээ хангамж багасах хандлагатай байна. Таны мэддэггүй хэд хэдэн жишээг дурдъя. Тухайлбал, нэг ширхэг А4 бичгийн цаас үйлдвэрлэхэд 10 литр ус зарцуулдаг. Нэг хэрчим талханд 40 литр, нэг ширхэг өндөгт 140 литр, Хос ширэн гутал үйлдвэрлэхэд 8000 литр, Хөх жинсэн хослол хийхэд 11,000 литр, нэг кг үхрийн маханд 15,400 литр, нэг машин үйлдвэрлэхэд 150 мянган литр ус зарцуулдаг байна. Энэ хэрээр усны үнэлэмж олон улсад өссөөр байгаа. Тухайлбал, усны ▸▸

үнэ сүүлийн таван жилд АНУ-д 27, Англид 32, Австралид 45, Канадад 58 хувиар өссөн байна. Гэтэл өнөөдрийн байдлаар нэг литр усанд манай улсын гэр хорооллын айл нэг төгрөг, орон сууцны өрх 32 мөнгө төлж байна. Зах зээлийн нийгэмд 32 мөнгө, нэг төгрөгөөр юу худалдаж авах вэ.

Хот, суурины хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн дарга Ч.Эрдэнэчимэг “Олон улсад усны үнийг олон шатлалтайгаар тогтоосон байдаг. Учир нь иргэдэд усыг аль болох л хямд үнээр өгөх. Нөгөө талдаа ус ихээр хэрэглэдэг үйлдвэр, аж ахуйн нэгж зах зээлийн тарифаар хэрэглэдэг. Ингэснээр ард иргэд усаар хангагдах эрхээ эдлэж байгаа юм. Мөн усыг эдийн засагжуулж чадсанаар усан хангамжийн байгууллагаа алдагдалгүй ажиллах боломжийг бүрдүүлж байгаа хэрэг. Тиймээс энэ тогтолцоог нэвтрүүлэх хэрэгтэй” гэв. Харин энэ санал Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрынханд таалагдсангүй. Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлөөс гаргасан усны суурь үнийн саналаа ШӨХТГ-т танилцуулж, үнэ нэмэх зайлшгүй шаардлага байгааг учирласан ч үндэслэл нь хангалтгүй байна гэсэн шалтгаанаар хойшлуулжээ. Гэхдээ усны үнийг нэмэх тал дээр талууд хоёр хуваагдчихаад байгаа юм. Иргэдэд хүрч байгаа усыг суурь үнэтэй болгох хэрэгтэй. Одоо бол ус зөвхөн хүргэж өгсөн үйлчилгээний хөлсийг л иргэд төлж байгаа гэх нэг хэсэг байхад. Нөгөө хэсэг нь усыг хамаагүй хэрэглэдэг аж ахуйн нэгжийн усны төлбөрийг өндөр болгох хэрэгтэй гэдэг. Гэтэл хувийн хэвшил нь Усны нөөц ашигласны төлбөр, бохирдуулсны төлбөр гээд өч төчнөөн төлбөртэй болчихоод байгаа шүү дээ гэх.

Ямартай ч “Ногоон эдийн засгийн өсөлт” ТББ-ын зөвлөлийн гишүүн З.Батбаярын хэлсэнчлэн Монгол Улс зах зээлийн эдийн засагтай орон. Гэтэл бүх үйлдвэрлэлийн гол түүхий эд болох усны үнийг төр нь хүчээр барьж байгаа нь тийм ч таатай зүйл биш. Гэхдээ монголчууд усаа анхаарахгүй байна гэж огт хэлж болохгүй. 2011 оныг усны жил болгон зарлаж, 140 төрбум төгрөг зарцуулсан. 10 жилийн хугацаатай “Ус” үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн. Дээр дурдсанчлан устай холбоотой хэд хэдэн хууль баталсан. Гэвч эдгээрийн ихэнх нь цаасан дээр төлөвлөгдөж, ажил хэрэг болсон нь тун ховор байна. Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн дарга Ч.Эрдэнэчимэг “Ус хөтөлбөр бол маш том. Гэхдээ хөтөлбөрийн дагуу хэрэгжсэн зүйл ховор. Тиймээс усны талаарх хөтөлбөрийг нэгтгэх хэрэгтэй. Үүнийхээ дараа гурван зүйлийг л тогтчих. Нэгдүгээрт, усны нөөцдөө таарсан ашиглалтыг явуулах. Хоёрдугаарт, ашиглалт хэмнэлтийн бодлогыг давхар суулгаж өгөх хэрэгтэй. Гуравдугаарт, усыг дахин ашиглах. Ийм гурван зүйлийг усны салбарт төлөвшүүлж чадвал сая ус үнэ цэнэтэй болно” хэмээв.

Улаанбаатарчууд хамгийн үнэ цэнэтэй усыг хэрэглэдэг. Өвөг дээдсийн хэлдгээр дөрвөн уулын дундах Алтан тэвшийн хөндийгөөс гарч байгаа ус чанарын хувьд үнэхээр сайн байдаг тиймээс нийслэлчүүд азтай хүмүүс гэдгийг УСУГ-ын дарга С.Үнэн хэлсэн. Учир нь Улаанбаатар хотыг усаар хангадаг үндсэн дөрвөн хэсэг 160-170 гүний худгаас усаа татдаг бөгөөд энэ нь газрын гүний хамгийн цэвэр, унданд шууд хэрэглэж болох ус байдаг аж. Тиймээс хотын иргэд маань ундны усны эх үүсвэрийн эрүүл ахуйн тал дээр санаа зовохгүй байж болно. Ийм усаар л бид хоолоо хийж, шалаа угааж, суултуурт ч татаж байна. ШУТИС-ийн багш профессор Д.Басандорж “Усны салбарт бодлого үгүйлэгдэж байна. Бодлого байхгүйн улмаас бүх хэрэглээндээ гүний усыг хэрэглээд байгаа юм. Хэрвээ бодлоготой байсан бол гадагшаа урсаад гарчихдаг болон цас, бороony усыг унднаас бусад хэрэглээндээ хэрэглэдэг болчихсон байх байлаа. Цоргоноос гоожих усан дусал бүр мөнгөөр хэмжигдэж байгаа энэ үед усыг юман чинээ бодохгүй байгаа нь усны үнэ цэнийг иргэд мэдэхгүйтэй холбоотой байна” гэв. Үнэхээр Монгол Улсын усны салбарт бодлого үгүйлэгдэж байгаа нь үнэн. Тоо баримтаас харахад ирэх 15 жилд өмнөд говийн бүсийн усны хэрэглээ 10-20 дахин нэмэгдэх судалгаа гарчээ.

Монгол Улс өнөөдрийн байдлаар жилд 552 сая 65 мянга, өдөрт 1.5 орчим тонн ус хэрэглэж байна. Үүнээс 40 гаруй хувийг нь уул уурхай, эрчим хүч боловсруулах үйлдвэрлэлд ашиглаж байна. Оюутолгой компанийн зэс баяжуулах үйлдвэр хоногт 110 мянган тонн ус хэрэглэх тооцоо байна. Балгасын улаан нуурын ордоос 40176 тонн ус олборлоход 25 жил ашиглана. Тэгвэл өмнийн говь 25 жилийн дараа ямар байдалтай үлдэх бол. Газрын гүний усаа соруулсан говь нутагт хүн, мал тогтох уу? Дорноговь аймагт аж үйлдвэрийн цогцолбор барихад усны асуудал тулгамдаж байгаа. Сайншандаас зүүн хойш орших Бор хөөврийн говьд усны хайгуул хийх төслийг боловсруулж байгаа юм байна. Уул уурхай бол усыг тонн тонноор ууна. Өнгөрсөн 20 жилийн дотор уул уурхайн олборлолтын явцад 29 гол хэт бохирдсон гэж бүртгэгджээ. Тэд нэг литр гүний усанд 15 төгрөг л төлдөг. Гэтэл алт олборлоход нэг секундэд 500 литр ус хэрэглэдэг гэсэн тооцоо байна. Хэрвээ байдал энэ чигээрээ үргэлжилбэл Монгол улс 2020 он гэхэд олон уурхайнуудыг усаар хангаж чадахгүй болох магадлалтай. Учир нь нэг хүнд ногдох усны нөөц хангайн бүсэд дэлхийн дунджаас 4-5 дахин их. Харин говийн бүсэд 10 дахин бага байна. Тиймээс яг одооноос усныхаа нөөцийг тодорхой болгож, ус ашиглах бусад бололцоог эрж олох цаг ирээд байна.

Усны аюулгүй байдал бол эх дэлхийн аюулгүй байдал


Ус олон улсын сэдэв. Ус өөрөө онцгой байгалийн баялаг. Тэр утгаараа “Mongolian Economy” сэтгүүлийн хамт олон усны асуудлыг онцолсон өдрүүдэд Дэлхийн эдийн засгийн чуулган “Усны аюулгүй байдлын чиглүүлэгч: Усны ирээдүй аюулгүй байдлыг хангах дэвшилтэт өөрчлөлт” сэдэвт хурлыг зохион байгуулсан байна. Эдийн засгийн чуулганаар жил бүр усны асуудлыг онцолдог. Гэхдээ энэ удаа олон улсын зочид төлөөлөгчид дэлхий нийтийн хөгжлийн хурдац, үйлдвэрлэлийн нөлөөллөөс үүдээд цэвэр ус, ундны усны нөөц, усны менежментийн асуудал нь

тухайн улс, бүс нутаг төдийгүй дэлхий нийтийг хамарсан, нэгдмэл ойлголцол, бодлого шаардсан талбар болж буйг анхааруулжээ. Дэлхийн эрсдэлийн үнэлгээ (Global Risk Report)-нд дурдсанаар усны асуудал нь Дэлхий нийтийн өмнө тулгамдаж буй таван онцлох асуудлын нэг болоод байгаа аж. Тиймээс цаашид усны асуудлаарх үйлдвэрлэл, бүс нутаг, дэлхий дахины стратегийн асуудал нь нэн чухал сэдэв гэдгийг хурлын үеэр онцолсон байна. Тус арга хэмжээнд Монгол, АНУ, БНЭУ, Данийн Вант Улс, Өмнөд Африк, БНСУ, Швейцарь, ИБУИНВУ, Мексик, Испани, Перу, Белгийн Вант Улс, БНХАУ зэрэг 20 гаруй орны төлөөлөгч оролцжээ. Мөн энэ үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж усны талаар илтгэл тавьсан байна. Ингээд түүний хэлсэн үгийг товчлон сонирхуулж байна.
-Ус бол амьдралын эх булаг гэж ээж минь хэлж байсан. Ус бол үнэхээр амьд оршихуйн язгуур үндэс юм.

Ус бохирдож, ширгэж үгүй болох нь дэлхий ээжийн эмзэглэл бөгөөд оршин тогтохуйд заналхийлж буй гамшиг юм. Дараагийн нэгэн чухал зүйл бол усыг хайрлан гамнах, зохистой бодлого хэрэгжүүлэхийг эрхэмлэгч хувийн хэвшлийнхнийг бид дэмжихийг байнга эрмэлзэж байдаг. Усны аюулгүй байдлыг хангах зорилготой хүн бүрийн зорилго хамгийн сайн үр дүнд хүрнэ гэдэгт би итгэдэг. Ер нь аливаа хувийн хэвшлийн, судалгааны байгууллагын үйл ажиллагаа нь ямар ч төр, засгийн бодлогосоос илүү ухаалаг гэдэгт би итгэдэг. Тиймээс төр, аж ахуйн нэгжийн хамтын ажиллагаа усны асуудлаарх сайн санаачилга бүрийг дэмжин ажиллахыг зорьдог. Монгол Улсад сүүлийн жилүүдэд уул уурхайн эрчимтэй өсөлт явагдаж байна. Эдийн засаг хоёр оронтой тоогоор өсөж байна. Үүнийг дагаад усны менежментын асуудал, хотжилтын усны асуудал, хөдөө аж ахуйн усны асуудал, уул уурхайн усны асуудал чухлаар тавигдаж байна. Сүүлийн дөрвөн жилийн турш бид ДЭЗЧУ, Усны асуудлаарх байгууллагуудтай нягт хамтран ажиллаж байна. Үүний зэрэгцээ бид уул уурхайн олборлолтод усны асуудлаар менежменттэй болохыг зорьж буй бөгөөд Монгол орны хөгжлийн хурдацтай хөл нийлүүлж байгальд ээлтэй шийдэл, усны аюулгүй байдал онцлох сэдвийн нэг болж байна.

Мөн бид усны хөгжлийн зорилтыг тавьж байгаа бөгөөд НҮБ-ын санаачилгатай улам бүр эрчимтэй хамтран ажиллахыг эрхэмлэж байгаа. Монгол Улс цаашид усны асуудлаар бүс нутагтаа тэргүүлэгч байхын төлөө ажиллах болно. Бид усны асуудлыг шийдэж чадсанаар одоо тулгамдаад байгаа, цаашид хүн төрөлхтний өмнө улам бүр хурцаар тавигдах асуудлыг хамтдаа шийдэж чадна гэдэгт итгэлтэй байна. Улс төр, эдийн засгийн олон сорилт бидэнд тулгарсаар байх боловч усны асуудал бол хамгийн суурь асуудал учраас бид хамтран шийдэлд хүрэхийн төлөө ажиллах ёстой. Усны аюулгүй байдал бол эх дэлхийн аюулгүй байдал. Тиймээс бүгдээрээ эх дэлхийгээ аварцгаая хэмээжээ.

Economy студи, Mongolian Economy сэтгүүл чандмань эрдэнэ болсон усны асуудлаар байнга хөндөх болно. ■



COAL MONGOLIA-2014

ХАР АЛТНЫ САЛБАР ХАРИУЛТ НЭХЭХ ЦАГААР

Э.ЗОРИГТ

Хүлээлтээр үргэлжилсэн Монголын эдийн засаг хаа хүрэх нь эргэлзээтэй хэвээр. Учир нь өнгөрсөн онд уул уурхай тойрсон дотоод гадаад шалтгааны улмаас экспорт хүссэн хэмжээнд хүрээгүй ч хоёр оронтой тоон өсөлтөө хадгалж 11.7 хувийн өсөлт үзүүлсэн. Гэхдээ эдийн засгийн голлох үзүүлэлтүүд таагүй үзүүлэлттэй гарсан. Уул уурхайн өөдрөг төсөөлөл хатуу газардаж, ашигт малтмалд хэт найдсан монголчуудад том сануулга болсон гэдгийг тэмдэглэх нь зөв болов уу.

Монголын эрх баригчид өмнө нь гаргасан алдаагаа давтахгүйн тулд гаднын хөрөнгө оруулагчдыг далласан нэг бус хуулийг өнгөрсөн онд баталж өдгөө “Хөрөнгө оруулалт сайжирна” гэсэн хүлээлтээр дүүрэн сууна. Тухайлбал, төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын баримт бичиг, Хөрөнгө оруулалтын тухай хуулийг шинэчлэн баталлаа. Энэ хуулиар манай улсад хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдэх суурь нь тавигдсан гэдгийг бодлого тодорхойлогчид болон уул уурхайнхан дуу нэгтэй хүлээн зөвшөөрч байгаа. Тэр дундаа уул уурхайн салбар өөрийн гэсэн бодлоготой болсон нь хөрөнгө оруулагч болон дотоодын хувийн хэвшлийнхэнд таатай боломж. Гэхдээ хууль баталлаа гээд Монголын уул уурхай тэр дундаа нүүрсний өрсөлдөх чадвар дээшлэх болов уу.

Дээрх асуултын хариулт жилдээ нэг болдог олон улсын хэмжээний чуулга уулзалт болох “Coal Mongolia-2014”-ийн үеэр тодорхой болж магадгүй. Учир нь “Discover Mongolia”, “Metals Mongolia”, “Coal Mongolia” зэрэг чуулга уулзалтаар монголчууд олон асуултын хариуг олж авдаг. Тэгвэл энэ сарын 20-21-нд болох “Coal Mongolia-2014”-өөр Монгол Улсын нүүрсний салбарт хөрөнгө оруулагчдыг татах, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх. Мөн харилцан үр ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлж, Азийн бүс нутагт Монголын нүүрсний салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх гээд хар алтны салбарт тулгамдаж байгаа гол асуудлаар ярилцах юм байна. Мэдээж нөгөө талдаа гаднынхан бидэнд дахиад итгэх үү гэдгийг тандана. Энэ талаар “Coal Mongolia-2014” чуулга уулзалтын ерөнхий нарийн бичгийн дарга Б.Алтаншагай “Өнгөрсөн он нүүрсний салбарт таатай байгаагүй ч гэсэн хөрөнгө оруулагчдын Монголыг гэх хүлээлт нэлээд байсан тул



чуулганд оролцогчдын тоо буураагүй. Мөн өнгөрөгч онд Шинэчлэлийн Засгийн газар байгуулагдсан учир цаашид энэ салбарын бодлого хэрхэн тодорхойлогдох вэ гэдэг асуултын хариултыг чуулга уулзалт өгч чадсан. Энэ жилийн хувьд ч мөн адил оролцогчдын тоо харьцангуй сайн байхаар байна. Зохион байгуулалтын олон ажлууд ч хийгдэж байна. Тухайлбал, хөрөнгө оруулагчдыг гаднаас урьж, үнэ төлбөргүй оролцуулахаар төлөвлөж байгаа. Мөн өөр нэг анхаарч ажилласан зүйл бол олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн уул уурхайн мэдээллийн вэб сайт, сэтгүүлүүдээр мэдээллээ цацсан. Ингэснээр хилийн чанадаас оролцох зочид төлөөлөгчдийн тоо харьцангуй нэмэгдэх хандлагатай байна. Мөн хурал нь Монгол, Англи, Орос, Хятад хэл дээр явагддаг учир олон талын байр суурийг сонсох боломж бүрдэх юм” гэв. Энэ удаа чуулган үндсэн зургаан хэсгээс бүрдэх аж. Нүүрсний аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх стратегийн чиг хандлага, Нүүрсний зах зээл ба Монголын өрсөлдөх чадвар, төслийн санхүүжилт, Нэмүү өртөг шингэсэн аж үйлдвэрлэл, Нүүрс, занарын гүн боловсруулалт, Нүүрсний салбар дахь хөрөнгө оруулалтын төслүүд, техник технологи зэрэг асуудлууд дээр голлох илтгэлүүд тавигдаж хэлэлцүүлэг өрнөнө. Харин сүүлийн хэсэгт төр, хувийн хэвшлийн нээлттэй хэлэлцүүлэг уламжлалын дагуу болох ажээ.

“Coal Mongolia” чуулганаар жил бүр гаднын орны шинжээч, хөрөнгө оруулагч нарыг урьж илтгэл тавиулдаг. Энэ жил хувьд нүүрсний зах зээлд тэргүүлэгч “Peabody Energy” ▸▸

компанийн Азийн бүс хариуцсан ерөнхийлөгчийг Кристофер Хагедорн нь “Дэлхийн нүүрсний зах зээлийн 2014 оны төлөв байдал, цаашдын хандлага, Монгол Улсад үзүүлэх нөлөөлөл” илтгэлийг тавих бөгөөд мөн “Фэнвэй Энержи Консалтинг” компанийн дэд ерөнхийлөгч Вэнлин Суэ хүрэлцэн ирж урд хөршийн нүүрсний зах зээлийн талаар голлох илтгэлүүдийг тавих юм. Мөн Японы банк санхүүгийн тэргүүлэгч “Сумитомо Мицуи банкны корпораци”-ийн Монгол дахь суурин төлөөлөгч, Хятадын “Шэнву” корпораци, Германы “Оол Минерал” компани зэрэг олон улсад нэр хүндтэй байгууллагын төлөөлөл оролцох аж.
Мөн тус чуулганы үеэр хурал болон үзэсгэлэн нэг дор зохион байгуулдгаараа онцлог.

Хөтөлбөрт тодорхой зохицуулалт хийснээр хуралд оролцогч бүр үзэсгэлэнг үзэх боломжтойгоор зохион байгуулдаг. Энэ жил нийт 55 компани үзэсгэлэн гаргахаар болжээ. Нэг онцлог нь хамтран ажиллах гэрээ хийж, шийдвэр гаргах түвшний хүмүүс оролцож байгаа тул үзэсгэлэн гаргагч компаниудад бодит үр дүн нь шууд тусна гэдгийг чуулганыг зохион байгуулж буй ажлын хэсэг онцолж байсан.

Өөрийн гэсэн онцлогтой тус чуулганаар тив алгасан ирсэн хөрөнгө оруулагчид Монголын талаарх бодит төсөөлөл, ирээдүйн таамаг, зах зээлийн шинэ боломжийг хараад буцах нь дамжиггүй. Нөгөө талаар хүлээлтээр дүүрэн Монголын эдийн засгийг хөдөлгөх хүч болсон нүүрсний салбар хэр хурдтай урагшлах вэ гэдэг асуултын хариулт чтодорхой болно. ■

COAL MONGOLIA-2014

НҮҮРСНИЙ ИРЭЭДҮЙ

Э.ЗОРИГТ

Монголын нүүрсний салбарт өнгөрсөн онд зах зээлийн тааламжгүй байдал үүсэж уул уурхайн зарим компаниуд үйл ажиллагаагаа түр зогсооход хүрсэн. Олонх нь үйл ажиллагаагаа хумьсан. Гэсэн хэдий ч нүүрс өнгөрсөн онд улсын экспортын бүтээгдэхүүний 26,1 хувь, төсвийн орлогын 27,7 хувийг дангаараа бүрдүүлсэн байна. Тус эрдэсийн салбар цагийн сайханд улсын нийт экспортын 45 орчим хувийг бүрдүүлдэг байлаа.

Гэхдээ уруудлаа гээд Монголын эдийн засаг дахь нүүрсний байр суурь тийм ч амархан ганхахгүй. Харин ч Засгийн газар уул уурхайн салбарт төрөөс баримтлах бодлоготой болоод авсан. Бодлогод тусгаснаар экспортын гаралтай бүтээгдэхүүн тэр дундаа нүүрсийг онцгой анхаарахаар болжээ. Графикаас харахад нүүрсний экспорт тогтмол өсөхөөр байна. Ингэж тооцсоны учир нь манай улс нүүрс олборлолтоо нэмэгдүүлж, экспортлох ихээхэн нөөц боломжтой аж. Сүүлийн жилүүдэд нүүрс экспортлогч томоохон аж ахуйн нэгжийн төлөөлөлд “Эрдэнэс Таван Толгой” ХК, “Тавантолгой” ХК, “Монголын Алт” (МАК) ХХК, “Саусгоби Сэндс” ХХК, “Энержи ресурс” ХХК, “Чинхуа-МАК Нарийнсухайт” ХХК зүй ёсоор орж байгаа. Гэтэл тэдний экспортолсон нүүрсний хэмжээ /2013 оны байдлаар 18,18 сая.тн/ байгаа нь уудам Монголоос ухаад гаргаж болох нүүрсний нөөцийн өчүүхэн хэсэг нь.

Монгол Улсад нүүрсний 15 сав газрын хүрээнд хамрагдах нийт 300 гаруй орд, илрэл байгааг тогтоожээ. Өнгөрсөн оны эхний хагас жилийн байдлаар манай улсын нүүрсний геологийн таамаг нөөц 173.3 тэрбум тонн. Харин нарийвчилсан хайгуулаар тогтоогдсон нөөц 23.5 тэрбум тонн болж нөөцөөрөө дэлхийд эхний 10-т багтаж байна. Монгол Улсын нүүрсний баялаг нь нийт газар нутгийн хэмжээнд харьцангуй жигд тархсан байдаг онцлогтой. Нутгийн зүүн бүсэд хүрэн, төв, хангайн болон баруун бүсэд чулуун болон коксжих нүүрс зонхилдог. ▸▸


Нүүрсний салбарын төсөөлөл (мянган тонн)



Монгол Улсын нүүрс олборлолт, экспорт /мян.тонн/




Ашиглалтын тусгай зөвшөөрөл бүсээр




Хятад улс нь дэлхийн хамгийн том нүүрс импортлогч орон. Хятадын Нүүрсний аж үйлдвэрийн нийгэмлэгийн дарга Ван Шяньжэн “Бидний урьдчилсан тооцоогоор 2020 он гэхэд Хятадын нүүрсний хэрэглээний нийт хэмжээ таван тэрбум тоннд хүрэх төлөвтэй байна. Манай улсын нүүрсний аж үйлдвэрийнхэнд хөгжлийн асар том зах зээл бий” гэсэн удаатай. Хэдийгээр тус улсын нүүрсний эрэлт сүүлийн жилүүдэд буурсан ч эрчим хүчний хэрэгцээ нь нэмэгдсээр байгаа. Тиймээс ойрын 10-15 жилийн хугацаанд урд хөршийн эрчим хүчний гол хэрэгцээ нь нүүрс байх нь дамжиггүй. Тийм болохоор ойрын жилүүдэд манай улсын нүүрсний зах зээл Хятадын нүүрсний эрэлтээс шууд хамааралтай байх төлөвтэй байгааг Ашигт малтмалын газрын гаргасан “Монгол Улсын нүүрсний салбарын өнөөгийн байдал” судалгаанд дурджээ. Хэдийгээр газар зүйн байршил ойрхон, нүүрсний чанар сайн байлаа гээд Монголын нүүрс урд хөршид ногоон гэрлээр зарагдахгүй. Урд хөрш сүүлийн жилүүдэд Австрали, Казахстан, ОХУ зэрэг улсаас нүүрсний импортоо нэмэгдүүлж байгаа энэ үед манай улсын боломж улам л багассаар. Төмөр замын тээвэрлэлтийн сүлжээг ашиглалтад оруулж мөн баяжуулснаар Монголын нүүрс Хятадын зах зээлд үнэ болон чанарын хувьд өрсөлдөхүйц болох боломжтой гэдгийг энэ талын мэргэжилтнүүд түлхүү ярьж байгаа. Сүүлийн үеийн мэдээллээс харахад Тавантолгойгоос Гашуунсухайт хүртэлх 225 км төмөр замын газар шорооны ажил 70 хувьтай явж байна. Ирэх хаврын чуулганаар царигийн асуудлыг шийдчихвэл энэ ондоо багтаад нүүрсээ урд хөрш рүү төмөр замаар зөөх боломж бүрдэх юм.

БНХАУ-ын нүүрсний импортын бүтэц



Төмөр замаас гадна нүүрсээ боловсруулж нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь монголчуудын хувьд нэн тэргүүний асуудлуудын нэг юм. 2011 онд нийт олборлосон нүүрсний 6.8 хувийг боловсруулж байсан бол 2012 онд 19 хувь, өнгөрсөн онд онд 32.2 хувийг боловсруулсан байна. “Энержи Ресурс” ХХК-ийн нүүрс баяжуулах үйлдвэр өнгөрсөн оны аравдугаар сард бүрэн хүчин чадлаараа (15 сая тонн) ашиглалтад орсон нь нүүрсний нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд томоохон байр эзэлж байна. Ямартай ч хувийн хэвшлийнхний нүүрс боловсруулалт жил тутам өсч байгаа нь сайшаалтай. Гэхдээ нөгөө талдаа төрийн өмчит компаниудын технологи хоцрогдоод эхэлжээ. Тухайлбал, төрийн өмчийн оролцоотой “ Багануур” ХК, “ Шивээ-Овоо” ХК болон хувийн “ Шарын гол” ХК, “ Адуун чулуун” ХК зэрэг дотоодын эрчим хүчний нүүрсний хэрэгцээг хангаж байгаа уурхайнуудын уулын үндсэн тоног төхөөрөмжүүдийн ашиглалтын хугацаа үндсэндээ дуусч техник технологийн шинэчлэл хийх шаардлага үүсээд байгаа аж.

Ухаа худагийн нүүрс баяжуулах үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл



Монгол Улсын ерөнхий сайдын БНХАУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр Монгол Улсын Уул уурхайн яам, Хятадын “Чайна Петрокемикал” компанитай жилд 50 сая тонн хүрэн нүүрсийг хийжүүлж 15 тэрбум шоо метр шатдаг хий үйлдвэрлэх төсөл хэрэгжүүлэх санамж бичгийг байгуулсан. Санамж бичгийн хүрээнд хийгдэх ажлыг зохион байгуулах Ажлын хэсэг байгуулагдаад байгаа. Ажлын хэсгийн мэдээлж байгаагаар манай улс нүүрс хийжүүлж шатдаг хий үйлдвэрлэх, нүүрсний давхаргын метан хийг олборлох, занараас хий гарган авах төсөл хэрэгжүүлэх. Мөн хүрэн нүүрснээс байгалийн хий, экологийн цэвэр түлш үйлдвэрлэн дотоодын хэрэгцээг хангаж, улмаар гадаад зах зээлд экспортлох боломжтой. Энэ хүрээнд одоогоор судалгааны ажлууд хийгдэж буй аж. Тухайлбал, Монголын Байгаль орчны консерциум, Америкийн байгаль орчны агентлагийн төлөөлөл болох “Равен Ридже Ресурсез Инкорпорэйтэд” компанитай хамтран хэрэгжүүлж байгаа “Уурхайгаас ялгарах хүлэмжийн хийг үнэлэх” төслийг дурдаж болох юм. Энэ хүрээнд МАК ХХК-ийн Нарийн сухайтын нүүрсний ордын V давхаргын (газрын гадаргаас 500 метр хүртэлх гүнд) метан хийн таамаг нөөцийг 728,97 сая шоо метр гэж тодорхойлсон. Энэ төслийн үйл ажиллагааг Ашигт малтмалын газрын Нүүрсний хэлтэс дэмжиж ажилладаг ба төслийн хүрээнд Нарийн сухайтын уурхайн тавдугаар давхаргын нөөцөд тулгуурлан 8.55 мВт-ын хүчин чадалтай хийн станц байгуулж, ашиглах боломжийн урьдчилсан эдийн засгийн үндэслэл боловсруулжээ. Энэ онд дээрх төслийн хүрээнд Багануур, Хотгор шанагын нүүрсний уурхайгаас нүүрсний дээж авч, таамаг нөөцийг тогтоох ажил үргэлжилж байгаа аж.

Нүүрсний салбарын үйлдвэрлэгч, хөрөнгө оруулагчдын хувьд зах зээл эргэн сэргэхийн хүлээж сууна. Гэгээн ирээдүй бий гэдэгт итгэе. ■

Ашигласан эх сурвалж: Ашигт малтмалын газар, Хятадын олон улсын радио, Хятадын нүүрсний аж үйлдвэрийн нийгэмлэг.



Эдийн засгийн хөгжлийн яамын дэд сайд О.Чулуунбаттай ярилцлаа.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

О.ЧУЛУУНБАТ: УУЛ УУРХАЙН КОМПАНИУДАА УРАГШ АЛХУУЛАХ ХЭРЭГТЭЙ

Б.ТОГТОХ

-Өнгөрсөн хугацаанд гаднын хөрөнгө оруулагчдад ээлтэй хэд хэдэн хуулийн төслийг УИХ баталлаа. Ингэснээр энэ онд хөрөнгө оруулалт сэргэх хандлага байна уу?

-Гадаадын хөрөнгө оруулалт өнгөрсөн онд бараг 50 хувиар буурсан. Энэ нь манай улсын эдийн засагт хүндээр нөлөөлж байна. Монголчуудын ерөнхий орлогын хэмжээ буурлаа. Үүнийг дагаад ажлын байр дорвитой тэлсэнгүй. Улсын төсвийн орлого өмнөх онуудад байгаагүйгээр өндөр алдагдал хүлээлээ. Мөн гадаад худалдааны алдагдал нэмэгдэж, инфляци зорилтот түвшинд хүрсэнгүй. Төгрөгийн ханш суларсан. Арилжааны банкуудын муу зээл өссөн. Эдгээр үүссэн нөхцөл байдлаас хурдан гарах үүднээс Хөрөнгө оруулалтын тухай хуулиа шинэчлэн баталлаа. Гэхдээ өргөс авсан юм шиг асуудал урьдын хэвэндээ орохгүй. Хөрөнгө оруулалт нь итгэлтэй холбоотой. Энэ итгэл сэргэсэн тохиолдолд хөрөнгө оруулалт нэмэгдэнэ. Нэг талаасаа худалдаа наймаа хийх гэдэг чинь бас л “амьдрал”-ынхаа ханиа сонгож байгаатай адил зүйл.

-Эдийн засагт үүссэн нөхцөл байдлаасаа манай улс сургамж аваа болов уу?

-Монголын хууль эрх зүйн орчинд ажиллаж амьдрах гэж байгаа хүмүүс удаан хугацаанд асуудалд нэлээд болгоомжтой хандаж, харзнаж байгаа байх. Хөрөнгө оруулагчдын итгэл сэргэхэд тодорхой цаг хугацаа шаардлагатай. Өнөөдөр эрх зүйн орчин сайжирсан гээд маргааш тэд ирэхгүй нь лавтай. Бид хүний итгэлийг амархан унагаж болдог юм байна гэдэгт том сургамж авлаа. Үүнээсээ суралцах хэрэгтэй. Алдаагаа давтахгүйн төлөө хичээж ажиллах нь чухал. Мөн аливаа асуудалд ухаантай хандаж байхыг ойлгууллаа. Хэт туйлшрах нь эрсдэлтэй болохыг харууллаа. Төрийн бодлогод залгамж чанартай хандах учиртай. Бид залгамж чанараа орхигдуулсан тал бий. Монгол Улсыг аль нэг улс төрийн намын гэж хамаатуулж хөрөнгө оруулагчид харахгүй. Бүхэлдээ Монгол гэсэн нэр цаана нь яваа учраас дотооддоо

нэгдсэн ойлголтод хүрч, нэгнээ ойлгох учиртай. Түүнээс өмнөх төр, засгийн бодлого, шийдвэрээ үгүйсгэж яваад амжилт болохгүй. Бүгдийг өөрсдийн дураар өөрчилж, дурааараа авирлаад байвал иймэрхүү байдалд ордог гэдгийг дээрх байдал нотоллоо.

-Гадаадын зах зээлд арилжаалж буй хувьцааны ханш сайнгүй байгаа. Та үүнийг хэрхэн харж байна вэ?

-Монгол Улстай холбогдсон томоохон төслүүдийн хувьцаа гадаадын хөрөнгийн захуудад арилжаалагдаж байна. Эдгээр хувьцааг Сингапур, Лондон, Хонконг, Торонто гээд дэлхийн нэр нөлөө бүхий биржүүдэд арилжаалж байгаа. Дээрх биржүүдэд арилжаалж буй Монголын хувьцаануудын үнэлгээ сайжирч өгсөнгүй. Жил хагасын өмнө Монголын хөрөнгийн зах зээлд оролцож байгаа хувьцааны нийт үнэ бараг 30 тэрбум ам.долларт дөхөж байсан. Тэгвэл өнөөдөр гурав гаруйхан тэрбум төгрөгийн үнэлгээтэй байна. Бид өөрсдийнхөө үнэлгээг арав дахин унагалаа. Уг нь гадаадын зах дээр манай үнэлгээ сайн байна гэдэг таатай үзүүлэлт. Иргэний хөдөлгөөн болон зарим улстөрчид гадаадынхан манай баялгийг гадаадад зараад ашиг олоод байна гэж туйлширдаг. Энэ буруу ойлголтоосоо салах хэрэгтэй. Дээр дурдсан алдааг гаргахгүй байхын төлөө дор бүрнээ зөв үйлдлээрээ харуулах хэрэгтэй. Ямар нэгэн үйлдэл хийх гэж байвал өмнө нь долоо хэмжиж, нэг огтолж үзэх. Наана нь тухайн асуудлаа долоо дахин боддог байх хэрэгтэй.

-Монгол Улсын эдийн засаг өнгөрсөн онд 11.7 хувиар өссөн. Энэ өсөлт иргэдийн амьдралд хэр өгөөжтэй байсан гэж Та бодож байна вэ?

-Би хувьдаа улс төрийн өнгөгүйгээр одоогийн эдийн засгийн өсөлтөд шүүмжлэлтэй хандаж байгаа. Өмнөх УИХ-д орж ажиллаж, бодлого тодорхойлж байсан хүний хувьд хэлэхэд энэ жилийн эдийн засгийн өсөлт иргэдэд наалдаагүй. Төгрөгийн ханш унаад ирэхээр иргэдийн худалдан авах чадвар эрс багассан. Ийм нөхцөлд эдийн засгийн өсөлт иргэдэд буухгүй.

-Эдийн засагт өсөлтийг хүртээмжтэй болгох чиглэлд юуг хийвэл илүү анхаарвал зохилтой вэ?

-Эдийн засгийн өндөр өсөлтөө хүртээмжтэй болгохын тулд төсөв, мөнгөний бодлого хоорондоо уялдаж байх ёстой. Мөнгөний бодлого нь эдийн засгийн бодлогоо дэмжих. Өнгөрсөн жилийн эдийн засгийн өсөлтийн ихэнх хувийг зээл бүрдүүлсэн гэж хэлж болно. Үүнд, Хөгжлийн банкны 500, Чингис бондын 1.5 тэрбум ам.доллар багтаж буй. Нийтдээ хоёр тэрбум ам.долларыг эдийн засаг руугаа хийлээ. Үр дүнд нь ажлын байр шинээр бий болж, иргэдийн орлого өссөн. Энэ мөнгө байхгүй байсан бол эдийн засаг бүр ч хүндрэх байсан. Учир нь бондын мөнгөөр гадаадын хөрөнгө оруулалтаа нэхлээ. Өнгөрсөн жилийн өсөлтийг 11.7 хувь гэж яриад байгаа. Энэ нь төгрөгөөр гаргасан тооцоо. Үүнийг ам.долларааар тооцох юм бол бараг өсөлт гарахгүй. Ийм болохоор манай иргэдэд эдийн засгийн өсөлт наалдахгүй байгаа юм.

-Эдийн засгийн үзүүлэлтүүд нэлээд муу гарсан байсан.

-Улаанбаатарт ажлын байр ихээр бий болгож буй үйлчилгээний салбарын бүх орлого буурсан. Үйлчилгээний салбараас манай компанийн орлого өссөн гээд хэлэх хүн гарч ирэхгүй л байх. Олон компани, аж ахуйн нэгжийн захиралтай уулзлаа. Эдгээрээс орлого нь өссөн компани нэг ч таарсангүй. Манай ачаа эргэлт багассан. Энэ бүхэн бизнес орлоготой хамаатай. Үүнээс гадна Монголын иргэний агаарын тээврээр зорчсон иргэдийн тоо буурсан. Мөн манайд ирсэн жуулчдын тоо чамлалттай. Энэ бүх үзүүлэлт эдийн засаг идэвхгүй байдалд орсны шинж тэмдэг. Үүндээ дүгнэлт хийх. Ингэснээр хууль эрх зүйн орчноо тодорхой, тогтвортой болгохын төлөө ажиллах үлдлээ.

-Манайхаас авч буй бодлогын өөрчлөлт хөрөнгө оруулагчдад хүрсэн болов уу?

-Бид цаасан дээр хууль гаргаад өөрсдөө ярихаас илүү түүнийгээ үйлдлээрээ харуулах хэрэгтэй. Хөрөнгө оруулалтын орчныг сайжруулаа гэж байна. Үнэхээр хөрөнгө оруулалтын сайжирсан эсэхийг бодитоор харуулах хэрэгтэй. Одоо уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниуддаа ямар нэгэн хориг саад тавихгүйгээр урагш нь явуулах хэрэгтэй. Оюутолгойн асуудлаас болоод бэлэн болсон цөөнгүй төсөлд хүлээлт үүсээд байна.

-Баялгийн сангийн тухай хуулийн төслийг Сангийн яам боловсруулсан. Уул уурхайгаас олж буй орлогоо хэрхэн үр ашигтай зарцуулах вэ?

-Монголчууд төрөхдөө л баялгийн сантай төрчихсөн хүмүүс. Бидний өвөг дээдэс энэ газар шороог өвлүүлэхдээ хамтад нь баялгийн санг үлдээсэн. Газрын хэвлийд баялгийн сан байна. Гол нь үүнийгээ мөнгөн хэлбэрт оруулах. Араб гэхэд л 50 жилийн өмнө дэлхийн ядуу орнуудын нэг байсан. Тэгвэл өнөөдөр тэд баялгаа мөнгөн хэлбэрт шилжүүлж чадсан. Энэ нь өдгөө хөгжлийг тэтгэж байна. Өмнөд Солонгос, Сингапур, БНХАУ хөлс гаргаж байж мөнгө хийж байна. Харин бидний хувьд буй болсон баялгаа эхний ээлжинд мөнгө болгох л хэрэгтэй.

-Ойрын жилүүдэд манай улсын эдийн засгийн хөгжих гол тулгуур юу вэ?

-Уул уурхай. Тиймээс энэ салбарт аль болох нээлттэй бодлого явуулах хэрэгтэй. Миний хувьд хэдий Засгийн газарт ажиллаж байгаа ч төрийн оролцоог багасгах. Төр бүхнийг шийднэ, хийнэ гэж зүтгэх бус хувийн хэвшилд боломж олгох талд зогсдог. Төр зөвхөн сайн зохицуулалт хийх замаар татвараа аваад явахад хангалттай. Төр хэтэрхий хувийн хэвшлийн хийх ажилд оролцож байгаа нь үнэн. Бүгдийг төр хийх гэж байгаа нь эргээд хөгжлийг царцаагаад байна шүү дээ. Заавал юм бүхэнд төр оролцоод байх шаардлагагүй. ■



Ашигт малтмалын газрын Нүүрсний хэлтсийн дарга Б.Алтсүхтэй ярилцлаа.

УУЛ УУРХАЙ

Б.АЛТСҮХ: НЭГ ЦОНХНЫ БОДЛОГООР НҮҮРСЭЭ ГАРГАХ НЬ МАНАЙД АШИГТАЙ

Б.АЛТАЙ

-“Coal Mongolia-2014” олон улсын чуулга уулзалт удахгүй болно. Тус чуулга уулзалт Монголын нүүрсний салбарт ямар өөрчлөлт авчирсан бэ?

-Дэлхий дахинд тэр тусмаа өнөө цагт мэдээлэл маш чухал баялаг болж хувирлаа. Хэн мэдээлэл сайтай байна, түүнд илүү боломж олддог болж. Мэдээлэлгүй болохуйц байвал ямар нэгэн бизнесийн үйл ажиллагаа урагшаа явахгүй. Тухайн компани зөв менежмент явуулж чадахгүй, гар мухардаж буйн шинж. “Coal Mongolia” зохион байгуулагдаад дөрөв дэх жилтэйгээ золгож байна. Тус чуулга уулзалт болсноор Монгол Улсын талаарх мэдээлэл олон нийтэд нээлттэй болж байна. Энэ талаараа ихээхэн ач холбогдолтой. Монгол Улс хэчнээн тонн нүүрсний нөөцтэй, үүнийгээ хэрхэн экспортлох сонирхолтой эсэхийг мэдэж болно. Мөн нүүрсний салбарт ямар боломж байгаа, шинээр гарч ирж буй компаниудад төдийгүй хөрөнгө оруулагчдад шинэ мэдээлэл авах индэр болохуйц арга хэмжээ юм. Нэг үгээр хэлбэл, бизнесийн анхан шатны угтвар эндээс эхлэх нь бий.

-Эрдэс баялгийн бирж байгуулж, түүгээр дамжуулан түүхий эдээ арилжаалах санал уул уурхайн салбарт нэг биш удаа гарч байсан. Жишиг үнээр бус биржийн үнээр бүтээгдэхүүнээ худалдах саналтай та санал нийлдэг үү. Нүүрсний салбарт жишиг үнэ байх шаардлагатай юу?

-Жишиг үнийн асуудалд компаниуд шүүмжлэлтэй ханддаг. Харин би ийм үнэ байх ёстой гэж үздэг. Өмнө нь жишиг үнэгүй явж үзсэн. Хяналтгүй орхих гэхээр хүн болгон өөрсдийн дураар үнэ гаргаж, нүүрсээ зардаг. Манайхан зах зээл дээр нүүрсний үнийг өсгөж өрсөлдөг байсан бол жишиг үнэгүй болсноор бууруулж өрсөлддөг муу талтай. Иймд Монгол тусгаар улс учраас ашигт малтмалаа ийм үнээр гаргана, та үүнд зохицуулаад гарга, чадахгүй бол баяртай гэж хэлэх эрхтэй. Ийм чиглэл барьж байгаа. Өөрөөр хэлбэл, үүнээс бага үнэ санал болгохыг манайх зөвшөөрөхгүй. Гэхдээ энэ чигтээ хатуу зогсох биш хүндрэлтэй нөхцөлд буюу эдийн засаг хямралтай, үнэ унасан үед уян хатан хандана. Тухайлбал, тал талын сонирхолд нийцсэн жишиг үнэ гэдэг ч юм уу, квот тогтоох шаардлага бий.

Харин уул уурхайн бүтээгдэхүүний биржийн асуудалд санал нэг байна. Засгийн газрын мөрийн хөтөлбөрт бирж байгуулж, нэг цонхны бодлогоор нүүрсээ гаргах тухай тусгагдсан. Компаниуд хэдэн тонн нүүрс бариад захын наймаачин шиг явбал энэ нүүрсний худалдаа биш болно. Нүүрс худалдах, экспортлох ажлыг гадаад худалдаагаар мэргэшсэн байгууллага хийх ёстой. Аж ахуйн нэгж бүр өөр, өөр үнэ санал болгож буй нь нүүрсийг үнэгүйдүүлж байна. Тиймээс нэгдсэн нэг цонхны бодлогоор буюу биржээр нүүрсээ худалдах нь зөв. Гэхдээ олон улсад нэр хүндтэй мэргэшсэн, гадаад худалдааны компаниар дамжуулж экспортыг хийх хэрэгтэй юм.

-Манай улс нүүрснийхээ өрсөлдөх чадварыг сайжруулахад хэр анхаарч байна вэ. Угаах болон баяжуулах үйлдвэрийн төсөл энэ онд шинээр хэрэгжих үү?

-Нүүрс боловсруулах ажил эрчимтэй явагдах ёстой. 2013 онд Ухаахудагийн нүүрс угаах үйлдвэрийг хүлээж авлаа. Нэг үгээр хэлбэл, гуравдугаар модуль ашиглалтад орсон гэсэн үг. Ингэснээр манайх жилд 15 сая тонн нүүрс баяжуулах хүчин чадалтай болж байна. Мөн Хөшөөтийн уурхайд хуурай баяжуулах үйлдвэр баригдсан. Үүнтэй

ижил үйлдвэрийг “Саус Гоби Сэндс” барьсан.

-Жил бүрийн “Coal Mongolia” чуулганы чухал сэдвийн нь нэг нүүрс хийжүүлэх, шингэрүүлэх төсөл байдаг. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд энэ чиглэлд ямар ахиц дэвшил гарсан бэ?

-Нүүрс шингэрүүлэх, хийжүүлэх төслүүд амжилттай хэрэгжиж байгаа. Одоогоор нүүрс шингэрүүлэх дөрвөн төсөл байна. Тухайлбал, MCS компанийн Өмнөд Солонгостой хамтарсан төсөл хэрэгжих шатандаа явж байгаа. Төслийн техник эдийн засгийн үндэслэл нь батлагдсан. Мөн МАК-ийн Аduунчулууны нүүрсний ордод тулгуурлаж барих нүүрс шингэрүүлэх үйлдвэрийн зураг төсөл хийгдсэн. Эрдэс баялгийн зөвлөлөөр зураг төслийг нь баталсан. Удаах нь Цайдам нуурын нүүрсний ордыг түшиглээд “Цэцэнс майнинг” компани нүүрс шингэрүүлэх үйлдвэрийн зураг төслийг боловсруулж байна. Төслийн багийнхан судалгааны ажлаа хийж байгаа. Дөрөв дэх нь Төгрөг нуурын нүүрсний ордыг түшиглэн “Монголын аж үйлдвэрийн корпораци” зураг төслийн ажлаа хийж эхэлсэн.

- Ерөнхий сайд БНХАУ-д албан ёсны айлчлал хийх үеэр нүүрс хийжүүлэх төсөлд хоёр тал санамж бичиг үзэглэсэн. Энэ хүрээнд ямар ажил хийж байгаа бол?

-Хятадад хийсэн Ерөнхий сайдын айлчлалын хүрээнд жилд 15 тэрбум тонн шоо метр нүүрс шингэрүүлэх хий үйлдвэрлэх. Үүнээс турба хоолойгоор зөөж экспортлох санамж бичигт гарын үсэг зурсан. Энэ хүрээнд хоёр тал нэлээд олон уурхайн нүүрсийг судалж байна. 15 тэрбум тонн шоо метр хий үйлдвэрлэнэ гэдэг маш том төсөл. Маш их нүүрс орно. Энэ хэмжээний хий гаргахын тулд жилд 50-60 сая тонн нүүрс олборлох шаардлагатай болно.

-Тухайлбал, нүүрсний аль ордуудыг судалж байгаа вэ. Энэ тухай тодорхой мэдээлэл өгөхгүй юу?

-Цайдам нуурын, Чандгана талын, Эрдэнэцогт, Тэвшийн говийн гээд хэд хэдэн ордыг санал болгож байгаа. Гол нь их ус шаардлагатай тул хоёр талын судалгааны хамтарсан ажлын хэсэг ажиллаж байна. Хэрвээ дээрх төсөл хэрэгжвэл нэлээд олон талын ач холбогдолтой.

-Нүүрс боловсруулалтын талаарх таны бодлыг сонирхоё?

-Аливаа зүйл сайн, муу хоёр талтай. Бид нүүрсийг боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн болгоно гэж хэт туйлширч болохгүй. Нүүрс боловсруулах нь мэдээж Монгол Улсад ашигтай. Энэ тохиолдолд бүтээгдэхүүний чанараар өрсөлдөх хэрэг гарна. Тээвэрлэлтийн явцад янз бүрийн хольц тээхгүй гэсэн үг. Жинхэнэ цэвэр бүтээгдэхүүн тээвэрлэвэл нүүрсний үнэ өсөх

> Нүүрс шингэрүүлэх, хийжүүлэх төслүүд амжилттай хэрэгжиж байгаа. Одоогоор нүүрс шингэрүүлэх дөрвөн төсөл байна. Тухайлбал, MCS компанийн Өмнөд Солонгостой хамтарсан төсөл хэрэгжих шатандаа явж байгаа.

сайн талтай. Гэвч сөрөг талууд бас байна. Тухайлбал, Монгол орон ус ховортой. Ялангуяа говийн бүсэд. Нүүрсийг боловсруулахын тулд ус их шаардлагатай. Усны нөөц хэр байгаа билээ. Дараагийн бэрхшээл нь хог хаягдал манай нутагт үлдэнэ. Бас нэг бэрхшээл гэх юм уу, сул тал бидэнд байгаа. Энэ нь зах зээл хязгаарлагдмал. Хэрэглэгч, худалдан авагчийнхаа ашиг сонирхолд нийцүүлэх. Тэдний үйл ажиллагааг харгалзан үзэх нь хамгийн чухал асуудал. Үүнийг тооцохгүйгээр туйлширч, заавал боловсруулсан, угаасан нүүрсийг гаргана гэвэл эрсдэлтэй.

-Зах зээл тааламжгүй байсан ч гэсэн шинэ уурхай нээгдсэн үү?

-Монгол Улс нүүрсний нөөцөөрөө дэлхийд эхний аравт орж байна. Нарийвчилсан хайгуулын нөөц 23.5 тэрбум тонн. Энэ он гарсаар манайд уулын ажлын төлөвлөгөөгөө 44 уурхай батлуулахаар өгсөн. Өнгөрсөн жилүүдийн байдлаас харахад дээр дурдсан уурхайнуудын зарим нь хаалгаа барихад хүрээд байгаа. Эндээс 30 орчим нь л идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Шинээр ашиглалт явуулах нь уурхайнууд үйл ажиллагаа нь жигдэрсэн бусад уурхайтайгаа өрсөлдөх чадвар, дэд бүтэц, туршлага муутай учраас хөрөнгө оруулалт гацаад байна. Одоо байгаа уурхайгаа бүрэн хүчин чадлаар нь зохистой, хаягдалгүй ашиглах.

Мөн чанарыг нь дээшлүүлэхэд зорьж байна. Өнгөрсөн жилийн сүүлч, энэ оны эхээр Өмнөговь аймгийн Ноён сумын нутаг дахь Баруун ноёнгийн уурхай ашиглалтад орж, хүлээж авсан. Тус уурхай эхний жил 500 мянган тонн нүүрс экспортолно. Мөн 2013 оны төгсгөлд “Шарын гол”-ын уурхайд нүүрс боловсруулах үйлдвэр барихаар төсөл нь хэрэгжээд, хөрөнгө оруулалтын асуудал нь шийдэгдсэн. Нүүрсний салбарт урт хугацааны хөрөнгө оруулалт, сайн техник технологи нэвтрүүлэхэд бидний зүгээс зохих анхаарлыг хандуулж, шаардлагыг тавьж ажиллаж байгаа. Олон уурхай ашиглах нь гол биш. Тоймтой, үр бүтээлтэй, хэдэн томоохон уурхайг ашиглаж, экспортоо нэмэгдүүлэх зорилготой.

-“Монгол нүүрс” хөтөлбөрөөс ямар үр дүн хүлээж болох вэ?

-“Монгол нүүрс” хөтөлбөрийг 2003 оноос боловсруулж эхэлсэн. Харин одоо Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын баримт бичиг гарлаа. Энэ бодлогын хүрээнд ашигт малтмалын төрөл тус бүрээр хөтөлбөрийг гаргахаар төлөвлөөд ажиллаж байна. “Монгол нүүрс “хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Энэ оны эхний улиралд багтаан хөтөлбөрийг Засгийн газарт өргөн барих зорилготой. Нүүрсний боловсруулалтыг улам гүнзгийрүүлэх. Нүүрсийг шингэрүүлэх, хийжүүлэх, экспортлохоор зорьж байна. Нүүрсээ боловсруулж химийн бүтээгдэхүүн гаргах боломжтой. ■

ХӨРШ

БНХАУ-ЫН БАНКНЫ САЛБАР

Р.ГАНТУЛГА

БНХАУ-ын хамгийн анхны хувийн банк бол 1996 онд байгуулагдсан Minsheng Bank Corp юм. Түүнээс хойш тус улсын Засгийн газар хувийн банк байгуулах зөвшөөрөл олгох тал дээр тун хатуу байр суурьтай байсаар иржээ. Гэхдээ цөөхөн тооны хувийн банк үйл ажиллагаа явуулдаг байна. Хувийн банк хөрөнгийнхөө багахан хувь, хэмжээгээр арилжааны банкуудад хөрөнгө оруулах эрхтэй байдаг аж. Гэхдээ энэ байдал тун удахгүй өөрчлөгдөх нь бололтой. Учир нь Хятадын Засгийн газар хувийн хэвшлийнхэнд банк, санхүүгийн салбараа нээж өгөх гэж байна.

Урд хөршид өдгөө таван төрийн өмчит арилжааны банк, бодлогын гурван банк, хувьцаат 12 банк, 144 хотын арилжааны банк, 47 гаднын хөрөнгө оруулалттай банк үйл ажиллагаа явуулж буй аж. Эдгээрээс гадна хөдөө, орон нутагт олон банк бий. Банкны салбарт хувийн банкууд орж ирснээр тухайн өрсөлдөөн ширүүсэх нь дамжиггүй.

Одоогийн байдлаар хувийн банк байгуулах 40 хүсэлтийг тус улсын Үйлдвэр, худалдааны төрийн захиргаанд хүлээн авч, урьдчилсан зөвшөөрөл олгоод байгаа аж. Гэхдээ жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд зориулсан зээлийн үйлчилгээ сайн хөгжөөгүй байсан үед байгуулагдаж байсан Minsheng банкны амжилт өнөөдөр давтагдах нь юу л бол. Учир нь өдгөө хэрэглэгчдийн анхаарлыг татахуйц санхүүгийн олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр банкууд өөр хоорондоо өрсөлдөж буй. Зарим хувийн банк эрсдэлийн хяналтын тогтолцоогоо эрүүл, хэвийн байлгах шаардлагатай болсон. Эс тэгвэл дампуурахад ойрхон байгаа аж.



Хувийн банк байгуулах зөвшөөрөл авах хүсэлтийг хоёр ангилан авч үзэж буй. Нэгдүгээрт, банк, санхүүгийн салбарт илүү хялбар ашиг олох санхүүгийн сувгийг эрэлхийлж буй хувийн хэвшил болон бизнесийн байгууллага. Тухайлбал, Sun-ing Commerce Group Co Ltd. Энэ компани гэр ахуйн цахилгаан барааны жижиглэнгийн худалдаа эрхэлдэг. Хоёрдугаар ангилалд өөрийн гэсэн банктай болох гэсэн “өндөр амбицтай” компаниуд орж байна. Үүнд, Tencent Technology (Shenzhen) Co Ltd зэрэг интернэтийн компаниуд багтаж байх жишээтэй.

Энэ мэтчилэн цахим худалдаа, үл хөдлөх хөрөнгө, хүнс, хувцас, цахилгаан бараа, технологи, нисэх зэрэг салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниуд банк, санхүүгийн салбарт өөрийн гэсэн байр суурьтай болохыг эрмэлзэж байгаа аж. Ингэж их тэмүүлэхийн шалтгаан нь чухам юу юм бол?

Энэ нь Хятадын банкны салбар ихээхэн ашиг олж буйтай холбоотой гэх. Өнгөрсөн оны хагас жилийн ашгийн тайлангаас харахад “А” хувьцаа буюу юаниар хувьцаа эзэмшигч 2,467 компани Хөрөнгийн биржэд бүртгэлтэй 16 банкнаас нийт 619 тэрбум юань буюу 102.1 тэрбум ам.долларын цэвэр ашиг хүртжээ. Энэ нь 2012 оны мөн үеийнхээс 13.54 хувиар өссөн үзүүлэлт аж. Энэ нь мөн нийт юанийн хувьцааны ашгийн 54.3 хувийг эзэлж буй. Банкууд хоорондын ашгийн зөрүү сүүлийн үед багасч байгаа. Гэхдээ эндээс олох цэвэр ашиг хувийн хэвшлийнхний анхаарлын төвд байсаар л байна.

Хувийн банкууд олноор байгуулагдвал хувийн хэвшлийнхний зээл, санхүүжилт авахад тулгардаг бэрхшээлийг хөнгөвчлөх боломжтой аж. Бээжинд төвтэй Qianzhan Industry Research судалгааны групп судалгаа

хийжээ. Үүнд жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн 1.3-хан хувь нь шууд санхүүжилт хийх боломжтой аж. Бусад нь банкны зээл, өөрийн хувьцаагаар дамжуулан хөрөнгө хуримтлуулдаг байна. Гэхдээ зээлжих зэрэглэл харьцангуй доогуур, менежментийн зардал өндөр, томоохон компаниудыг банкууд илүүд үздэг учраас Хятадын жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн аравхан хувь нь л банкны зээл авах боломжтой юм байна. Энэ онд жижиг, дунд хувийн хэвшлийнхэнд 17.5 их наяд юанийн зээл хэрэгтэй гэсэн урьдчилсан тооцоо гаргажээ.

Дампуурах эрсдэл

Банкны салбар дахь ширүүн өрсөлдөөн нь хувийн хэвшлийнхний хүсэл, эрмэлзлийг мохоож ч болзошгүй. Учир нь тэд банкны салбараас олох ашигт л голлон анхаарч байна. 2012 онд Хөрөнгийн биржэд бүртгэлтэй 16 компаниас төрийн өмчит “топ” таван банк нийт ашгийн 75.5 хувийг хийсэн байх жишээтэй. Тухайн үед хотын арилжааны банкуудын нийт хөрөнгө нь банк, санхүүгийн байгууллагуудын нийт хөрөнгийн ердөө л 9.4 хувийг эзэлж байв.

Хятадын банкны салбарт хувийн хөрөнгө оруулалт хийх боломж бүрдэж байгаад шинжээчид сайшаалтай хандсаар ирсэн. Гэхдээ үүнийг хийхэд эрсдэлтэй.

“China Investment Corporation” баялгийн сангийн дарга Жин Личүн “Зарим хувийн банк дампуурахад ойрхон байна. Харин төрийн өмчит банк бол дампуурахгүй. Учир нь хадгаламж эзэмшигчдийнхээ мөнгийг аюулгүй хадгалах баталгаа өгсөн. Тэгээд ч Коммунист нам, Засгийн газар өөрийн ард түмнээ хуурахгүй. Нөгөө талаас хувийн банкууд дампуурах эрсдэлтэй тулгардаг нь гайхаад байх зүйл биш. Хүмүүс ер нь нэг их санаа зовох албагүй шүү дээ. Яагаад гэвэл хөгжил эрсдэлийг ч мөн дагуулдаг” хэмээн хэлсэн юм.

Тэрбээр “Дампуурах үед хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахын тулд хадгаламжийн даатгал заавал байх хэрэгтэй. Том банкууд өөрсдийгөө дампуурахгүй гэж боддогоос даатгалын тогтолцоог үл ойшоож, харин ч дарамт мэтээр үздэг талаар би сонссон. Гэтэл тэдгээр банкийг дампуурахаас нь Засгийн газар хамгаалдаг шүү дээ. Энэ нь иргэд хадгаламжаа байршуулах сайхан боломжийг ч олгож буй хэрэг. Даатгалын тогтолцоо бий болгох зардлыг тэдгээр банкны хувийн ашиг сонирхолтой харьцуулахад юу юм бэ?” гэжээ.

Шинжээчид хувийн хэвшлийнхний банкны салбарт орох гэсэн хүсэл, тэмүүлэл тодийлэн амжилт олохгүй гэжээ. Төрийн зөвлөлийн хөгжил, судалгааны төвийн Санхүүгийн судалгааны хүрээлэнгийн ерөнхий даргын орлогч Ба Шусонг “Хувийн компаниуд банкны салбар руу орж ирэхээсээ өмнө хүлээцтэй байж, хүнд байдлыг хэрхэн давж гарахаа сайн тодорхойлох чадвартай болсон байх шаардлагатай” гэжээ. Тэрбээр Тайваньд 1992 онд 16 хувийн банк байгуулах эрх олгогдсон боловч өдгөө зургаахан нь үлдсэн гэдгийг иш татаж байсан юм.

Ерөнхийдөө хувийн банк байгуулагдсанаас хойшхи гурван жилийн хугацаанд ашгийн асуудал яригдахгүй гэдгийг ойлгох хэрэгтэй аж. Урд хөршийн хувьд хувийн хэвшлийнхэн нь банкны салбарт азаа туршихаас өмнө тухайн салбар боловсронгуй, нэгдмэл болтол нь хүлээх шаардлагатай ажээ. ■

Эх сурвалж:

http://www.chinadaily.com.cn

ТӨМӨР ЗАМ

САХИЛ ХҮРТЭЭД ШАЛ ДОРДОХ ВИЙ

С.БАТЗАЯА

Манай улс хэвтээ тэнхлэгийн 1800 км төмөр зам барихаар шулуудсанаас хойш 6-7 долоон жилийг үдэж байна. Энэ асуудлыг УИХ хэлэлцэх гэхээр намын бүлгүүд шил шилээ харчихна. Ийн хоёр ч Парламент дамжсаны эцэст 2010 онд Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогоо арайхийн батлав. Бодлогод Даланзадгад-Тавантолгой-Цагаан суварга-Зүүнбаян чиглэлд 400, Сайншанд-Баруун-Урт 350, Баруун-Урт-Хөөт 140, Хөөт-Чойбалсан рүү 150 км зам тавихаар тусгасан. Энэ нь төмөр замын бүтээн байгуулалтын эхний хэсэг нь. Эдгээрийг 2010 онд эхлүүлэх байсан ч өнөөг хүртэл нэг ч чулуу байрнаас нь хөдөлгөсөнгүй. Үүнийгээ хөрөнгө мөнгөгүй хэмээн тайлбарлаж, ам таглах. Уг нь, Бодлогын баримт бичгийн 7.1.4-т “хөрш орнуудын нутаг дэвсгэрээр дамжин далайд гарах төмөр замын шинэ гарц нэмэгдэн эрэлт ихтэй гуравдагч орны зах зээлд ашигт малтмал шууд нийлүүлэх боломжтой далайн боомтуудад гарцтай болох” тухай тодорхой тусгаж. Гэтэл хөгжилд хүч нэмэх төмөр замын асуудал юунаас болж гацсан нь бүрхэг хэвээр. Хөрөнгө мөнгө гадаад дотоодоос татаж, эхлүүлж болох ажлыг өнгөрсөн дөрвөн жилд хойш чангаахад хүргэсэн асуудал нь юу вэ. Үүнд улстөрчдийн эрх ашиг байна гэж хардаж болохоор. Учир нь, төмөр ▸▸

замын бүтээн байгуулалтын эхний хэсэг гараанаасаа гараагүй байхад хоёрдугаар үе шатных нь зарим ажлыг эхлүүлээд буй ч бас л маргалдсаар. Нарийнсухайт-Шивээхүрэн-45.5, Ухаа худаг-Гашуунсухайт-267, Хөөт-Тамсагбулаг-380, Хөөт-Бичигт чиглэлд 200 км төмөр зам тавихаар хоёрдугаар үе шатдаа тусгасан. Үүнээс Ухаахудаг-Гашуунсухайт чиглэлийн



төмөр замын газар шорооны ажлыг өнгөрсөн онд эхлүүлээд байна. Бүтээн байгуулалтын ажил эхлэхтэй зэрэгцэн төмөр замаа ямар царигаар барих вэ гэх асуудал дахиад л маргаан дэгдээж эхлэв. 2010 онд баталсан Төмөр замын бодлогодоо өргөн царигаар барихаар тусгасан ч УИХ-ын хаврын ээлжит чуулганаар дахиж хэлэлцэнэ гэнэ. Цариг, ямар компани гүйцэтгэгчээр ажиллаж, хэдэн төгрөгөөр барих нь хуучирсан сэдэв байсан ч эргээд шинэ болов.

Төмөр замын 49 хувийг К.Н.Илюмжинов эзэмших үү

Төмөр замын барилга угсралтын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Олон улсын нээлттэй тендерийг анх 2009 онд зарлаж байв. Улмаар 2012 оны зургаадугаар сард дахин шинэчлэн зарлаж Австрали, БНХАУ, БНСУ-ын нийт долоон компанид урилга өгснөөс гурав нь саналаа ирүүлжээ. Эдгээрээс “Самсунг” констракшн тэргүүлж Ухаахудаг-Гашуунсухайт чиглэлд төмөр зам барих бүтээн байгуулалтын ерөнхий гүйцэтгэгчээр ажиллаж байна. Тус компанийн туслан гүйцэтгэгчээр дотоодын 12 компани ажиллаж байгаа юм.

1800 км төмөр зам барихад урьдчилсан тооцоогоор 5.2 тэрбум ам.доллар хэрэгтэй байгаа аж. Энэ нь манай улсын төсвөөс ч их мөнгө. Тиймээс гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татахаас өөр аргагүйд хүрсэн. Дэлхийн орнуудад ч ийм жишиг бий. Гагцхүү ямар хэлбэрээр хамтарч ажиллах нь оновчтой байх ёстой. Манайд хэрэгжүүлж буй “Шинэ төмөр зам” төслийг Халимгийн ерөнхийлөгч асан К.Н.Илюмжинов ихэд сонирхож байна. Тэрбээр 1800 км төмөр замын 49 хувийг эзэмшихээр хөрөнгө оруулалт хийх саналаа Монголын Засгийн газарт тавьжээ. Оны өмнөхөн Монголд ирж, энэ чиглэлээр Зам, тээврийн яамны удирдлагуудтай уулзаад явжээ. Энэ тухай К.Н.Илюмжинов “Би 1.6 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийнэ. Монголын Засгийн газарт өөрийн сангийн хөрөнгийн баталгааг гардуулсан. Одоо Англий нэгэн банкинд 400 сая ам.доллар байршуулаад байгаа. Үүнийг бид ажил эхлэх үед зарцуулах юм. Хэрэв бид ойрын хугацаанд гарын үсэг зурвал төсөл хэрэгжүүлэх ажилдаа орно. Өөрөөр хэлбэл, 49 хувийн санхүүжилт бидэнд бий. Тавантолгойн ордыг Монголын хилтэй холбох төмөр зам барих төслийг хэрэгжүүлэгч, гүйцэтгэгч түншүүдээ бид сонгож авсан” гэжээ. К.Н.Илюмжинов энэ төсөлд консорциум байгуулж оролцохоор төлөвлөсөн байна. Тухайлбал, олон улсад 6000 гаруй км төмөр зам барьж, дэлхийн шилдэг 10 компанийн нэгд ордог Испанийн “Учи Ейл” компани багтаж буй аж. Тус компани Хятад, АНУ-д төмөр зам барьсан туршлагатай гэсэн. Канадын “Бамбардье”, “Рау Жи Дэ” зэрэгт ч санал тавьж, зөвшөөрүүлжээ. Өөрөөр хэлбэл, ОХУ, Канад, Франц, Английн компаниуд консерциум болж, оролцох юм байна. Үүнээс гадна Оросын төмөр зам компанитай хамтарч ажиллах сонирхолтой байгаа гэсэн. Одоо Монголын Засгийн газартай хувь нийлүүлэгчдийн гэрээ хийх л дутуу үлджээ. Харин манайх энэ асуудлыг судалж буй аж. К.Н.Илюмжиновын мөнгө баталгаатай эсэхийг нягтлах шаардлага байгаа бололтой.

Нэг км замыг 2.5-3.2 сая ам.долларaар барина

Засгийн газар Гашуунсухайт-Тавантолгой чиглэлийн төмөр замыг “Энержи ресурс” компанийн хийж байсан нэг км замыг 2.5-3.2 сая ам.долларын өртгөөр хүлээж авчээ. Тус компани өөрийн хөрөнгөөр дээрх чиглэлд төмөр зам барих ажлыг эхлүүлээд байсан юм. “Энержи ресурс” олон улсад санхүүжүүлэх хамгийн зөв хувилбарыг сонгосон байж хэмээн “Монголын төмөр зам” компанийн Төслийн захирал А.Зориг хэлж байна. Харин Төмөр замын мэргэшсэн инженерүүдийн холбооны төлөөлөл “Төмөр замд тариф, хэр хэмжээний ачаа зөөх, хөрөнгө оруулалтын хэмжээ ямар байх нь чухал байдаг. Уул устай хүнд нөхцөлд нэг км төмөр замын өөрийн өртөг гурав орчим сая ам.доллар. Тал хээр нутагт барихад хоёр, хуучин шугам байгууламжийг сэргээхэд нэг сая ам.доллар байдаг. Харин манайх төмөр замын өөрийн өртгийг өндөр байлгах гээд байна. Нэг км замаас сая ам.долларын ашиг олох гээд байгаа юм биш үү. Үүнээс болоод төмөр замын мэргэжилтнүүд болон төсөл хэрэгжүүлэгч тал хоёрын дунд маргаан үүсээд байгаа” хэмээн ярьж буй. Тус холбооныхон төмөр замын өртгийн талаар Зам, тээврийн яамны удирдлагуудад удаа дараа хэлсэн гэх. Өөрөөр хэлбэл, Гашуунсухайт-Ухаа худаг чиглэлд барих төмөр замын нэг км-ыг хоёр сая ам.долларaар барих боломжтой гэж үзжээ.

Харин энэ асуудалд А.Зориг захирал “Энержи ресурс”-ийн барьж байсан өртөг нь олон улсын банк санхүүгийн байгууллагаас зээл авахад шаардлага хангасан үзүүлэлт. Дэлхий дахинд ч ийм жишиг байдаг. Австрали, Индонезид 3-4 сая ам.долларaар

барьсан байна лээ. Монголын хувьд газар шорооны ажил багатай учраас үүнээс харьцангуй хямд байдаг. Одоо барих шинэ төмөр зам нэгдүгээр зэрэглэлийнх. Зөөх ачааны хэмжээ ч харилцан адилгүй. Бид энэ төмөр замаар жилд 25 сая тонн ачаа тээвэрлэнэ" гэв. Төмөр зам барих хөрөнгөө олон эх сурвалжаас шийдэх хувилбар бий аж. Аливаа төслийг өөрийн болон зээлийн хөрөнгө оруулалт гэж хуваадаг байна. Өөрийн хөрөнгө оруулалт нь нийт өртгийн 30-40 хувь байх. Үүний 51 хувийг төрөөс гаргаж, үлдсэнд нь хөрөнгө оруулагч хайхыг хэлдэг аж. Манайх энэ аргачлалыг хялбар гэж үзэж буй. Харин үлдсэн 60-70 орчим хувийг олон улсын банкны зээлээр шийдэхээр төлөвлөжээ. Нэг ёсондоо төмөр зам ашиглалтад орж орлого олж эхэлсний дараа зээлээ буцаан төлөх юм. Олон улсад ч ийм байдаг байна. Банкны зээлийн хүү бондынхоос бага аж. Гэхдээ банкууд зээл өгөхийн тулд баталгаа шаарддаг. Хэрэв улсаас баталгаа гаргаж өгвөл зээл авах боломжтой гэсэн.

Зам барих хөрөнгө мөнгө нь шийдэгдвэл 2015 оны сүүлч 2016 оны эхээр түрүүчээсэ ашиглалтад орох юм байна.

Цариг чухал. Гэхдээ…

Манай эрх баригчид ОХУ-ын буюу 1520 мм-ийн өргөн, Хятадын 1435 мм-ийн буюу нарийн царигийн алинаар нь барих уу хэмээн сүүлийн хэдэн жил маргалдсан. Дэлхий нийтэд хоцрогдоод буй өргөн царигаар барьж болохгүй гэх шүүмжлэл их байдаг. Энэ асуудалд "Монголын төмөр зам" компанийн төслийн багийнхан "Улс бүр өөр цариг тай хийсэн. Аль цариг байх нь зөв, буруу гэсэн ойлголт байдаггүй. Монгол Оростой адил цариг тай. Нэг улс дотроо олон төрлийн цариг тай байх нь зохимжгүй гэж үзсэн учраас манайх өргөн царигаар барих бодлого баталсан. Тэгэхээр Тавантолгойгоос нүүрсээ шилжүүлж ачиж таарна. Үүнийг төрийн төвшинд шийдэх байх. Хамгийн гол нь, төмөр зам ашигтай байх ёстой. Цариг яаж шийдэгдэх нь чухал биш. Хамгийн гол нь, ойр ойрхон өөрчлөөд байх нь төслийн явцад хор урхагтай. Төмөр замтай болох нь автомашинаар зөөснөөс хамаагүй бага зардал гарна. Тиймээс төмөр замаа хурдан баримаар байна" хэмээн ярив. Харин К.Н.Илюмжинов манайд өргөн цариг ашигтай гэж хэлжээ. Хэрэв нарийн царигаар баривал уул уурхайн бүтээгдэхүүнийг зөвхөн Хятад улс руу гаргаж, хараат болох магадлалтайг хэлсэн байна. Гэхдээ энэ хоёр талтай ойлголт. Өргөн царигаар баривал бид нүүрсээ шилжүүлэн ачна. Шилжүүлэн ачилт зардлыг өндөрсгөдөг. Нэг тонн нүүрс хоёр ам.долларын илүү өртөгтэй гэж Монголын төмөр замын төслийн захирал А.Зориг хэлсэн. Харин олон улсын Хятад Монголын хооронд шилжүүлэн ачих тарифд нэг тонн нь 10 швейцарь франк байдаг аж. Багахан тооцоо хийж үзэхэд, бид жилд хамгийн багаар бодоход 25 сая тонн нүүрс экспортоллоо гэж бодъё. Үүнийг түүний ярьсан хоёр ам.доллараар тооцвол 50 сая ам.долларын алдагдал хүлээх нь. Ганцхан жилд шүү дээ. Олон улсын тарифаар бодвол үүнээс ч хэд дахин илүү өртөг зардал гарна. Ерөнхий сайд Н.Алтанхуяг БНХАУ-д айлчлахдаа жилд 50 сая тонн нүүрс экспортлох гэрээ хийсэн. Гэтэл урд чиглэлийн төмөр замаар жилд 25 сая тонныг зөөх чадвартай. Тэгэхээр одоо яах вэ. Нэг вагон 60 тонн-ын багтаамжтай. 80-90 тонн-ын багтаамжтай вагоноор зөөж болно. Мөн төмөр замаа хос болгож, зөрлөгүүдийн тоог нэмж болох юм. Гэлээ ч царигийн асуудлыг улсдаа ашигтай байдлаар шийдэхгүй бол төмөр зам барьсан ч "сахил хүртээд шал дордов" гэгч болох вий дээ. ■

ЭРҮҮЛ МЭНД

ХЯНАЛТ ХААНА БАЙНА

С.ЗАЯА

Монголчууд эмийг "хоол" шиг хэрэглэж байна. Эмийн замбараагүй хэрэглээ газар авсантай зэрэгцэн хуурамч эм, эмийн бүтээгдэхүүн хил гаалиар орж ирэх нь хэвийн үзэгдэл болжээ. Үүнд мэргэжлийн хяналтын байгууллагынхан хяналт тавьдаг гэх ч хадгалалтын хугацаа дууссан, чанаргүй, эмийн жагсаалтаас хасагдсан эмүүд зарим эмийн сан, "Нарантуул" худалдааны төвийн лангуу, хэн нэгний халаасанд байж, авах эзнээ хүлээсээр. БНХАУ-д үйлдвэрлэсэн үр зулбуулах "Misoprostol" нэртэй эм, "Oxytocin Injection" гэсэн хятад бичигтэй тариа, эмэгтэй хүний сав угаах шингэн зэрэг хуурамч эм, тариаг нууцаар худалдаалж буй баримт олон. Заримыг нь илрүүлдэг ч нөгөө хэсэг нь охид, бүсгүйчүүдийг үхэлд хүргэсээр байгаатай мэргэжлийн байгууллагынхан өнөө хэр тэмцэж чадахгүй байна.

ДЭМБ-аас хийсэн судалгаагаар дэлхийн эмийн зах зээлийн 10 орчим хувийг хуурамч эм эзэлж, олон тэрбум ам.долларын ашиг олдог аж. Харин хуурамч эм хөгжиж буй орнуудын эмийн зах зээлийн 25, хойд хөршийн л гэхэд 35-40 хувийг эзэлдэг тооцоо бий. Харин манай улсын хувьд 1994 оноос хойш хуурамч эмийн бизнес цэцэглэх үндэс тавигдсан хэмээн энэ чиглэлийн мэргэжилтнүүд хэлж байна. Монгол Улсад 1891 нэр төрлийн эм бэлдмэл хэрэглэхийг зөвшөөрч албан ёсоор бүртгэжээ. Үүнээс 170 нэр төрлийн эмийг түгээмэл хэрэглэдэг гэх судалгаа бий. Түүнчлэн 34 эмийн үйлдвэр, 190 гаруй эм ханган нийлүүлэх байгууллага, 1200 гаруй эмийн сан үйл ажиллагаа явуулдаг байна. Нэг гудамж тойроод эмийн сан байдаг нь иргэдийг дуртай эмээ хэлээд авах боломж бүрдүүлсэн. Үүнд хэн хэзээ хяналт тавих вэ. Төрөөс эмийн бодлогод анхаарна гэдэг ч ▸▸



салбарын яам өнөөг хүртэл эмч нараа жор бичүүлж сургаагүй байна. Эмийн зохисгүй хэрэглээнээс болж хордож, мансуурсан нэгнийх нь хохь болоод үлдэх нь энүүхэнд.

Жор бичиж урамшуулал хүртэнэ гэв үү

Төрийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоо муу байгаа нь эм зүйчдийг жоргүй эм олгоход хүргэсэн гэж УИХ-ын гишүүн Л.Эрдэнэчимэг хэлж байна. Жор бичээгүй эмчийн ёс зүй, хариуцлагатай ярих ёстой. Эмзүйчтэй ч мөн адил. Гэтэл Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Ц.Цолмонгэрэл “Манай улсад эмийн бодлого, жорын стандарт хэвшүүлэх талаар баримт бичгүүд бий ч хэрэгждэггүй. Эмч нар ачаалал ихтэй учраас зориулалтын цаасан дээр жор бичихээс төвөгшөөдөг ч байх. Тийм болохоор жор бичсэн эмчид урамшуулал өгөх хөшүүргийг бий болгохоор манай яам ажиллаж байна. Бусад улсад ч ийм аргачлал байдаг. Одоо жорыг өвчтний карт зарим тохиолдолд цаасан дээр бичиж байна.

Жор бичих асуудал ямар ч хяналтгүй байгаа. Тиймээс энэ хяналтыг бий болгох үүднээс ийн шийдвэрлэлээ” хэмээн ярив. Эмч өвчтөн үзэж, оношилж, жор бичсэнийхээ төлөө урамшуулал авна гэдэг санаанд багтамгүй асуудал. Хүн ардынхаа эрүүл энхийн манаанд зогсож, амь нас, эрүүл мэндийг нь хамгаалахаар тангараг өргөсөн цагаан нөмрөгтнүүд зоосоор “хөдөлнө” гэдэг мөнгө цагаан нүд улаан болсныг илтгэх. Нөгөө талаас жор бичсэнийх нь төлөө мөнгө өгөх бодлого боловсруулж суугаа яамыг дотроосоо ялзарч байна гэж тодорхойлъё. Германд жоргүй эм олгосон эмзүйчэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх хуультай аж. Харин манайд жороор олгох эмийг жоргүй олговол торгуулийн арга хэмжээ авдаг байна. Эмийн сангийн тусгай зөвшөөрөл, эмзүйчийн эрхийг хасах талаар дурсаад ч хэрэггүй гэсэн үг. Яагаад гэвэл, хуульд ийм заалт байхгүй.

Монгол эм, эмнэлгийн хэрэгсэл хамгийн үнэтэй

Эм тарианы үнэ дэлхийн зах зээлтэй харьцуулахад 3-5 дахин үнэтэй байгааг Эрүүл мэндийн яамны удирдлагууд хэлж байна. Манай улс 2005 онд нийт эм, эмнэлгийн хэрэгслийн бүтээгдэхүүний 10 хувийг дотооддоо үйлдвэрлэдэг байсан бол өнгөрсөн оны байдлаар 20 хувь болж өсчээ. Энэ чиглэлд төрийн бодлого үгүйлэгдэж байгааг эндээс харж болно. Учир нь, эм ханган нийлүүлэгч компаниуд импортоор өндөр үнэтэй эм оруулж ирэн түүн дээрээ ашгаа тооцон худалдаалдаг. Энэ нь эмийн үнийг нэмэгдүүлэхэд хүргэж буй. Хэрэв дотооддоо 50 хувь хүртэл үйлдвэрлэдэг болчихвол эмийн үнэ, чанар, аюулгүй байдал нэг шатаар урагшилна. Эмийн сангуудын 40 орчим хувь нь стандартын шаардлага хангахгүй байгааг Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас хийсэн судалгаа харуулж байна.

Энэ асуудалд Эрүүл мэндийн дэд сайд Ж.Амарсанаа “Эм, эмнэлгийн хэрэгслийг нэгдсэн журмаар худалдан авч үнийг нь хямдруулдаг жишиг маш олон оронд байдаг. Мөн хэд хэдэн орон нийлж худалдан авалт хийж, үнэ буурууллж байна. Ихийг авах тусам хямдардаг нь зах зээлийн хууль. Манайх улсын төсвөөр худалдан авч буй эмүүдийг бөөнд нь авбал хямдрах боломжтой. Гэхдээ үүнийг хэрэгжүүлбэл жижиг, дунд үйлдвэрүүдийн эрх ашиг зөрчигдөх талтай. Эмийн сангуудад ажилладаг эм найруулагч, эмзүйчид ажилдаа маш хариуцлагагүй ханддаг. Антиобиотекийг жоргүй өгч, зөвхөн ашгийн төлөө ажиллах нь энгийн үзэгдэл болсон. Харин манай зарим эмч нар жор бичсэнийхээ төлөө эмийн сангаас мөнгө авдаг. Үүнд бид хариуцлагатай хандах ёстой. Жорын цаасны төсвийг байнга төсөвдөө суулгаж байх хэрэгтэй. Үүнээс хойш эмийн жор дугаарлаж, эмч нарынхаа тоогоор өгөх тогтолцоог бүрдүүлэхэд анхаарна” гэв.

Эм хангамжийн байгуулагад нэгдсэн алба зайлшгүй шаардлагатайг нийслэлийн Эрүүл мэндийн газрынхан хэлж байна. Одоо бодлого, зохицуулалт, мэдээлэл статистик нь тусдаа газар харьяалагдаж буй аж. Эмийн талаар төрөөс баримтлах бодлогод Хүнс, эмийн агентлаг байгуулахаар тусгасан. Гэтэл өнөөг хүртэл ийм агентлаг байгуулаагүйг тэд яриандаа онцолсон. Дэлхийн улсуудын 60 гаруй хувь нь ийм агентлагтай аж. Манайд ийм агентлаг байгуулахад эхний санхүүжилтийг Азийн хөгжлийн банкнаас хийе гэжээ. Гэсэн ч төрийн ажил урагшлахгүй байрандаа байсаар. Үүнээс үүдээд хүний эрүүл мэнд хохирсоор байна.

Бид эмийн зохистой хэрэглээтэй болохын тулд даатгалаас санхүүжүүлж, жороор олгож буй эмийн нэр төрлийг нэмэгдүүлэх шаардлагатай. Тухайлбал, өнгөрсөн онд зургаан тэрбум төгрөгийн эмийг хөнгөлөлттэй үнээр олгосон байна. 2013 онд эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн иргэдэд нийт 60 тэрбум төгрөг зарцуулжээ. Үүний 10 хүрэхгүй хувийг даатгалаар хөнгөлөлттэй эм авахад зориулсан гэсэн үг. Харин одоо энэ хувь хэмжээг нэмэгдүүлбэл эмийн зохистой хэрэглээ болон жор бичилт сайжрах гарц харагдаж байна. Мөн эмч бүр жороо бичиж, эмийн санчид ашгаа бодож, эм худалдахгүй байх эрхзүйн орчинг бүрдүүлж өгмөөр байна. Үүнийг хэн, хэзээ ягштал биелүүлэх нь төрийн аппарат хэрхэн ажиллахаас хамааралтай гэдгийг эцэст нь тэмдэглэе. ■

ЭДИЙН ЗАСГИЙН ОНОЛД

ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТОЛЦОО, ТҮҮНИЙ ТӨРЛҮҮД



Ц.БАТСҮХ
СЭЗДС-ийн Эдийн засгийн тэнхимийн эрхлэгч

Өмнөх булангуудад эдийн засгийн шинжлэх ухаан юуг судалдаг хийгээд эдийн засгийн субьектүүдийн онцлог, үүрэг, тэдгээр нь захуудаар дамжин хэрхэн харилцдаг талаар авч үзсэн билээ. Энэ удаагийн буландаа субьектүүдээс бүрдэх эдийн засгийн тогтолцооны харилцааны механизмууд ямар зарчимд тулгуурладаг хийгээд түүнээс хамаарах тогтолцоог хэрхэн ангилдаг талаар авч үзнэ.

Эдийн засгийн субьектүүд, тэдгээрийн хооронд үүсч байгаа хүн ам, хөдөлмөрийн нөөц, түүний шилжилт хөдөлгөөн, үйлдвэрлэл, хэрэглээ, арилжаа солилцоо, мөнгө-санхүү, техник технологи, байгалийн баялгийн ашиглалт зэрэгтэй холбоотой бүхий л харилцаа, үйл ажиллагаа, тэдгээрийг удирдан зохицуулж байгаа байгууллага, хууль дүрэм, итгэл үнэмшил, уламжлал, ёс заншил зэргийн нийлбэр цогцыг эдийн засгийн тогтолцоо хэмээн ойлгодог. Эдийн засгийн тогтолцоо нь эдийн засгийн үйл хөдлөл, үр дүнд шууд буюу тойруу замаар нөлөөлдөг бүхий л үйл ажиллагаа, байгууллага, хууль дүрэм, уламжлал, итгэл үнэмшил, байр суурь, үнэлгээ, хэв хэмжээний хориг, бүдүүвчээс хамаарна.

Эдийн засгийн үндсэн асуудлуудыг хэрхэн шийдэж байгаагаар нь эдийн засгийн тогтолцоог дараах дөрвөн төрөлд хуваадаг. Үүнд:

- Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоо
- Цэвэр зах зээлийн эдийн засгийн тогтолцоо
- Холимог эдийн засгийн тогтолцоо
- Уламжлалт эдийн засгийн тогтолцоо

Эдийн засгийн асуудлуудыг шийдэх зорилготой харилцаанд оролцогч өрх, пүүсийн шийдвэр гаргалт нь ямарч хөндлөнгийн оролцоогүйгээр, цэвэр зах зээлийн механизмд тулгуурлан хийгддэг тогтолцоог цэвэр зах зээлийн эдийн засгийн тогтолцоо гэдэг.

Харин эдийн засгийн асуудлуудыг шийдвэрлэгч нь төр байдаг бол төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоо болно. Шийдвэр гаргалтад уламжлал, тогтсон ёс заншил голлон нөлөөлдгийг уламжлалт тогтолцоо гэх ба дээрх гурван тогтолцооны хэв шинжийг аль, алиныг нь агуулсан бол холимог эдийн засгийн тогтолцоо гэнэ. Хүмүүсийн өөрсдийн аюулгүй байдлыг эрхэмлэн, амар амгалан байдлаар хэрэгцээгээ ханган амьдрах хүсэл сонирхол нь төр үүсэх үндсэн нөхцөл болсон. Төрийн хэлбэрүүд нь хүмүүсийн хүсэл, шаардлагыг хэрхэн хангаж байгаагаасаа хамааран олон янз байдаг. Эдийн засгийн тогтолцооны төрлийг тодорхойлогч гол хүчин зүйл нь субьектүүд хоорондын харилцааны механизм ямар зарчим, үзэл баримтлалд тулгуурлаж байна вэ гэдэгт оршдог.

А.Смит эдийн засгийн харилцаан дахь төрийн оролцоог аль болох бага байлгах үзэл баримтлалыг барьсан ба төр зөвхөн батлан хамгаалах, иргэдийн аюулгүй байдлыг

»



хангах, асран хамгаалах, нийтийн боловсрол болон эрүүл мэндийн асуудлыг шийдэх, нийтийн барааны үйлдвэрлэлийг хангах чиглэлд оролцох ёстой гэсэн төрийн үүргийг хамгийн бага номлосон билээ.

Энэхүү хамгийн бага төртэй байгаа нөхцөлд эдийн засгийн субьект хоорондын харилцаа хөндлөнгийн бусад нөлөөлөлгүй зах зээлийн дотоод механизмаар дамжиж буй тогтолцоо цэвэр зах зээлийн тогтолцоо юм. Сонгодог эдийн засагчид энэ үзэл баримтлалыг гол болгон эдийн засгийн харилцаанд ханддаг. Төрийн оролцоог үгүйсгэдэг энэ онол, үзэл баримтлал өнгөрсөн зууны 30-аад он хүртэл давамгай байр суурьтай байсан.

19-р зууны сүүлийн хагаст К.Маркс бүх нийтийн өмчид суурилсан, нийгмийн сонирхлыг бүрэн хангасан сонголт бүхий, төрийн нэгдсэн зохицуулалттай эдийн засгийн тогтолцооны өөр нэг загварын үзэл баримтлалыг номлосон нь өмнөх номлолын нөгөө туйл юм. Хүн төрөлхтний тодорхой хэсэг нь энэ үзэл баримтлалыг барьж, социалист нийгмийг байгуулах оролдлогыг хийсэн билээ. Төр нийгмийн бүхий л хэрэгцээг хангах туйлын үүргийг хүлээдэг.

1929-1933 оны дэлхийн эдийн засгийн их хямралын нөлөөгөөр бий болсон Ж.М.Кейнсийн эдийн засгийн онол нь зах зээлийн дутагдалтай талыг төр нөхөж оролцох шаардлагатай тухай үзэл баримтлал бүхий төрийн зохицуулалттай холимог тогтолцооны загварыг бүтээсэн билээ. Холимог тогтолцооны нөхцөлд төрийн үүрэг нь хамгийн бага үүрэг дээр зах зээлийн дутагдлыг нөхөх, орлогын хуваарилалтыг тэгшитгэх, ажил эрхлэлтийг дэмжих, байгаль орчныг хамгаалах, үнийг тогтвортой байлгах зэрэг үүрэг нэмэгддэг.

Эдийн засгийн микро болон макро түвшинд аль алинд нь төрийн оролцоог үгүйсгэдэг А.Смит, хоёр түвшинд хоёуланд нь зохицуулалт байхыг номлосон К.Маркс нарын туйлын үзэл баримтлалуудын дунд микро түвшинд оролцоог үгүйсгэж, макро түвшинд байхыг зөвшөөрсөн Ж.Кейнсийн холимог хувилбар оршдог.

Д.д	Гол үзүүлэлтүүд	Цэвэр зах зээлийн эдийн засгийн тогтолцоо	Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоо	Холимог эдийн засгийн тогтолцоо
1	Өмчийн хэлбэр	Хувийн өмч	Нийгмийн өмч	Хувийн өмч давамгайлсан
2	Өрсөлдөөний механизм	Ашгийн төлөө	Уралдаан	Хосолсон шинжтэй
3	Зохицуулалтын механизм	Зах зээлийн	Төлөвлөгөө	Хосолсон
4	Эдийн засгийн үйл ажиллагааны төвлөрөл	Хувь хүний хэрэгцээг хангах	Нийгмийн хэрэгцээг хангах	Хувь хүний хэрэгцээг илүүд үзэх
5	Үнэ бүрдэлтийн механизм	Эрэлт, нийлүүлэлтийн харилцан шүтэлцээний үндсэн дээр	Төрөөс хатуу тогтооно	Ихэнх нь зах зээлийн механизмд тулгуурлах боловч, зарим бүтээгдэхүүний үнийг төр тогтооно
6	Төрийн хэлбэр	“Хамгийн бага төр”	“Хамгийн том төр”	“Дунд зэргийн төр”
7	Үйлдвэрлэгчийн гол зорилго	Хувь хүний хэрэгцээг хангах	Төлөвлөгөөг биелүүлэх	Аль, алиныг нь харгалзах
8	Субьектүүдийн үйл ажиллагааны сэдэл	Хувийн сонирхол	Нийгмийн эрх ашиг, сонирхол	Хувийн сонрихол давамгайлна
9	Эдийн засгийн эрх чөлөө	Бүрэн эрх чөлөөтэй	Байхгүй	Тодорхой хэмжээний эрх чөлөөтэй
10	Банкны тогтолцоо	Олон шатат тогтолцоо	Улсын банкны нэг шатат тогтолцоо	Олон шатат тогтолцоо

Их хямралын үед сонгодог үзэл баримтлалд тулгуурласан цэвэр зах зээлийн эдийн засгийн тогтолцоо бүхэлдээ хямарсан нөхцөлд үүнээс аврах арга зам нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоог бүрдүүлэх явдал гэсэн үзэл давамгайлж, капитализм нуран унах аюул нүүрлэж байхад холимог эдийн засгийн тогтолцооны шинэ номлол гаргаж, Ж.Кейнс капитализмыг аврагч болсон түүхтэй бөлгөө. Энэ үзэл баримтлал 1980-аад оныг хүртэл ноёрхсон ба үүний дараагаар сонгодог үзэл баримтлал дахин сэргэж эхэлсэн төдийгүй, үүнийг Рональд Рейган, Маргарет Тетчер нар практик бодлогын талаас дэмжсэн юм. Орчин үед уламжлалт тогтолцоо бүхэлдээ ноёрхсон эдийн засаг байхгүй бөгөөд зарим нэг үйл хөдлөлд энэ тогтолцооны элемент оршин байдаг. Тухайлбал шашны зан үйл, үндэсний зан заншлаар эдийн засгийн харилцаа зохицуулагддаг. Бурханы шашны хийдүүдэд өргөл барих, эцэг, эх нь хүүдээ шинэ гэр төхөөрч, мал таслан амьдрах нөхцөлийг бүрдүүлж өгдөг ардын уламжлал үүнд хамрагдана. Гол гурван тогтолцоог дараах хүснэгтэд харьцуулан харуулав.

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоонд хэн нэгэн малчинд дараа жил гутлын хэрэгцээ гарахыг улсын төлөвлөгөөний комисс мэдээд, түүнийг үйлдвэрлэх даалгаврыг гутлын үйлдвэрт өгнө, гутлын үйлдвэр төлөвлөгөөний дагуу үйлдвэрлэж, аймгийн худалдааны трестэд хуваарилан ачиж хүргүүлнэ, аймгийн худалдааны трест сумын худалдааны бэлтгэлийн ангид хүргүүлж, тэр нь өөрийн агент буюу гэрээт борлуулагчаар дамжуулан малчинд аваачиж өгдөг механизм үйлчилдэг байв. Төлөвлөгөөний комисс малчин бүрийн ямар гутал өмсөх дур сонирхол, хүсэлтэй байгааг тэр бүр мэдэж боломжгүй тул нийтлэг нэг загварын гутал үйлдвэрлэдэг, нийтийг хамарсан том үйлдвэрийн газруудтай байсан. Энэ үйлдлийн үе шат бүр төрийн зохицуулалтаар хийгддэг. Харин зах зээлийн тогтолцооны нөхцөлд малчин ямар загварын, хэдэн размерийн гутал хэрэгтэй байгаагаа сумын бизнесмэндээ

хэлэх ба бизнесмэн нийслэлийн зах, дэлгүүрээс захисан гутлыг олж, эсвэл гутал оёдог хүн болон үйлдвэрт тусгайлан захиалж хийлгээд өөрийн эсвэл хот хоорондын тээвэр хийдэг хүний машинд ачиж, малчинд хүргэнэ. Энд гутал үйлдвэрлэх, худалдах бүхий л шат дамжлагад хувь хүмүүсийн хоорондын аман эсвэл албан гэрээ хэрэгждэг. Төр малчныг гутал авах орлоготой байлгахад л анхаарахаас бусдад оролцох шаардлагагүй. Малчин бүрийн өмсөх гутлын сонирхол өөр, өөр байх тул бараг хүн бүрт зориулсан тусгай загвартай бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч хийх шаардлагатай болдог. Энэ нь хөрвөх чадвартай, уян хатан технологи, үйлдвэрлэх арга бүхий жижиг үйлдвэрийн газруудыг буй болгохыг шаардана.

Дээрх жишээнээс эдийн засгийн тогтолцооны туйлын хоёр хэлбэрийн үндсэн ялгааг олж харах боломжтой. Манай улс 1990 онд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос цэвэр зах зээлийн тогтолцоонд шилжих түүхэн зорилгыг тавьж, хэрэгжүүлэхийн тулд

- Үнэ чөлөөлөх
- Худалдааг чөлөөлөх
- Өмчийг хувьчлах
- Аж ахуйн нэгж буюу пүүсүүдийн зохион байгуулалтыг өөрчлөх
- Банкны тогтолцоог өөрчлөх
- Нийгмийн хамгаалал, төсвийн орлого, зарлагын шинэ тогтолцоог бүрдүүлэх

зэрэг өөрчлөлтүүдийг хийсэн билээ.

Харин зах зээлийн тогтолцооноос төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоонд шилжвэл өмчийг нийгэмчилж, үнийг хатуу тогтоон, аж ахуйн нэгжүүдийг төрөөс төлөвлөгөөгөөр зохицуулах, банкны үйл ажиллагааг Засгийн газрын мэдэлд авах өөрчлөлтүүдийг хийх болно.

Өнөөгийн байдлаар манай улсын эдийн засгийн салбар, секторуудын ихэнх нь зах зээлийн зарчмаар ажиллаж байгаа хэдий ч зарим салбаруудын эдийн засгийн үйл ажиллагааг төр хариуцан гүйцэтгэж байгаа билээ. Одоог хүртэл суурь дэд бүтцийн үйлдвэрлэл, хэрэглээ төрийн мэдэлд байсаар байгаа нь манай эдийн засаг холимог эдийн засгийн тогтолцоотой байгааг нотлох буй зай. Холимог тогтолцоо нь

- нийгмийн чиг баримжаатай,
- чөлөөт өрсөлдөөнд суурилсан сонгодог чиг баримжаатай

гэсэн янз бүрийн хольцтой байдаг.

Тухайлбал, Германы эдийн засгийг нийгмийн чиг баримжаатай холимог тогтолцоо, Америкийн эдийн засгийг чөлөөт өрсөлдөөнд суурилсан сонгодог холимог тогтолцоо хэмээн үздэг.

Цэвэр зах зээлийн болон төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн сонгомол хэлбэрүүд орчин үед аль ч улс оронд байхгүй бөгөөд янз бүрийн хольц бүхий холимог эдийн засгийн тогтолцоо л оршин байна. ■

ҮНЭ ХАНШ

Хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнэ ханшийг манай сэтгүүл уншигчдадаа тогтмол мэдээлж байна.

/Хоёрдугаар сарын 17-ны байдлаар/

Мах /кг.төгрөг/

Төрөл		Захуудын нэр/үнэ		
		"Хүчит шонхор"	"Бөмбөгөр"	"Миркури"
Үхэр	цул	8000-8500	9100	9000-11000
	Ястай	7500-8000	8500	9000-10000
Хонь	цул	6800-7300	8500	7500-8500
	ястай	6200-6800	7800	7000-8000
Ямаа	цул	5800-6300	6800	6500-7200
	Ястай	5300-5800	6000	6000-6500
Тахиа	мөч	5000-5500	5200-5500	6000-6500
	гуя	4800-5500	5000-5500	5500-6000
Адуу	цул	4800-5500	5000-6000	5500-6500
	ястай	4200-5000	4700-5500	5000-6000

Хүнсний ногоо /кг.төгрөг/

Төрөл	Захуудын нэр/үнэ		
	"Хүчит шонхор"	"Бөмбөгөр"	"Миркури"
Монгол төмс	600-800	600	700-900
Монгол лууван	1000-1200	800-1000	1200-1500
Монгол сонгино	1300-1500	1500	1500
Монгол манжин	1100-1300	1500	1300-1800
Монгол байцаа	1200-1500	1000-1200	1500-1800
Сармис	3500-4000	3000-4500	4000
Цагаан лууван	2000-2500	2500-3000	2500-3000

Гурил /кг.төгрөг/

Төрөл		Захуудын нэр/үнэ					
		"Хүчит шонхор"		"Бөмбөгөр"		"Миркури"	
хэмжээ		10 кг	25 кг	10 кг	25 кг	10 кг	25 кг
Улаанбаатар	дээд	12500	20500	13000	28500	14000	23000
Алтантариа	дээд	12000	25000	12000	24500	12500	26500
	I	8000	17500	7000	16500	9500	21000
	II	5000	10500	5500	13500	6000	11000
"Атар"	дээд	11500	26000	11500	25500	12500	26500
	I	8000	18500	8000	18000	9000	19000

Бусад бараа бүтээгдэхүүний үнэ

Төрөл	Захуудын нэр/үнэ		
	"Хүчит шонхор"	"Бөмбөгөр"	"Миркури"
Ургамлын тос	3000-3500	2850-3500	3500-4000
Элсэн чихэр	1600-2000	1500	2000-2500
Цагаан будаа	1800-2000	2000-2100	2000-2500
Гурвалжин будаа	1800-200	2000	2200-2500
Давс	600-1000	600-700	500-1000

ҮЗЭЛ БОДОЛ

ЭРЧИМТЭЙ ХӨГЖИЛ ХИЙГЭЭД ХАМААРАЛ



Ж.ГӨЛГӨӨ /Доктор/

Өмнөд хөрштэй эдийн засгийн чиглэлээр харилцах тухайд монголчууд бид ацан шалаанд ороод удаж байна. Нэг талаас эл зах зээлээс хэт хамааралт байдлыг багасгахыг бодлогын түвшинд мэрийсээр атал нөгөө талаас худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний харилцаа, бодит нөхцөлүүдээс үүдэн улам бүр тэлсээр байна. Эл эсрэг тэсрэгийг хэрхэн авцалдуулах вэ, алтан дундаж нь хаана байх ёстой вэ гэдэг асуулт урт, дунд хугацааны бодлогын гол сэдэв болон хувирч байна.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “...Нэг орноос худалдан авах бараа бүтээгдэхүүн нийт импортод хэт давамгайлахаас сэргийлэх бодлого баримтална (3.2.5.3). Гадаадын аль нэг орноос хийгдэх хөрөнгө оруулалтын хувь, хэмжээг гадаадын нийт хөрөнгө оруулалтын гуравны нэгээс хэтрэхгүй байлгах бодлого баримтална (3.2.2.2)....” гэж заасан буй. Эдүгээ БНХАУ-д манай барааны экспортын 95 хувь, импортын 27 хувь нь ногдож байна. 2012 оны эхний хагас жилийн байдлаар Монгол Улсад ороод буй 11,5 тэрбум ам.долларын гадаадын хөрөнгийн 31,7 хувь нь өмнөд хөршиийнх байжээ. Дээр нь Хонконгийн 1,8 хувийг нэмбэл даруй 33,5 хувь болж байна. Эдгээр тоо баримт нь дээрх үзэл баримтлалд тогтоож өгсөн чиглэл, шалгуур үзүүлэлтүүдийг давж гарах хэмжээнд хүрчихээд байгаа бөгөөд цаашид ч манай эдийн засагт БНХАУ-ын хүчин зүйл бусад орнуудынхаас илүүтэй нөлөөлөх нь маргаангүй юм. Энэ нь Ерөнхий сайдын өнгөрсөн оны аравдугаар сард хийсэн айлчлалын үед хүрсэн тохиролцоонуудаас ч тодорхой харагдаж байна. Тухайлбал, ойрын 20 жилд Хятадаас 10-аад төсөлд 70-80 тэрбум ам.долларын хөрөнгө орох болсныг хэвлэлүүдээр мэдээлсэн.

Тэгэхээр эдийн засгийн өсөлтийг тэргүүлэх байранд тавьж тус улстай аж ахуйн харилцааг цаашид эрчимжүүлэх үү, эс бөгөөс хамааралт байдлыг хязгаарлахыг чухалчилж хэлхээ холбоог одоогийн түвшинд барих уу гэдэг сонголтын өмнө бид тулж ирээд байна. Биднийхээр бол даяаршлын орчин цагийн нөхцөлд үйлдвэрлэх хүчнээ аль болох хурдацтай өсгөж, эдийн засгийн хийгээд нийгмийн дэвшлээ түргэтгэж чадсан улс орон тусгаар тогтнол, үндэсний дархлаагаа хадгалах боломжоор илүү хангагдаж байна. Эдүгээ аюулгүй байдлыг хангахад цэрэг зэвсэглэлийн үүрэг буурч эдийн засгийн ерөнхий түвшингээр нөхцөлдсөн “зөөлөн” хүчин зүйлүүдийн ач холбогдол өсч байна. Бие даасан байдлын баталгаа нь шуурхай маневрлах боломжийг хангахуйц валютын арвин нөөц, орчин цагийн төмөр зам, авто зам, бас агаарын тээвриийн сүлжээ зэрэг материаллаг хүчин зүйлс болон хувирч байна. Манай орны газар зүйн байршил хийгээд хойд хөршийн эдийн засгийн бүтцээс үзэхүл эрчимтэй өсөлтийн хөдөлгүүр нь өмнөд хөрш болж таарч байна. Энэ гаргалгаа ямар ч болов ойрын ирээдүйд буюу 15-20 жилийн хугацаанд үнэ цэнээ алдахгүй болов уу. БНХАУ нь 1,2 тэрбум хүнтэй хамгийн багтаамжтай төдийгүй, тогтвортой өсч буй, бас үйлдвэржин буй зах зээл юм. Манай экспортод ойрын ирээдүйд давамгайлсаар байх эрдсийн түүхий эдийг тээвэрлэн авах дэд бүтэц, шингээх чадамж түүнд л бий. Харин бидний тухайд анхнаасаа ойлгож бүх түвшинд байнга санаж ажиллавал зохих нэг зүйл бий. Энэ нь бид урд зах зээлгүйгээр хэвийн амьдрахад хэцүү, харин тэд бидэнгүйгээр амьдарч чадна гэдэг тухай юм. Өөрөөр хэлбэл, бид яриа хэлэлцээнд оролцохдоо зөвхөн өөрийн эрх ашгийн үүднээс хандах биш, түншийнхээ ашиг сонирхлыг бүрдүүлэх, харилцан хамаарлыг буй болгоход анхаарвал зохино. Эл хамаарал нь зөвхөн хэрэгцээт бараг нь нийлүүлэх төдийд биш, хөрөнгө нь орж ирсэн, ашигтай ажиллах болон борлуулалтын хариуцлагыг бас нөгөө тал хуваалцахуйц үйлдвэрлэлийн харилцан хамаарлалт холбоо байх ёстой. Цаашдаа хэрэглээний түүхий эд, хувцас, хивс, даавуу, мах зэргийн экспорт ч Хятадын зах зээлд нэмэгдэх боломжтой. Иргэдийнх нь орлого өсөхийн хэрээр натурал хүнс, эко бүтээгдэхүүн худалдан авах хэрэгцээ нь нэмэгдэх нь мэдээж.
Харилцааг хөтлөн явуулах механизмын хувьд гэвэл төрийн оролцоо, зохицуулалт түлхүү шаарддаг өмнөд хөршийн онцлогийг бодолцохоос өөр аргагүй. Хамтын ажиллагааны зарчим, цар хүрээг эхлээд төр, засгийн байгууллагуудын түвшинд тоймлон тогтоодог практикийг нь хүлээн авах, түүнд нь дулдуйдаж

аль болох урт хугацааны тогтвортой харилцааг бүрдүүлэхийг чармайх нь манай талд ашигтай ч байж болно. Харин хамааралт байдлыг багасгах нэг түлхүүр нь хойд хөршийн оролцоо мөн. Энэ үүднээс төмөр болон авто зам, нефть, хийн хоолой, цахилгаан дамжуулах шугам зэрэг Орос-Монгол-Хятадын гурвалсан төслүүдээс болгоомжлох биш, харин хөхиүлэн дэмжих чиглэлийг бид баримталж эхэлсэн нь сайн хэрэг юм.

Гуравдагч зах зээлийн ач холбогдлыг үгүйсгэхгүй байна. Гэхдээ транзит тээврийн одоогийн боломж, түүхий барааны овор хэмжээ зэргээс хамааран манай дийлэнх экспортын бараа ойрын ирээдүйд бусад орнууд руу төдий л гарч чадахгүй юм. Оюутолгой зэрэг төслийн жишээнээс харахад Монгол дахь гадаадын компанийн хувьд Хятад борлуулалтын гол зах зээл байх нь. Монгол-Хятад-гуравдагч улсын компаниуд гэсэн гурвалсан хэлхээг аль болох дэмжих шаардлага гарах нь.

Тэгэхээр өмнөд хөрштэй эдийн засгийн чиглэлээр харилцах тухайд хоёрын хооронд, тодорхойгүй, “шийрэгнэсэн” байдалдаа цэг тавьж эхлээд эдийн засгийн эрчимтэй өсөлтийг тодорхой хугацаанд хангах явдлыг тэргүүн зэрэгт тавих нь зөв гэдэг дээр санал нэгдэцгээе. Энэ нь аливаа хязгаарлалт, босгогүйгээр худалдааны, хөрөнгө оруулалтын харилцааг өргөтгөж, хил дамнасан дэд бүтцүүдээс цэрвэх биш, харин хөхиүлнэ гэсэн үг. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал зэрэг баримт бичигт зохих өөрчлөлт оруулах ёстой болно.

Хятадтай аж ахуйг уялдуулахаас болгоомжлох үндэслэл нь чухам юу билээ, тэр нь хэдий хугацаанд үйлчлэх билээ гэдэг асуудал нөгөө талаас тавигдана. Монголыг нэгтгэх, нөөц баялгийг нь эзэмдэх, мөлжих гэж байна гэсэн хардлага энэ үзлийн цөм нь. Эдүгээ улс үндэстэн хоорондын харилцааны дүрэм өөрчлөгдсөн гэж найдах болох. Нөгөө талаас, үндэсний хэмжээний амар амгаланг урт хугацаанд хангах олон улсын нөхцөл нь хөрш орнуудтай найрсаг харилцаг хангах тухай БНХАУ-ын номлолыг ч иш үндэс болгоё. Эдийн засгийн өсөлтийнх нь үр шимээс хөршүүд нь бас хүртэх ёстойг манай Гадаад хэргийн сайдын саяхны айлчлалын үеэр Хятадын албаныхан цохон тэмдэглэцгээсэн нь бас нэгийг өгүүлнэ. Харин нэгэнт байгуулсан гэрээ хэлцлийнхээ утга санаа, үг үсгийг чандлан сахиж биелүүлдэг соёлд бид суралцах ёстой. Гэрээ тохиролцооноосоо нэг талаар буцах болчимгүй алхмууд хийгдсээр байгааг санацгаахад илүүдэхгүй. “Чалко”-той байгуулсан гэрээ үүний тод жишээ. Хамгийн сүүлийн тохиолдлуудын нэг нь Төв аймгийн Сэргэлэн суманд хятад компанийн хөрөнгөөр баригдах цементийн үйлдвэрийн зөвшөөрлийг цуцлуулах тухай хэвлэл мэдээллийн сүлжээгээр өрнүүлэн буй кампанит ажил юм.

Эцэст нь өмнөд хөрштэй хэрэгжүүлж буй аж ахуйн харилцааны үр ашгийн асуудал ихээхэн маргаан дагуулдаг. Өөрөө үйлдвэрлэсэн бол илүү зардал гаргахуйц барааг түүнээс хямдаар үйлдвэрлэсэн зүйлээ борлуулж олсон мөнгөөрөө худалдаж авч чадаж байвал харьцангуй ашиг үүсдэг. Манай хоёр улсын худалдаанд дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн энэ л шалгуурын үүднээс хандах ёстой байх. Гэхдээ хөгжье гэвэл мөлжигдөх ёстой, мөлжүүлэхгүй гэвэл хөгжих ёстой гэсэн диалетик тойрогт орших үнэмлэхүй үнэнийг бас хүлээн зөвшөөрөх ёстой болно. Түүнийг энгийнээр илэрхийлвэл харилцан ашигтай байх явдал юм. ■

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

АРИЛЖААГАА АМЖИЛТТАЙ ЭХЛЭХ ЗӨВЛӨМЖҮҮД

Г.МӨНХ-ЭРДЭНЭ
“Мандал Ассет Менежмент” ХХК-ийн Хөрөнгө оруулалтын шинжээч, дилер

Бэлтгэл үйл ажиллагаа буюу сайн брокер сонгох нь

Таны брокер таныг хөрөнгө оруулалтын ертөнцөд хамгийн аюулгүй, найдвартай, хамгийн хурдан галт тэргэнд, хамгийн тохилог суудалд суулгах ёстой. Үлдсэнийг нь та өөрөө хийх учиртай юм. Иймээс гараагаа амжилттай хийхэд брокероо зөв сонгох маш чухал.

ЗӨВЛӨМЖ 1: Байршил. Өнөөгийн зах зээлийн хөгжлийн түвшинд та тодорхой хугацааны дараа өөрийн биеэр очиж хувьцааны захиалгадаа гарын үсгээ зурах үүрэгтэй. Иймээс та ажил, гэр, хүүхдийн тань сургууль, цэцэрлэгтэй ойрхон тийм брокерыг сонгох нь цаг завыг тань хэмнэнэ. Тиймээс та байршлыг харгалзан үзэх хэрэгтэй. Зах зээлийн хөгжлийг дагаад уг хүчин зүйлийн нөлөө ирээдүйд буурах болно.

ЗӨВЛӨМЖ 2: Шимтгэл бага: Та аль болох бага шимтгэлтэй брокерт хандах нь таны зардлыг бууруулж, ашгийг нэмэгдүүлнэ. Гэхдээ та нэг гараараа хэмнэсэн зардлынхаа мөнгийг авч байгаа бол нөгөө гараараа юуг өгч байгаагаа заавал хараарай. Ямар нэг зүйлийг авсан л бол цаана нь ямар нэг зүйлийг алдаж

байдаг. Өөрөөр хэлбэл шимтгэл нь бага боловч туршлага муутай брокер байвал яах вэ? Зах зээлийн алтан үеүд ирж буйг таньд анхааруулж чадахгүй шүү дээ.

ЗӨВЛӨМЖ 3: Хурд. Ханш унах гээд яаран байж захиалга өгөхөд яст мэлхий шиг удаан брокерууд байдаг. Магадгүй хөрөнгийн зах зээл бол хурдны галт тэрэг гэдгийг тэд ухаараагүй юм болов уу. Хэн хамгийн хурдан галт тэргэнд сууна тэр амжилтын зогсоолд хүрэхэд бусдаас нэг алхам урд байна. Иймээс хурдтай, түргэн шуурхай үйлчилдэг брокерыг сонгоорой. Гэхдээ галт тэрэгнийхээ бүрэн бүтэн байдлыг шалгаж үзэхээ мартуузай.

ЗӨВЛӨМЖ 4: Чулуун зэвсгийн үеийн багаж. Бид маш завгүй. Өнөөгийн нийгэм бидний чихэнд үргэлж “ажил - завгүй” гэдэг үгийг шивнэж байдаг. Иймээс брокер тань захиалгаа зөвхөн “биеэр ирж өг” гэвэл энэ маш том хүндрэл. Тэд харилцагчийнхаа төлөө хийх ёстой алхамуудынхаа хамгийн эхний алхамыг ч хийгээгүй байна шүү дээ. Ийм байхад таныг ханшийн давалгаа дунд амжилттай гулгахад тусална гэдэгт итгэхгүй байна. Утсаар, мэссэжээр, интернетээр гээд аль болох олон арга замаар арилжаа хийх боломжийг олгож буй брокерыг сонго. Энэ бүхэн нь таньд давуу талыг олгоно. Гэхдээ хяналтаа сайн тавиарай.

ЗӨВЛӨМЖ 5: Туршлагатай нэгнийг сонго. Хамгийн багадаа 3-5 жил ажилласан брокер сонгох нь зүйтэй. Учир нь энэ хугацаанд ерөнхийдөө эдийн засгийн мөчлөгийн нэг үе өнгөрдөг. Хүнээр бол “хал үзэж хашир сууна” гэсэн үг. Гэхдээ туршлага чухал боловч “ӨНГӨРСӨН БОЛ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА” биш гэдгийг мартаж болохгүй. Туршлага, мэдлэгтэй ч ёс зүйгүй брокер байвал яах вэ? Таны захиалгыг хойш тавьж өөрийн захиалгыг урд нь оруулна шүү дээ. Иймээс та сонголтоо хийхдээ хувь хүнийг нь давхар харах хэрэгтэй.

ЗӨВЛӨМЖ 6: Дэлхий дээр үлдсэн ганц хүн. “Зах зээлд галав юүлэхэд дэлхий дээр цор ганц амьд үлдсэн, аврал эрж болохуйц хүн бол миний брокер юм байна” гэж та өөрийн брокерийг үнэлж байна уу? Чухамдаа та ийм л брокерыг сонгох учиртай. Учир нь танд хангалттай хэмжээний мэдээлэл, судалгааг хүргэж чадаж байгаа брокер л ингэж үнэлэгдэх юм. Брокер тань шаардлагатай үед бүхий л үнэн бодит мэдээлэл, судалгаагаар хангаж чадах мэдээлэл, судалгааны уурхай байх учиртай. Мөн тодорхой хэмжээний зөвлөмж өгөх чадвартай байвал бүр сайн. Гэхдээ шийдвэр таны гарт.

ЗӨВЛӨМЖ 7: Бусад нь юу гэж хэлж байна вэ? Монголчууд итгэмтгий хүмүүс. Ялангуяа хувьцаа авахад энэ зан олонтаа анзаарагддаг. Тиймээс та “бусад” гэдэг үгийг ойлгохдоо таны сонгохоор төлөвлөж буй брокероор олон жил идэвхтэй үйлчлүүлсэн хүнийг гэж ойлгох хэрэгтэй. Тэдгээр хүмүүс л брокеруудыг өөрсдөөс нь илүү сайн мэдэж байдаг. Иймд харилцагчдаас нь брокерийнхоо чансааг заавал асууж тодруулаарай.

ЗӨВЛӨМЖ 8: Хэрэглэгч хаан. Таны төлөө чин зүрх сэтгэлээсээ ажиллаж чадах уу? гэдэг асуултанд заавал хариулт аваарай. Институциональ ба жижиг хөрөнгө оруулагч гэдэг утгаараа харилцагчид үзүүлэх үйлчилгээ нь харилцан адилгүй байдаг нь бизнесийн хууль. Гэхдээ их эсвэл бага мөнгөөр арилжаа хийдгээс хамаарч брокерууд ялгаварлан харилцаж байвал асуудал үүсчээ гэсэн үг. Эсвэл хөгшин, залуу, хувцаслалт гэх зэрэг гадаад шинж байдлаар тань ялгаварлаж байна уу? Иймээс таныг өөрийнхөө цорын ганц харилцагч, таныг л алдчихвал харилцагчгүй болно гэж өөртөө хариуцлага хүлээлгэж чаддаг өндөр ёс зүйтэй, үйлчлүүлэгчийнхээ төлөө гэсэн сэтгэлтэй брокерийг сонгоорой.

ЗӨВЛӨМЖ 9: Судалгаа, шинжилгээний супермаркет. Таны брокер хэр олон төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлдэг вэ? Арилжааны, хувьцааны, эдийн засгийн олон талт судалгаануудыг хийдэг үү? Ханш хэт хэлбэлзлэх үед таньд дохио өгдөг үү? Мэдээллээр бүрэн дүүрэн хангаж чаддаг уу? Аль болох олон төрлийн чанартай үйлчилгээ үзүүлдэг брокерыг сонгох нь маш чухал. Учир нь та газар ухахдаа дан ганц хүрзтэй зогсохыг хүсэхгүй л болов уу. Бээлий, жоотуу, лоом...гээд хэд хэдэн багажтай байвал хурдан ухна шүү дээ. Иймээс хувьцааны хөрөнгө оруулалт хийхэд шаардлагатай багажуудыг зардаг судалгаа, шинжилгээний супермаркетыг сонго.

ЗӨВЛӨМЖ 10: Тэд хэр хөгжих чадвартай вэ? Эцэст нь хэлэхэд, хамгийн чухал зүйл бол харилцагчдынхаа төлөө шинэ үйлчилгээ, бүтээгдэхүүнийг тогтмол нэвтрүүлдэг, шинийг санаачилж, хэрэгжүүлж, амжилттай үр дүнд хүрч чаддаг тийм л брокерийг сонго. Үүний тулд өнгөрсөн хугацааны түүхийг нь судал. Электрон хаягийг нь нэг нэгэнгүй ухаж үз. Шинээр нэвтрүүлсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний хугацааны давтамж, танилцуулгыг анхааралтай унш. Брокер тань хөгжвөл та бас хөгждөг юм. Хөрөнгийн зах зээл гэдэг зогсохоо мэдэхгүй хөгжиж, ядрахаа мэдэхгүй судалж, үхэхээ мэдэхгүй суралцаж байдаг тийм л газар.

Арилжаанд ороходоо анхаарах нь


Хэрэв та Монголын хөрөнгийн зах зээл дэх хувьцаанд хөрөнгө оруулах гэж байгаа бол Монголын нөхцөлд бүрэн дүүрэн нийцэх, шууд ашиглах боломжтой, арилжаагаа амжилттай эхлэхэд тань зориулсан зөвлөмжийг хүргэж байна.

ЗӨВЛӨМЖ 1: Хөрвөх чадвар багатай зах зээл. Юуны өмнө яг одоогийн нөхцөл байдалд хөрөнгийн зах зээлд 100 байтугай 10 сая төгрөгийг удирдахад хөрвөх чадварын асуудал үүсдэгийг тэмдэглэх нь зүйтэй. Өfрөөр хэлбэл, таван сая төгрөгийг жилийн дотор 10 сая төгрөг болгох боломжтой ч 100 сая төгрөгийг 200 сая болгоход хүндрэл учирна гэсэн үг. Хөрвөх чадвар муу байгаа нь ийм хэмжээний мөнгийг богино хугацаанд зах зээлд оруулахад хувьцааны ханшийг өсгөх ба хувьцаагаа зарахад ханш унахад хүргэдэг. Иймээс хэдэн төгрөгийг, ямар хугацаанд, ямар хувьцаануудад хийх вэ гэдгээ нарийн төлөвлөх хэрэгтэй. Бэлэн мөнгөний хэрэгцээ гэнэт бий

болвол хувьцаагаа хэд хоногийн дотор зарж чадах вэ? үүнээс улбаалан ханш хэдэн хувиар унах вэ? гэх зэргээр тооцоогоо сайтар хийх нь маш чухал. Иймээс таныг мөнгөний хэмжээндээ хязгаар тавихыг зөвлөж байна. Мөн та дөнгөж эхэлж байгаа учир их мөнгөөр арилжаанд орох нь эрсдэлтэй. Харин та урт хугацаанд хөрөнгө оруулалт хийж байгаа бол нөхцөл байдал өөр болно. Хэдэн сарын турш бага багаар түүх замаар ханшид нөлөөлөхгүйгээр хөрөнгө оруулж болох юм. Харин богино хугацаанд хэдэн зуун саяар хувьцаа авч, эргүүлээд зарах замаар ашиг олох гэж байгаа бол таныг валют, үл хөдлөхөд хөрөнгө оруулахыг зөвлөж байна. Гэхдээ дунд ба урт хугацаанд хөрөнгийн зах зээл дэх энэ төрлийн эрсдэл буурна.

Жишээ нь, 2014 хоёрдугаар сарын 11-ны өдрийн арилжааны Шарын гол ХК-ийн арилжааг графикт харуулжээ. Арилжаа өглөө 10:00 цагт нээгдсэн бөгөөд 12:30 цаг хүртэл ханш өмнөх өдрөөс өсөлттэй 9,000 төгрөгөөр арилжаалагдаж байв. Харин 12:30-13:00 цагт хооронд 245 ширхэгийг нийлүүлж 8035 төгрөг хүртэл унасан байна. Мөнгөн дүнгээр тооцвол дөнгөж хоёр сая орчим төгрөг юм.

Шарын гол ХК-ийн 2014.02.11-ний арилжаа



ЗӨВЛӨМЖ 2: Төвлөрөл өндөр. Бирж дээрх чанартай хувьцаануудын дийлэнхи нь өндөр төвлөрөлтэй байдаг. Энэ нь ханшийн хиймэл хэлбэлзэл үүсгэх боломжийг спекуляторуудад олгож байдаг учир эхлэн оролцогчид ханшийн давалгаанд цохиулж буруу шийдвэр гарахад хүрдэг. Өнөөдөр авсан хувьцаа тань маргааш гэнэт уначихаж болно. Эсвэл гэнэт өсөж бас болно. Гэнэтийн ханшийн хэлбэлзэл үүсэх л юм бол “үүнийг далд зорилго”-той үйлдэл гэж сэжиглэх хэрэгтэй. Ийм нөхцөлд тухай бүрд нь зөв мэдрэх нь чухал.

2013 оны арванхоёрдугаар сарын байдлаар:

Нийт хувьцааны	93.88%	нийт хувьцаа эзэмшигчдийн	0.32%
Нийт хувьцааны	6.12%	нийт хувьцаа эзэмшигчдийн	99.68%

Эх сурвалж: Мандал Ассет Менежмент

Зориудаар ханшийг унагаж байгааг та мэдэж чадвал хувьцаагаа зарахаас илүү эсрэгээр худалдан авах нь зөв. Учир нь Монголд шорт сэлл байхгүй учир спекуляторууд ханшийг эргүүлэн өсгөж байж ашиг олно шүү дээ. Тэр үед хямд авсан хувьцаагаа зарж ашиг хийж болно. Зөв мэдэрч чадвал ийм хэлбэлзлээс богино хугацаанд ахиухан ашиг олох боломжтой.

Нэг компанийн нийт хувьцааны	93.45%	нийт	3
Нэг компанийн нийт хувьцааны	6.55%	нийт	1042

Эх сурвалж: Мандал Ассет Менежмент

Тийм чадвартай болохын тулд цаг их зарцуулж, судалгаа сайн хийхээс аргагүй. Ханшийн хэлбэлзэлд өртөж, алдагдалд орохгүйн тулд аль болох төвлөрөл багатай хувьцаа авахыг зөвлөж байна. Төвлөрлийн талаарх статистик тоог YЦТТТХТ-өөс /schcd.mn/ авч болно. Зах зээл хөгжихийн хэрээр хувьцааны төвлөрөл буурах боломжтой.

ЗӨВЛӨМЖ 3: Гадаадын хөрөнгө оруулагчдын нөлөө их. Манай зах зээлийн арилжааны 70 хувийг гадны хөрөнгө оруулагчид хийсэн статистик бий. Цаашид ч энэ тоо хадгалагдах нь гарцаагүй. Эндээс маш чухал анхаарах ёстой нэг зүйл урган гардаг. Түүхэн өгөгдлөөс харвал гадаад иргэний нэг данснаас арилжаанд орж буй мөнгөний дундаж хэмжээ Монгол иргэний дунджаас хамгийн ихдээ найм дахин, хамгийн багадаа хоёр дахин их байсан. Энэ нь гадаад иргэдийн ханшид нөлөөлөх хүч Монгол иргэдийнхээс хэд дахин илүү гэсэн үг юм. Нэг данснаас орж буй арилжааны дүн өсөх тусмаа нэг чигийн хүч нэмэгдэж, ханшид нөлөөлөх чадамж нь өсч байдаг. Иймээс уг харьцаа хэрхэн өөрчлөгдөж буйг, мөн хэмжээний хувьд хэрхэн хувьсаж буйг тогтмол ажиглаж, шийдвэр гаргалтандаа тусгах хэрэгтэй. Уг статистик тоог YЦТТТХТ-ийн /schcd.mn/-ээс харж болно.

		2013M12	2013M11	2013M01
Гадаадын ААН-ийн	нэг данснаас нэг удаан хийх арилжааны дундаж дүн нь	1 233 492.28	1 275 331.12	1 036 238.05
Гадаадын иргэний		647 834.44	626 739.74	1 213 132.51
Дотоодын ААН-ийн		757 170.14	747 530.12	751 157.22
Дотоодын иргэний		245 736.43	230 256.93	271 111.41

Дээрх үнийн дүнг дотоод иргэдийн арилжааны дүнтэй харьцуулбал

Хөрөнгө оруулагчдын төрөл	2013M12	2013M11	2013M01
Гадаадын ААН-ийн	5.02	5.54	3.82
Гадаадын иргэний	2.64	2.72	4.47
Дотоодын ААН-ийн	3.08	3.25	2.77

Эх сурвалж: Мандал Ассет Менежмент

ЗӨВЛӨМЖ 4: Мэдээллийн ил тод байдал муу. 2014 оноос мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэхүйц хуулиуд хэрэгжиж эхэлсэн ч үр дүн гарах хэмжээний цаг хугацаа өнгөрөөгүй байна. Иймээс үнэ цэнэ бүхий мэдээллийг тогтмол хүлээн авч чадах мэдээллийн системийг өөртөө бий болгох хэрэгтэй.

Харин мэргэжлийн байгууллагаас “БиДиСек” компанийн сайт харьцангуй идэвхтэй байдаг. Ер нь хоёрдогч эх сурвалжаас авч байгаа мэдээллийн үнэн бодит байдлыг заавал шалгахыг зөвлөж байна. Худал мэдээлэл тараасан хэргээр хариуцлага хүлээлгэх хууль эрх зүйн орчин байхгүй учир далд зорилгоор мэдээлэл тараах нь элбэг байдаг. Үнэн бодит мэдээлэл авах хамгийн гол эх сурвалж бол хувьцаат компанийн “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал” гэдгийг бүү мартаарай. Ямар ч ажилтай байсан та хувьцааг нь эзэмшиж ашиг олох зорилготой л бол хуралд нь заавал суух хэрэгтэй.

ЗӨВЛӨМЖ 5: Их хэмжээний арилжаанаас хэрхэн ашиг хүртэх вэ? Тухайн өдөр өмнөх хэвийн өдрүүдээс их хэмжээний арилжаа хийгдвэл энэ нь зах зээлд цочрол өгдөг. Өнгөрсөн 1 сар эсвэл 3 сарын хугацааны нэг өдрийн арилжааны дундаж ширхэгээс их хэмжээний хувьцаа арилжаалагдах гэх мэт шинжүүрээр тухайн өдрийн арилжааны хэмжээ их эсвэл бага байгааг тодорхойлж болдог. Ингэж тодорхойлохын учир нь их дүнтэй арилжаа зах зээлд цочрол өгч, ихэнхи тохиолдолд “ханш өсөх” нь гэсэн хүлээлтийг бий болгодог. Мөн багцын арилжааны үнэ зах зээлийн үнээс илүү үнэтэйгээр хийгдсэний дараа ханш өсдөг талтай. Жишээ нь, саяхан АПУ-ийн 19.8 хувийн багцын арилжаа тухайн үеийн зах зээлийн үнээс 15% хувиар илүү үнээр арилжаалагдахад энэ нь ханшид нөлөөлж богино хугацаанд 16 хувиар өссөн. Мөн Баганууурын 21 хувийн багцын арилжаа нь зах зээлийн ханшаас 42%-ийн илүү үнээр хийгдсэний дараа ханш 15% хувиар өссөн.

ЗӨВЛӨМЖ 6: IPO-оос хэрхэн ашиг хүртэх вэ? Анхдагч зах зээлд гаргасан хувьцаанаас илүүг худалдан авах захиалга ирж байвал хоёрдогч зах зээлд илүүдэл эрэлт үүсч, энэ нь ханш өсөхөд нөлөөлдөг. Статистикаас харахад ахдагч зах зээлийн хугацаа 1-2 хоногт дуусвал хоёрдогч зах зээлийн эхний 1-3 хоногт өдөрт дунджаар 10 хувь өссөн статистик тооцоо бий. Өөрөөр хэлбэл, амжилттай IPO богино хугацааны ашиг хийх боломжийг олгодог.

Мэдээж хэрэг шинээр хувьцаа гаргаж буй компани болгосны ханш хоёрдогч зах зээлд өсөх албагүй. Энэ талаар дэлгэрүүлэн уншихыг хүсвэл “IPO ашигтай юу? Богино хугацаанд тоглох уу? Урт хугацаанд хөрөнгө оруулах уу?” сэдэвт нийтлэлийг уншаарай.

ЗӨВЛӨМЖ 7: Мэдээллийн нөлөөнөөс хэрхэн ашиг хүртэх вэ? Сүүлийн үед зах зээлд мэдээллийн нөлөө хүчтэй мэдрэгдэх тал ажиглагдаж эхэллээ. Мэдээ ханшид нөлөөлж эхэлж байгаа нь зах зээл хөгжиж байгаагийн тод илрэл юм. Жишээ нь, УБ-БҮК компани шинээ үйлдвэрээ ашиглалтанд оруулсан тухай мэдээлэл цацагдахад ханш 5 сарын хугацаанд 50 хувиар өссөн. Хай Би Ойл Хойд Солонгосын компанийг худалдан авсан тухай мэдээлэл цацагдсанаар оны эхнээс 88 хувиар ханш нь өссөн. Таван толгойн ХК-ийн нүүрсний нөөц нэмэгдэж, ирэх жилүүдэд тогтвортой борлуулалт хийхээр болсон нь ханшийг 3,700-аас 4,800 хүртэл өсөхөд нөлөөллөө. Цаашид зах зээл хөгжихийн хэрээр мэдээний ханшид нөлөөлөх нөлөө улам бүр нэмэгдэх болно.

ЗӨВЛӨМЖ 8: Арванхоёрдугаар сарын нөлөөлөөс хэрхэн ашиг хүртэх вэ?

Зах зээл хөгжихийн хэрээр хувьцаанд хөрөнгө оруулах дотоод, гадаадын сангуудын тоо өссөөр байна. FMG, AFC гэх мэт идэвхтэй ажиллаж буй сангуудыг дурдаж болох. Эдгээр сангийн хувьд жилийн эцсээр санхүүгийн тайлангаа гаргадаг бөгөөд ашиг, алдагдлаа үнэлдэг тул арван хоёрдугаар сарын эцсээр эзэмшиж буй хувьцааныхаа ханшийг өсгөх сонирхолтой байдаг. Ингэж бага алдагдалтай эсвэл илүү ашигтай тайлан баланс гаргах тал бий. Графикт нийт 2006-2013 оны TOP 20 индексийг жилээр харуулсан байна. 2011, 2012, 2013 онд буюу сүүлийн жилүүдэд оны эцэст тус индекс мэдэгдэхүйц өсөлттэй байгаа нь дээрх таамгийг дэвшүүлэхэд хүргэж байгаа юм. Зах зээл хөгжихийн хэрээр олон тооны сангууд ажиллаж эхлэх ба цаашид энэ төрлийн нөлөө нэмэгдэх болов уу гэж дүгнэж байна.

ЗӨВЛӨМЖ 9: Нэгдүгээр сарын нөлөөнөөс хэрхэн ашиг хүртэх вэ? Тогтмол, өндөр хувийн ногдол ашиг тараадаг компаниудын хувьцаанаас ногдол ашиг хүртэх зорилгоор хөрөнгө оруулагчид “бүртгэлийн өдөр”-өөс өмнө худалдан авч, эрэлт үүсгэн ханшийг өсгөдөг. “Бүртгэх өдрийн дараагийн өдрөөс хувьцааны ханш унадаг. Ингэж унахдаа ногдол ашгаас хүртэж буй өгөөжтэй тэнцүү хэмжээтэйгээр унана” гэж онолын хувьд тооцсон байдаг. Ямартай ч бүртгэх өдөр хүртэл хувьцааны ханш өсөх хандлагатай байдаг. ■

ТОП-20

ТОМ ТОГЛОГЧИЙН ЖИЖИГ ЭРСДЭЛ



Э.ТАМИР

ММС энэ бол “Энержи Ресурс” компанийн Хонконгийн биржид бүртгэгдсэн албан ёсны нэр. Одоогоос дөрвөн жилийн өмнө Mongolian mining corp буюу анх удаа Монголын гэх тодотголтой компанийн хувьцааг олон улсын хөрөнгийн биржид арилжсан түүхт өдөр тохиосон. Монголын компаниуд олон улсын зах зээлд гарах замыг нь зассан гэж хэлж болох уг компанийн хувьцаа өдгөө Монголын хөрөнгийн биржийн ТОП-20 эгнээнд зүй ёсоор багтдаг. Түүнчлэн манай улсаас БНХАУ-д нийлүүлдэг ▸▸

нүүрсний 42 хувийг дангаараа экспортолдог маш том компани юм.


ММС нь коксжих нүүрсний олборлогч ба экспортлогч. Мөн охин компаниараа дамжуулан нүүрсний тээвэр борлуулалтыг давхар гүйцэтгэдэг. 2009 оноос үйл ажиллагаагаа эхлүүлсэн тус компани өдгөө жилд 15 сая тонн нүүрс олборлох, угаах хүчин чадал бүхий шинэхэн үйлдвэртэй болсон. Тэр ч утгаараа ММС бол Монголын хамгийн том бөгөөд үйл ажиллагаагаа тогтвортой явуулдаг нүүрс экспортлогч компани юм. Цаашдаа ч тус компанийн үйл ажиллагаа тогтвортой байх төлөвтэй байна. Тухайлбал, Өнгөрсөн онд Монголын тал Хятадын “Шинхуа” компанитай ирэх 20 жилийн хугацаанд нэг тэрбум тонн нүүрс буюу жилд дунджаар 50 сая тонн нүүрс нийлүүлэх гэрээнд гарын үсэг зурсан. Мөн Тавантолгой болон Хятадын Ганц модны боомтыг холбосон төмөр зам барих санамж бичиг байгуулсан. Энэ хүрээнд ММС, “Эрдэнэс тавантолгой”, “Тавантолгой” ХК нүүрсээ Хятад руу тогтмол нийлүүлэх боломжтой болсон. Мөн тус компани өнгөрсөн оны долоодугаар сард нүүрс баяжуулах үйлдвэрийн гуравдугаар модулыг ашиглалтад оруулснаар компанийн өрсөлдөх чадвар нэмэгдсэн байна. *(Санхүүгийн үзүүлэлтийг графикаас харна уу.)*

Эрсдэл

Хэдийгээр тус компанийн борлуулалт сайн байгаа ч дэлхийн зах зээл дээрх коксжсон нүүрсний үнэ унасантай холбоотой орлогын үзүүлэлт нь хангалтгүй гарчээ. Одоогоор нүүрсний үнэ огцом унаж жилийн 28 хувийн уналттай байгаа. Байдал энэ хэвээрээ үргэлжилбэл тус компанийн өр төлбөрийн чадварт эрсдэл үүсч магадгүй. Тухайлбал, Хонконгийн хөрөнгийн биржид бүртгэлтэй “Mongolian Mining Corp”-ын зээлжих зэрэглэлийг “Moody’s” агентлаг бууруулсан тухай “Bloomberg” мэдээлжээ. Зэрэглэлийг нь нэг түвшнээр доошлуулж, Caa2 болгосон нь тус компани зээлээ эргэн төлөх боломжгүй байгаатай холбоотой гэсэн байна. Энэ нь өнгөрсөн оны эхний есөн сард Монголын нүүрсний экспорт 20 хувиар буурсан төдийгүй уг таваарын үнэ хямдарсан нь компаниудад сөргөөр нөлөөлж байгаатай шууд холбоотой. “Moody’s” агентлаг “2013 оны хоёрдугаар хагас болон 2014 онд уг компанийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл хангалттай хэмжээнд хүрэхгүй байж магадгүй” гэж мэдэгджээ. Бас “Ирэх 12 сарын хугацаанд хөрвөх чадвараа нэмэгдүүлэх хэд хэдэн арга хэмжээ авах боломжтой. Гэхдээ хувьцааны ханш доогуур байгаа, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ багассан зэрэг хүчин зүйл нөлөөлж болзошгүй” гэжээ.Тус компани энэ оны нэгдүгээр хагаст 25.2 сая ам.долларын алдагдал хүлээсэн гэх мэдээлэл байна. *(Балансын үзүүлэлтийг графикаас харна уу.)*

Хэдийгээр тус компанийн үнэлгээ буурсан ч тодорхой арга хэмжээг авч байгаа аж. Мөн ойрын үед нүүрсний зах зээл сэргэх хандлагатай байгаа нь дээрх санхүүгийн эрсдэл нь ММС-ийн үйл ажиллагаанд тийм ч том цохилт болохгүй байх гэсэн хүлээлттэй байна. *(Дэлгэрэнгүйг графикаас харна уу.)*
ММС-ийн ТУЗ-ын даргаар Ж.Оджаргал, Гүйцэтгэх захирлаар нь Г.Батцэнгэл нар ажилладаг. Хувьцаа эзэмшигчдийн хурлаа жил бүр тогтмол хийдэг. Мөн шаардлагатай үед хувьцаа эзэмшигчдийг хуралдаалдаг аж. “Энержи Ресурс” ХХК нь Монголын Компанийн засаглалыг хөгжүүлэх төвийн гишүүн учраас компанийн нийгмийн хариуцлагын тал дээр ихээхэн анхаардаг байна. Мөн Олон улсын санхүүгийн корпорацитай компанийн засаглал болон нийгмийн хариуцлагын тал дээр хамтран ажилладаг. Тиймээс тус компанид итгэх хөрөнгө оруулагчдын итгэл өндөр байдаг аж. ■


Зардлын үзүүлэлтүүд (сая ам.доллараар)



Зардлын таналтыг амжилттай хийж байгаа нь компанийн алдагдлыг бууруулж байна

Эх сурвалж: Компанийн жилийн ба хагас жилийн тайлан

Орлогийн тайлангийн үзүүлэлтүүд, жилээр (сая ам.доллар)



Борлуулалт өсөлттэй байгаа ч үнэ буурч буй нь орлогын өсөлтийг хязгаарлаж байна

Эх сурвалж: Компанийн жилийн ба хагас жилийн тайлан

Балансын үзүүлэлт (сая ам.доллар)



Өр хөрөнгийн харьцаа өссөөр байгаа нь төлбөр чадварын эрсдэлийг нэмэгдүүлж байна

Эх сурвалж: Компанийн жилийн ба хагас жилийн тайлан



- Офсет хэвлэл
- Хулдаасан хэвлэл
- Фото хэвлэл
- Хаяг реклам
- Тугны хэвлэл
- Бэлэг дурсгал
- Тайз карказ түрээс
- Замын тэмдэг
- Жаазны үйлдвэр

ЮНИПРЕСС

ХЭВЛЭЛИЙН КОМПАНИ

Одоо хэвлэхэд хялбар боллоо

Утас: 70009009, 70109009
Факс: 70109009
Вэб: www.unipress.mn
И-мэйл: uni_vision2002@yahoo.com
https://www.facebook.com/unipressprinting

“MONGOLIAN ECONOMY” СЭТГҮҮЛИЙН ТВ ХУВИЛБАР



Манай сэтгүүлийн үнэнч уншигч та бидний уран бүтээлийг телевизээр үзэх боломжтой боллоо.
“Economy” ТВ студи улс оронд тулгарсан бүхий л асуудал, иргэн, бизнесмэнийг эмзэглүүлсэн аливаа сэдвийг цуврал нэвтрүүлэгтээ шууд хөндөн, шууд нэвтрүүлнэ. Бид Чандмань эрдэнэ болсон ус, алтаар жишигдэх нүүрсний салбарт анхаарал хандуулж “Ус ирж байна”, “Хар алтны эрин” нэвтрүүлгүүдээ хүргэх гэж байна.

“УС ИРЖ БАЙНА” нэвтрүүлэг
Гарах телевиз: NTV
Гарах өдөр: 2014.11.18 Мягмар гариг
Гарах цаг: 21:50

“ХАР АЛТНЫ ЭРИН” нэвтрүүлэг
Гарах телевиз: NTV
Гарах өдөр: 2014.11.25 Мягмар гариг
Гарах цаг: 21:50

Уншигчдийн маань мэргэн дүгнэлт, үзэгчдийн минь онч үгс бидний бүтээлд том дэм болох билээ.

ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ

МЭДЛЭГ, ТЕХНОЛОГИЙН НУТАГШУУЛАЛТ

Аливаа улс орны хөгжлийг илтгэх томоохон үзүүлэлтүүдийн нэг бол хөдөлмөр эрхлэлт байдаг. Монгол Улсын хувьд эрдэс баялгийн салбарыг даган шинэ зах зээл, бизнесийн талбар бий болж, хөрөнгө оруулалт нэмэгдэн, эдийн засгийн өсөлт хоёр оронтой тоо руу орж байгаа ч хөдөлмөр эрхлэлт өсч, ажилгүйдлийн тоо буурсан зүйл үгүй. Тиймээс хөдөлмөрийн зах зээлийг хөгжүүлэх зорилгоор Хөдөлмөрийн төв биржийн захиалгаар "IT Zone" компани "Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн систем"-ийг бий болгох төслийг хэрэгжүүлээд байна. Энэхүү төслийн талаар Хөдөлмөрийн төв биржийн дэд дарга Д.Баттогтох, "IT Zone" компанийн Программ хангамжийн газрын дарга С.Хишигбаатар нартай ярилцсан юм.



Д.Баттогтох



С.Хишигбаатар

Хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн байдал болоод төслийг хэрэгжүүлэх болсон шалтгаан чухам юу байв?

Д.Баттогтох: -Шинэчлэлийн Засгийн газраас Хөдөлмөрийн яамыг бий болгоод багагүй хугацаа өнгөрч байна. Тус яам нь хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой бодлогыг хэрэгжүүлж, тэрхүү бодлогын хүрээнд Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийг баланслуулах юм. Энэ нь нэг талаас ажил олгогчийн шаардлагыг хангасан ур чадвартай мэргэжилтэнг бэлтгэн нийлүүлэх, нөгөө талаас ажил олгогч нарт шинэ ажлын байр бий болгох нөхцөлийг дэмжин Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийг тэлж ажиллах юм. Гэсэн хэдий ч өнөөг хүртэл ажил хайгч, ажил олгогчийн хооронд мэдээлэл чөлөөтэй солилцож чаддаггүй, боловсролын тогтолцоо хөдөлмөр эрхлэлттэйгээ уялддаггүй, хөдөлмөрийн зах зээлийн бодит эрэлт хэрэгцээнд тохирсон мэргэжилтэн, ажилтнууд шаардлагатай тоогоор бэлтгэгддэггүй зэргээс болж олон залуус ажил эрхлэх боломжоо алддаг. Энэ мэт олон дутагдалтай асуудлууд өмнөх онуудад явсаар ирсэн билээ. Тиймээс юун түрүүнд бид иргэн, ажил олгогч шууд холбогдох дэд бүтцийг бий болгохыг зорьж ажилласан. Тэгэхээр энэ асуудлыг шийдэх өнөөдрийн гарц бол мэдээлэл технологид суурилсан дэд бүтэц бий болгох өөрөөр хэлбэл, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн системийг шийдэх явдал юм. Бид өнөөдрийн байдлаар Хөдөлмөрийн яамны харьяа байгууллагууд болох Хөдөлмөрийн төв бирж, Хөдөлмөр эрхлэлт үйлчилгээний төв, Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, Хөдөлмөрийн аюулгүй байдал, өвчин судлалын төв болон бүх аймаг дүүргүүдийн хөдөлмөрийн хэлтсүүдийг дотоод VPN сүлжээнд холбоод байна. Үүгээр бид Хөдөлмөрийн зах зээллийн мэдээллийг хоорондоо шуурхай, өндөр нууцлалтайгаар солилцох боломжтой болсон. Тус төслийн хүрээнд иргэн, ажил олгогч нар цахим орчинд уулзах цахим программ хангамжийг бид мөн хөгжүүлэн ажиллаж байгаа. Төсөлд гүйцэтгэгч талаас ITZone компани ажиллаж байгаа ба энэ нь үндэсний бүтээн байгуулалтад төр хувийн хэвшилтэй хамтран хийж байгаа бас нэгэн томоохон ажил юм.

"Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн систем" төслийн программ хангамжийн талаар тодруулахгүй юу?

С.Хишигбаатар: Хөдөлмөрийн яам, Хөдөлмөрийн төв бирж, Хөдөлмөр эрхлэлт үйлчилгээний төв, Хөдөлмөрийн аюулгүй байдал өвчин судлалын төв зэрэг байгууллагуудыг хамарч байгаа энэхүү төсөл нь программ хангамж, техөөрөмжийн нийлүүлэлт, дэд бүтэц болон сүлжээ байгуулах гэсэн үндсэн гурван хэсгээс бүрдэнэ. Хугацааны хувьд уг төслийг 2013 оны нэгдүгээр сарын 1-нээс эхлэн хэрэгжүүлж эхэлсэн ба өнгөрсөн аравдугаар сарын сүүлээр бид системээ амжилттай хүлээлгэж өгсөн байгаа. Тодруулбал хөдөлмөрийн яамны харъяа байгууллагуудын ажилтнууд ашигладаг үндсэн программ, гадаад хэрэглэгчдэд зориулсан портал вэб сайт болон киоск буюу "Электрон бирж"-ийн программ гэзд үндсэн гурван программ хангамж хийгдлээ.

"Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн систем" программын хувьд front-tend буюу хэрэглэгчтэй харьцах үндсэн найман модуль, backend портал сайтыг тус тус хүлээлгэж өгсөн байгаа. Frontend систем-ээр Улаанбаатар хотын есөн дүүрэг болон 21 аймгийн Хөдөлмөрийн төв биржийн ажилтнуудын өдөр тутмын үйл

ажиллагааг системчилсэн бөгөөд Улсын бүртгэлийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын газартай мэдээллээ мөн солилцоно.

-Олон нийтэд зориулсан портал вэб сайтын талаар дэлгэрэнгүй сонирхуулахгүй юу?

-Backend систем нь олон нийтэд зориулсан портал вэб сайт ба ажил олгогч, ажил хайгч, ажлын байрны анкет, ажлын зарын мэдээллийг бүртгэх, удирдах үйл ажиллагаатай. Уг систем нь гаднын болон дотоодын хөдөлмөр зуучлалын үйл ажиллагааг удирдан зохицуулах боломжийг олгох юм. Мөн гэрээний үндсэн модулиас гадна “Электрон бирж” буюу киоскийн программ хангамж, өвчин судлал гэсэн хоёр модулийг 2014 оны эхний сард хүлээлгэн өгөхөөр ажилласан. Програм хангамж, системийн архитектурын хувьд олон улсын стандартад нийцсэн, орчин үеийн технологи, ололт дэвшлийг ашиглаж хийсэн. Тухайлбал, Өгөгдлийн сангийн удирдах систем database-ийн хувьд дэлхийд мэдээллийн технологиороо дээгүүрт ордог Oracle компанийн бүтээгдэхүүн JAVA програмчлалыг ашиглан манай инженерүүд системийг нэвтрүүлсэн бол Microsoft компанийн технологийг ашиглаж “Электрон бирж” буюу киоскийн программ хангамжийг бичиж байна. Бид захиалагчийнхаа шаардлагыг ойлгон, түүнд нийцсэн програм хангамжийг хэрэгжүүлэхийн тулд Хөдөлмөрийн төв биржийн ажлын хэсэг болон ITZone компанийн программ хангамжийн газрааснийт 40 гаруй удаагийн уулзалтыг зохион байгуулсан. Энэхүү төсөлд нийт 26 төрлийн 2500 гаруй тоног төхөөрөмжийг нийлүүлэн, Монгол Улсын 21 аймаг, есөн дүүргийг холбосон интернэт, VPN сүлжээний ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд ажил хайгч болон ажил олгогчийг холбосон хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн сүлжээг амжилттай бий болгож, улс орныхоо бүтээн байгуулалтад хувь нэмрээ оруулж байгаадаа баяртай байна.

Энэхүү шинэ системийг цаашид ашиглан, үйл ажиллагаагаа удирдан авч явахад Хөдөлмөрийн төв биржийн ажилтнуудад тодорхой сургалт болон чиглэлүүдийг ITZone компанийн зүгээс өгөх байх. Энэ тал дээр та бүхэн хэр анхаардаг вэ?

С.Хишигбаатар: Программ хангамж нь шууд хүлээлгэн өгдөг бүтээгдэхүүн биш бөгөөд хүлээлгэн өгөх олон улсын стандарт дараалалтай байдаг. Үүнд:
- Анализ буюу хэрэглэгчийн хүсэлтийг тодорхойлох
- Дэлгэцийн зохиомж, дизайныг гаргах
- Програмчлалын кодыг бичих үе
- Тест буюу зүгшрүүлэлт
- Сургалт

Бид Хөдөлмөрийн яамны нийт 200 гаруй ажилтанд энэхүү системийг танилцуулах сургалт, системийг цаашид авч явах админ буюу Хөдөлмөрийн төв биржийн IT хэлтсийн ажиллагсдад системийг хүлээлгэж өгөх сургалтуудыг тус тус зохион байгуулсан. Мөн Oracle компанийн олон улсын стандарттай, сертификат бүхий албан ёсны сургалтыг энэ онд зохион байгуулахаар бэлэн болоод байна. Манай компанийн хувьд аливаа төслийг хэрэгжүүлэхдээ тухайн байгууллагын ажиллагсдад системээ бүрэн хүлээлгэн өгч, сургалтад хамруулахаас гадна хүлээлгэн өгсний дараа Support, Maintenance -ийн гэрээг 2-3 жилийн хугацаатайгаар хийн, системийн найдвартай ажиллагааг хангаж ажилладаг юм.

Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлд энэхүү систем нэвтэрснээр ямар үр өгөөж, боломжийг бидэнд олгох вэ?

Д.Баттогтох: Олон давуу тал ач холбогдолтой. Тухайлбал, өнөөдөр Монгол улсын хэмжээнд 21 аймаг, есөн дүүргийн нийт 30 хөдөлмөрийн хэлтэс, мөн тийм тооны Хөдөлмөрийн хувийн бирж үйл ажиллагаагаа явуулж байна. Тэдгээрээс ирж байгаа бүхий л мэдээлэл Хөдөлмөрийн төв биржийн сервер дээр нэгтгэгдэнэ. Тэрхүү мэдээллийг 21 аймгийн төв, 142 сум, 132 хорооны хөдөлмөрийн хэлтэс дээр байрлуулж байгаа “Электрон бирж”-ээр долоон минут тутмын шинэчлэлтэйгээр иргэд мэдээлэл авах боломжтой болж байгаа юм. Өөрөөр хэлбэл Монгол Улсын хэмжээнд зарлагдсан ажлын байрны мэдээллийг танил талаараа дамжуулан олж авах биш хүнд суртал, ямар нэгэн саад бэрхшээлгүйгээр авах боломжийг “Электрон бирж” танд олгоно. Тухайн ажил хайж буй иргэн компьютергүй, унаагүй мөнгөгүй байж болох ч таны ойр байгаа “Электрон бирж”-ийг ашиглан идэвхтэй байгаа ажлын байрны мэдээллийг авах, дээр нь регистр, утасны дугаар, шаардлагатай мэдээллээ илгээж нэмэлт үйлчилгээ авах боломжтой болж байгаа юм. Мөн бидний бий болгож буй Web буюу интернэт орчинд ажиллах программ хангамжийг ашиглан ажлын байр, ажиллах хүчний мэдээллийг тухайн цаг минут секунд тутамд шинэчлэгдсэн байдлаар авах боломжийг мөн танд олгож байгаа. Өөрөөр хэлбэл, тус программ нь боловсрол, цалин, мэргэжил, туршлага, нас, хүйс зэрэг үндсэн үнэлгээний найман үзүүлэлтийг автоматаар боловсруулалт тохируулалт хийн, танд тохирох ажлын байр, ажиллах хүчнийг санал болгох юм.

С.Хишигбаатар: Ерөнхийлөгчийн санаачилсан “Том төрөөс ухаалаг төр рүү” уриалгыг бид Засгийн газар данхайсан том бүтцээ больж, цахим хэлбэрт шилжихээр болсон гэж ойлгож байгаа. Хөдөлмөрийн төв бирж дээр хэрэгжүүлсэн энэхүү төсөл нь ч Ерөнхийлөгчийн дээрх мэдэгдэлтэй нийцэж байгаа юм. Цахим систем нь илүү ухаалаг, түргэн шуурхай, мэдээллийн ил тод, нууцлалын өндөр хамгаалалтаар иргэн бүрт хүрч үйлчлэх боломжийг бүрдүүлнэ.

Олон улсын хөдөлмөрийн зах зээлд энэхүү систем болоод “Электрон бирж” нь хэр танигдсан бэ?

Д.Баттогтох: Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн системийг олон улс нэвтрүүлсэн байдаг. Энэ нь үр дүнгээ өгсөөр байгаа. Тухайлбал, Өмнөд Солонгос, Америк, Герман, Япон гээд олон орныг дурьдаж болно. Манай Хөдөлмөрийн төв бирж “Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн систем” төслийн хүрээнд Өмнөд Солонгосын “Korean employment information service” мөн Германы хөдөлмөрийн байгууллагуудтай туршлага солилцон ажилладаг. Тиймээс ч бид мэдлэг, технологи нутагшуулах замаар Германаас “Электрон бирж”-ийн санааг авч тус системийг нэвтрүүлж байна. Эдгээр аргачлал, систем бүгд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, үр ашигтай шийдлүүд юм. ■

БИЗНЕС ЗӨВЛӨГӨӨ

ЗӨВХӨН ХЭРЭГЦЭЭТЭЙГ НЬ ХИЙ

Сайн бизнес нь сайхан санаанаас эхэлдэг. Харин бизнес санаа гэдэг нь таны хийхийг зорьж буй бизнесийн товч, тодорхой тодорхойлолт юм. Таны бизнесийн санаа юу ч байж болно. Мөн хаанаас ч төрж болдог аж. Ихэнхдээ эргэн тойронд чинь байгаа хангагдаагүй хэрэгцээнээс төрдөг. Хэрэгцээ гарч л байгаа бол түүнийг бизнес болгоход амархан гэдэг. Энэ нь “Залуу минь хийж чаддаг зүйлээ биш хэрэгцээтэй зүйлийг л хий тэгвэл тэр жинхэнэ бизнес” гэх бизнесмэнүүдийн танд хэлдэггүй нэг нууц юм. Гэхдээ нөгөө талдаа бизнес санаа төрөх өөр нэг чухал хүчин зүйл бол таны ашиглагдахгүй байгаа нөөц ур чадвараас буюу өөрт байгаа нөөц бололцоогоо ашиглаад бизнес хийж болно. Тухайлбал, олон жил үслэг эдлэлийн үйлдвэрт ажилласан туршлагатай хүн байлаа гэж бодоход энэ чиглэлээрээ бизнес явуулж болох юм. Бизнес санаа төрөх гурав дахь хүчин зүйл бол хүмүүсийн шинэ хэрэглээ, орчин нөхцөлөөс хамаарч өөр дадал зуршил, шинээр үүссэн хэрэгцээг хангах байдаг аж. Тухайлбал, ухаалаг утсанд зориулсан аплейкэйшн, компьютерийн зөвлөгөө өгөх үйлчилгээ гэдэг ч юм уу. Магадгүй утаатай Улаанбаатарт утаанаас хамгаалах амны хаалт зарах гэх мэт байж болно. Товчхондоо эдгээр хүчин зүйлийг соргогоор мэдэрч чадвал бизнес санааг хаанаас л бол хаанаас олж болох ажээ. Гэхдээ та бизнесээ эхлэхийн өмнө эрхлэхийг зорьж буй бизнесийнхээ төрлийн талаар маш тодорхой төсөөлөлтэй, эсэхээ магадлах хэрэгтэй. Амжилттай яваа бизнес худалдан авагчдын хэрэгцээг хангахын зэрэгцээ таны хувийн горьдлого, найдварыг биелүүлж байх ёстой. Өөрөөр хэлбэл, таны бизнес хүмүүст хэрэгцээтэй байх хэрэгтэй гэсэн үг. Энэ нь тэдний хүсч байгаа зүйлсийг нь тэдэнд тохирсон болон тэдний төлөхөд бэлэн байгаа үнээр нь худалддаг. Мөн шинээр эхлэх гэж байгаа бизнес танд хүрэлцээтэй ашиг болон сэтгэлийн ханамж өгдөг байх ёстой. Ийм учраас танд болон таны худалдан авагчдад хүрэлцээтэй ашигтай байж чадахуйц сайн бизнес санааг тодорхойлж, хөгжүүлэх хэрэгтэй болдог. Үүний тулд та тэдгээрийг сайтар тодорхойлон бичих ба өөрийн хамгийн сайн бизнес санаануудаа тус бүрд нь нягтлан шалгаад үз. Та хэрвээ өөрийн бизнес санаагаа олчихсон бол дараах юуг, хэнд, яаж гэсэн асуултад хариулаад үзээрэй.

Юуг

Таны хариулах ёстой асуулт бол “Таны бизнес ямар бараа ба үйлчилгээг худалдах гэж байна вэ”. Бодож олсон бизнес, борлуулж чадах бараа бүтээгдэхүүн нь тухайн бизнес эрхлэгчийн үзүүлж чадах үйлчилгээнээс үүдэлтэй байх ёстой. Мөн түүнчлэн хүмүүс төлбөр төлж авахад бэлэн тийм бараа буюу үйлчилгээ байх нь чухал. Бараа гэдэг бол таны өөрөө үйлдвэрлэж байгаа зүйлс буюу эргүүлэн зарахын тулд авч байгаа бүтээгдэхүүн юм. Жишээлбэл, багаж, жигнэмэг, хувцас гэх мэт. Үйлчилгээ гэдэг бол та хүмүүст зориулан хийж, тэд танд төлбөр өгдөг тийм зүйлс байдаг. Жишээлбэл, жижгэвтэр ресторан эзэмших, бараа хүргэж өгөх үйлчилгээ, интернэт кафе, засвар үйлчилгээ гэх зэрэг.

Хэнд

Энэ бизнесийн худалдан авагч нь хэн байх вэ. Эцсийн дүндээ энэ бараа, үйлчилгээг хэн худалдан авах вэ. Таны татаж чадах тэр худалдан авагчид л танд мөнгө оруулах болно. Та тодорхой нэг бүлэг худалдан авагчдад уу, аль эсвэл өөрийнхөө дүүргийн бүх оршин суугчдад худалдахыг хүсч байна уу гэдгээ эхлээд тогтоо. Аливаа бизнес ашиг авч ирэхийн тулд таны бараа, үйлчилгээнд төлбөр хийж худалдан авахад бэлэн болон хүсч байгаа хүний тоо хүрэлцээтэй их байх ёстой. Та ямар нэг зүйл үйлдвэрлэж эхлэхээсээ өмнө өөрийн бүтээгдэхүүнээ ямар худалдан авагчидад худалдах гэж буйгаа нарийвчлан тодорхойлох нь чухал.

Яаж

Бараа, үйлчилгээг хэрхэн яаж худалдах вэ. Хэрэв та дэлгүүр нээх гэж байгаа бол яаж гэдэг асуулт тодорхой. Та бараа бүтээгдэхүүн борлуулна. Харин үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах гэж буй бол борлуулалтын маш олон төрлийн аргуудыг хэрэгжүүлэх шаардлагатай болдог. Иймд яаж гэсэн асуултад маш тодорхой хариулах хэрэгтэй. Эдгээр асуултад хариулахаас гадна та доорх хүснэгтийг бөглөөд үзээрэй. Энэ нь таны бизнес ашигтай эсэхийг харуулах бяцхан судалгаа юм.

Бизнес гэдэг хүмүүс бидний хүсэл сонирхол, хэрэгцээнээс үүдэлтэй байхын зэрэгцээ заримдаа этгээд хачин зүйл ч сая саяын ашиг цуглуулж болдог аж. Доорх 10 гайхмаар бизнес санаа нь мөн л бидний сонирхолтой хэрэгцээнээс үүдэлтэй. Эдгээр 10 бизнесийн санааг гаргасан »

эрхэмүүд бүгд нэг сая давсан ам.долларын ашигтай ажиллаж чадсан байх юм.

10. Зөвхөн танай хайртай муужгайнд зориулсан суултуур

9. Ажилгаа амарцгаая - Энэхүү бизнес нь хөдөө янз бүрийн аж ахуйд ажлангаа амрах сонирхолтой амралтыг хүмүүст санал болгожээ.

8. Пластик цацагт хяруулын яс - Барууныхны хамгийн өргөн дэлгэр тэмдэглэдэг Талархлын баярын гол зоог болох цацагт хяруулын эрэлт баярын өдрүүдэд эрс нэмэгддэг. Тэгвэл пластик цацагт хяруулын ясыг хүмүүс худалдан аваад хүслээ шивнэн, баяраа тэмдэглэх боломжтой болсон байна.

7. Болзох цахим хуудас - хэдийгээр хэн нэгэнтэй харилцаатай ч шинэ харилцааг эрэлхийлж байгаа хүмүүст зориулсан тусгай вэб сайт. Бас л муугүй ашиг олсон байна.

6. Эмчийн магадлагааг онлайнаар - Ажилдаа явахыг хүсээгүй, хааяа нэг чөлөө авчихаар үе гарах үед эмчийн магадлагааг утсаар болон онлайнаар захиалаад л авчих боломж бий.

5. 100 ам.долларын сурталчилгаа - Сурталчилгааг хэмжээгээр нь зардаг вэб сайт. 100 ам.доллар төлөөд өөрийн сурталчилгааны орон зайг худалдан авах боломжтой.

4. Сантаагийн захидал - Энэхүү компанийн ажил тун энгийн. Хүүхдүүдэд хойд туйлд амьдрах завгүй санта өвөөгийн нэрийн өмнөөс захидал бичих.

3. Диваажинд захиалга өгөх - Хамгийн сонирхолтой нь диваажинд захиалга өгөх нь оргүй хоосон зүйл авч энэхүү бизнес нь хүмүүсийн сонирхлыг татаж чадсан байна. Хүмүүс диваажинд вэб сайтаар захиалгаа өгөх бөгөөд нэг захиалга 13 орчим ам.долларын үнэтэй.

2. Нохойнд зориулсан нүдний шил - Таны нохой ч дэгжин харагдаж болно.

1. Чулуун урлал - Чулууг янз бүрээр чимэглэн хийсэн бэлэг дурсгалын зүйлс

Эх сурвалж: Хөгжлийн шийдэл ТББ, BIZGUIDE мэдээллийн сан. ■

ТЕХНОЛОГИ

ХАМГИЙН ЧУХАЛ 10 НЭЭЛТ

Б.БЯМБАДОРЖ

Хүмүүс түүхэндээ өөрсдийн амьдралыг сайжруулах зорилгоор маш олон зүйл сэдсэн байдаг. Зарим нь тэдний амьдралыг бүрмөсөн өөрчилж чадсан. Харин зарим нэг нь амьдралыг өөрчлөөд зогсохгүй, маш олон боломжийг нээж өгдөг.

Дугуй



Хүмүүс МЭӨ 3,500 –гаад онд дугуйг нээх хүртлээ ч явгаар хол зам туулах боломжгүй байв. Мөн их хэмжээний ачаа тээх чадваргүй байжээ. Харин дугуйтай хавтан дээр эд хогшлоо тавьж зөөдөг болсноос хойш нүүдлээ их хялбар болгожээ. Түүнчлэн нэг нүүхдээ харьцангуй хол явах боломж олсон байна.

Хадаас



Хэдийгээр энгийн мэт санагдавч хадаасгүйгээр бид соёл иргэншлийг төсөөлж чадахгүй. Түүнийг хоёр мянга гаруй жилийн өмнө эртний ромд бий болгожээ. Харин өмнө нь хүмүүс байшин барихдаа нарийн зүссэн модыг нийлүүлж ашиглаж байсан. Тэр нь барилгачдын хувьд их хүндрэлтэй байж.

Харин арай “чанартай” гэхдээ модонд шургуулахад бас “хэцүү” шураг гэгч зүйлийг МЭӨ III зуунд Грекийн эрдэмтэн Архимед анх бүтээсэн гэж үздэг.

Луужин




Хүмүүс дугуйтай тэрэг ашиглан их хэмжээний мод, бараа зэргийг хүссэн газартаа зөөж хүргэдэг болсон. Мөн хадаас шураг ашиглаж усан онгоц хийдэг болов. Хэдий ийм ч тэд далайд аялахдаа тэнгэрт буй оддын байршлаар зүг чигээ олдог нь нэгэн сул тал байж. Ийм учир ▸▸

нартай өдөр, эсвэл шөнө үүлтэйд далайд аялах нь эрсдэлтэй байв.
Харин IX-XI зууны үед Хятадад дэлхийн хамгийн анхны соронзжуулсан төмөртэй луужин бий болсон. Түүгээр хүмүүс зүг чигээ өдөр шөнө ялгалгүй л хэмжих болов. Энэхүү шинэ нээлт нь удалгүй Европ, Арабын орнуудад дэлгэрсэн байна.

Мөн үүний тусламжтайгаар хүмүүс дэлхий дээр байгаа олон шинэ газруудыг (тухайлбал Америк тивийг) нээсэн юм.

Хэвлэх машин



Герман дархан Иоган Гутенберг 1440 онд анхны хэвлэх машиныг бүтээжээ. Ямар нэг бичсэн бүтээлийг хуулах хугацааг олон дахин багасгав. Хүмүүсийн дунд мэдээлэл маш хурдтай тархаж эхлэв. 1500 он гэхэд баруун Европт 20 сая ном хэвлэгдсэн байна. Шинэ хэвлэх машин нь тухайн үеийн хамгийн том шашин болох Христийн ном библийг их хэмжээгээр хувилах боломж олгосон. Үүний дүнд библийн олон янзын урсгал тархаж, шинэ шашин шүтлэгүүд дэлгэрч эхэлжээ. Тэдний нэг нь Мартин Лютерийн протестант урсгал байсан юм.

Ган



Эртний хүмүүс олон янзын металл хэрэглэдэг байв. Хүрэл, төмөр зэргийг зэвсэг болгон хэрэглэдэг байсан. Харин XIX зууны үед ганг өргөн хүрээнд тухайлбал барилга, тоног төхөөрөмжид хэрэглэж эхэлснээр аж үйлдвэрийн хувьсгал эхэлжээ.

Эхэндээ зэс зэвсэг хэрэглэдэг байсан хүмүүс удалгүй хүрэл хэрэглэдэг болжээ. Харин 6000 жилийн тэртээ хар тугалга, зэс хоёрыг зарим нэг өнгөтэй чулуутай холиход илүү чанартай хүрэл гардаг гэдгийг мэдэв. Үүнийг хайлш гэдгийг тухайн үед мэдээгүй. Энэ аргаар төмрийн хүдэр хайлж ган гаргаж авчээ.

Уурын хөдөлгүүр




Уурын хөдөлгүүрээс өмнө бүх зүйлс бараг биеийн хүчээр хийгдэж байв. Гол горхины урсгалын хүч, эсвэл салхины хүчээр ажилладаг газрууд нь тухайн үеийн аж үйлдвэрийн хамгийн дээд дэвшилтэт технологи байв.
Хүн төрөлхтний хамгийн богино хугацаанд хамгийн их дэвшилт гаргасан XIX зууны аж үйлдвэрийн хувьсгалд уурын хөдөлгүүрийн хэрэглээ тэргүүлсэн юм.

Уурын хүчийг хэрэглэж машиныг ажиллуулах санаа он удаан жил хүмүүсийн тархинд байсан. Гэсэн ч 1712 оны Томас Ньюкомений загвар нь уурын хүчийг зохистой ашиглаж чадсан анхны хөдөлгүүр болсон. Харин 1769 онд Жэймс Уотт Ньюкомений загвар дээр өөрчлөлт хийж, уурын хөдөлгүүрийн үр ашгийг нэмэгдүүлэн практикт хэрэглэхэд хялбар болгожээ. Иймээс Жэймс Уотт уурын хөдөлгүүрийг “нээсэн” хүн гэж түүхэнд тэмдэглэгдсэн юм.

Өнөөдөр уурын ихэнх хөдөлгүүрийг цахилгаан ба дотоод шаталттай хөдөлгүүрүүд хэрэглээний хувьд давамгайлсан. Гэхдээ уурын хөдөлгүүр нь хүмүүсийн хамгийн чухал нээлтүүдийн нэг хэвээр. Өнөөдөр ч уурын хүчийг өдөр тутам ашигладаг улс цөөнгүй бий.

Чийдэн



Зөвхөн байгалийн гэрэлтэй үед хүмүүсийн ажлын цаг хязгаарлагддаг байсан. Харин чийдэн нь биднийг шөнө ажиллах боломж олгосноороо томоохон өөрчлөлт авчирсан юм. Түүхчдийн хувьд XIX зуунд 20 гаруй хүн чийдэнг бүтээхэд хувь нэмэр оруулсан гэдэг. Гэсэн ч Томас Эдисон хамгийн анхны бүрэн, урт удаан ажилладаг чийдэнг хийсэн учир түүнийг чийдэнг бүтээгч гэж үздэг.

Пенициллин



Үүнийг эм зүйн хамгийн чухал нээлт гэж зарим нь нэрлэдэг. 1928 онд Шотланд эрдэмтэн Александр Флеминг санамсаргүйгээр пенициллинийг нээжээ. Түүний лаборатори дахь дээжийг ногоон мөөгөнцөр хүрээлсэн байсныг харсан аж. Сонирхолтой нь мөөгөнцөрт хүрсэн бүх бактери, халдварууд устсан байхыг тэрбээр ажигласан байна.

Хэдэн жил өнгөрөхөд Флеминг мөөгөнцрийг цэвэршүүлж, пенециллиум хэмээх хөгцийг ялгаж авч шинэ эм бүтээжээ. Энэ нь биед байгаа халдварыг хүнийг өөрийг нь гэмтээлгүйгээр устгадаг үйлчилгээтэй юм. Дэлхийн I дайнд шархтай цэргүүдийн тал хувь нь халдвараас болж нас барсан. Энэ нь пенициллин байгаагүйгээс болсон юм. Харин дэлхийн II дайнд ийм хэмжээний халдвараас шалтгаалсан үхэл гараагүй ажээ.

Компьютер



Компьютер нь товчхондоо ямар нэг мэдээллийг аваад, боловсруулалт хийж өөр шинэ мэдээлэл гаргах чадвартай бүтээл юм. Энэ нь хүн төрөлхтний хувьд маш чухал үүрэг гүйцэтгэж байна. Бидний амьдралын өдөр тутмын ажил компьютертэй нягт холбоотой. Жишээлбэл, бараа худалдан авалт, машин, интернэт, гар утас, зураг гэх мэт.

Компьютерийг бүтээхэд олон хүн оролцсон учир яг хэн нь бүтээсэн бэ гэдэгт хариулахад хэцүү. Харин Английн математикч Алан Тюрингийг компьютерийн ертөнцөд хамгийн их нөлөө үзүүлсэн хүн гэж үздэг.

Цахилгаан холбоо



Телеграф, радио, зураг, интернэт бүгдийг нь нэг нээлт гэж нэрлэх зүй ёсгүй санагдана. Ерөнхийдөө цахилгаан холбоо нь дэлхийг “жижигхэн” болгосон их үүрэгтэй. Урьд өмнө нь дэлхийн хаа нэг газар чухал үйл явдал өрнөхөд үүний тухай мэдээ дэлхийн нөгөө өнцөгт хэд хэдэн долоо хоногийн дараа хүрдэг.. Харин өнөөдөр секундын хугацаагаар л хэмжигдэж буй.

Сэм Морз 1836 онд телеграфийн системийг анх бүтээж, удалгүй хүмүүсийн яриаг холын зайнд шууд сонсох арга нээгдэв. Утасгүй харилцан холбоо XX зууны сүүл үеэр эрчимтэй хөгжиж эхэлсэн. Эцэст нь интернет бий болжээ. Өнөөдөр интернэтийн тусламжтайгаар дэлхий тэр чигээрээ маш том тархи болж хувирсан юм. ■